



Ministry of the Environment

Япон улсын Байгаль орчны яам



Дэлхийн байгаль орчны  
стратегийн хүрээлэн

# ЦХМ-ЫН

# ◆ТОЙМ

Хувилбар 5.0  
2008 оны 2-р сар



Зүүн Хойд Азийн Эдийн засгийн  
судалгааны хүрээлэн



ГЗ.37-ын үр дүнд үндэслэн шинэчлэв.

# Южи МИЗУНО

Дэлхийн байгаль орчны стратегийн хүрээлэн (IGES)-гийн  
ЦХМ хөтөлбөрийн удирдагч, ахлах мэргэжилтэн

Цэвэр хөгжлийн механизмын (ЦХМ) талаар бүрэн гүйцэд, ойлгоход хялбар тайлбар өгөх нь энэхүү товхимолын зорилго болно. Тус товхимолд улс хоорондын хэлэлцээрүүдээр тохирсон баримт, бичвэрүүдийн агуулгыг бүрэн хэмжээнд тусгаагүй болохыг тэмдэглэх нь зүйтэй. Түүнчлэн, зарим ойлголтын дэлгэрэнгүй тайлбар болон үйл явцын талаар улс хоорондын хэлэлцээрүүдээр эцэслэн шийдвэрлэгдээгүй хэвээр байна. Холбогдох баримт, бичгүүдийн дэлгэрэнгүй агуулга, тодорхойлолтуудын талаар Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын суурь конвенцийн вэб хуудсанд хандана уу. <http://unfccc.int/>  
Энэхүү товхимолд тусгагдсан мэдээлэл нь хэвлэгдэх үеийн байдлаар үнэн, бодитой боловч зохиогч болон хэвлэгчийн аль аль нь энд хийгдсэн байж болзошгүй алдаа, орхигдсон зүйлийн төлөө хуулийн хариуцлага, ямарваа үүрэг хүлээхгүй болно. Товхимолтой холбоотой хүсэлт, саналыг [cdm-info@iges.or.jp](mailto:cdm-info@iges.or.jp) хаягаар илгээнэ үү.

Орчуулгын баг: Хувилбар 1- Ч.Ариунсан (ИХХ), Хувилбар 2, 3 -Ш.Энхбаяр (ERINA), Хувилбар 4 ,5-Н.Цолмон (Цукуба Их сургуулийн магистр оюутан).

Хянан тохиолдуулсан: Ш. Энхбаяр (ERINA).

Англи хэлнээс монгол хэлэнд хөрвүүлж, тараах эрх Зүүн Хойд Азийн Эдийн засгийн судалгааны хүрээлэн (ERINA)-д хадгалагдана.

## Товчилсон нэрийн тайлал

Англи товчлол	Англи хэл дээрх бүтэн хэллэг	Монгол товчлол	Бүтэн хэллэг
AAU	Assigned Amount Unit	ТХН	Тогтоосон хэмжээний нэгж
ACM	Approved Consolidated Methodology	БНА	Батлагдсан нэгдмэл аргачлал
AE	Applicant Entity	ӨГ	Өргөдөл гаргагч
AM	Approved Methodology	БАр	Батлагдсан аргачлал
AMS	Approved small-scales methodologies	БАЖ	Батлагдсан жижиг төслийн аргачлал
A/R CDM	Afforestation and Reforestation Project Activities under the Clean Development Mechanism	О/НС ЦХМ	Цэвэр хөгжлийн механизмд хамаарах Ойжуулалт, ой нөхөн сэргээх төслийн үйл ажиллагаа
AR	Afforestation and Reforestation	О/НС	Ойжуулалт, ой нөхөн сэргээлт
CCS	Carbon dioxide Capture and Storage	НХХ	Нүүрсхүчлийн хийн хураалт болон хадгалалт
CDM	Clean Development Mechanism	ЦХМ	Цэвэр хөгжлийн механизм
CDM-AP	CDM Accreditation Panel	ЦХМ-ИК	ЦХМ-ын Итгэмжлэгдсэн комисс
CEF	Carbon Emission Factor	НЯФ	Нүүрстөрөгч ялгаралтын фактор
CER	Certified Emission Reduction	ЯББ	Ялгаралтын баталгаажсан бууралт
COP (CP*)	Conference of the Parties (to the UNFCCC)	ТБХ	(Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын Суурь конвенцид нэгдсэн) Талуудын Бага хурал
COP/MOP (CMP*)	the Conference of the Parties serving as the meeting of the Parties to the Kyoto Protocol	ТБХ/ТХ (ТХ*)	Киотогийн протоколд нэгдсэн талуудын хуралдааны үүрэг гүйцэтгэх Талуудын Бага хурал
CPA	CDM programme activity	ЦХҮа	ЦХМ хөтөлбөрт үйл ажиллагаа
CPR	Commitment Period Reserve	ҮХН	Үүрэгт хугацааны нөөц
DNA	Designated National Authority	ТҮТ	Томилогдсон Үндэсний товчоо
DOE	Designated Operational Entity	ТМБ	Томилогдсон Магадлах байгууллага
EB	CDM Executive Board	ГЗ	ЦХМ-ын Гүйцэтгэх зөвлөл
EIT	Economies in Transition	ШЭЗУ	Шилжилтийн эдийн засагтай улс орнууд
ER	Emission Reduction	ЯБ	Ялгаралтын бууралт
ERT	Expert Review Team	ШҮН	Шинжээчдийн үнэлгээний баг
ERU	Emission Reduction Unit	ЯБН	Ялгаралтын бууралтын нэгж
GHG	Greenhouse Gas	ХүХ	Хүлэмжийн хий
GWP	Global Warming Potential	ДДЧ	Дэлхийн дулааралтын чадамж
HFCS	Hydro fluorocarbons	УФН	Ус фторт нүүрстөрөгчүүд
IET	International emissions trading under the Kyoto Protocol	ЯОУХ	Киотогийн протоколын дагуух ялгаралтын олон улсын худалдаа
IPCC	Intergovernmental Panel on Climate Change	УӨЗГХК	Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх Засгийн газар хоорондын комисс
ITL	International Transaction Log	ОУГБ	Олон улсын гүйлгээний бүртгэл

## Товчилсон нэрийн тайлал (үргэлжлэл)

Англи товчлол	Англи хэл дээрх бүтэн хэллэг	Монгол товчлол	Бүтэн хэллэг
JI	Joint Implementation	ХаХ	Хамтарсан хэрэгжүүлэлт
KP	Kyoto Protocol	КП	Киотогийн протокол
LULUCF	Land Use, Land-Use Change and Forestry	ГАГАӨО	Газар ашиглалт, газар ашиглалтын өөрчлөлт, ойн аж ахуй
MP	Methodologies Panel	АК	Аргачлалын комисс
NM	New Methodology	ШАр	Шинэ аргачлал
OE	Operational Entity	МБ	Магадлах байгууллага
Party	Country or regional integration organization which has ratified the KP, unless otherwise specified	Тал	(өөрөөр заагаагүй бол) КП-д нэгдсэн улс орон болон бүс нутгийн нэгдсэн байгууллага
PDD	Project Design Document	ТББ	Төслийн баримт бичиг
PFCs	Per fluorocarbons	ПФН	Перфторт нүүрстөрөгч
PoA	Programme of Activities	ХҮА	Хөтөлбөрт үйл ажиллагаа
PP	Project Participant	ТО	Төсөлд оролцогч
RMU	Removal Unit	ШГН	Шингээлтийн нэгж
SAR	(the IPCC) 2nd Assessment Report	ХҮТ	(ЗГХК-ын) хоёрдахь үнэлгээний тайлан
SBI	Subsidiary Body for Implementation	ХСХ	Хэрэгжилтийн талаарх салбар хэсэг
SBSTA	Subsidiary Body for Scientific and Technological Advice	ШУТЗСХ	Шинжлэх ухаан, технологийн асуудлаар зөвлөх салбар хэсэг
SF <sub>6</sub>	Sulfur Hexafluoride	ГФН	Гексафторт нүүрстөрөгч
SOP	Share of Proceeds	ОШ	Орлогын шимтгэл
SSC	Small Scale CDM	ЦЖТ	ЦХМ-ын жижиг төсөл
SSC-WG	Working group for small-scale CDM project activities	ЦЖТ-АХ	ЦХМ-ын жижиг төслийн ажлын хэсэг
STL	Supplementary Transaction Log	ТГБ	Туслах гүйлгээний бүртгэл
UNFCCC	United Nations Framework Convention on Climate Change	НҮБҮӨСК	Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын суурь конвенц

Тайлбар: 1.ЦХМ-тай холбоотой баримт бичгүүдийг боловсруулах албан ёсны хэл нь англи хэл тул ЦХМ-ГЗ-тэй харилцахад дээрх жагсаалтын англи товчлолыг баримтална. (орч)

2. \*Холбогдох албан ёсны баримт бичгүүдэд хэрэглэж буй тэмдэглэгээ. (орч)

# Агуулга

## 1. Киотогийн протокол ху1

## 2. Киотогийн механизмууд

2-1. Цэвэр хөгжлийн механизм (ЦХМ) ху2

2-2. Хамтарсан хэрэгжүүлэлт (ХаХ) ху3

2-3. Ялгаралтын олон улсын худалдаа (ЯОУХ) ху4

## 3. ЦХМ төслийн мөчлөг ху6

## 4. ЦХМ-д холбогдох байгууллагууд

4-1. ТБХ/ТХ ху8

4-2. Томилогдсон Үндэсний Товчоо (ТҮТ) ху8

4-3. ЦХМ-ын Гүйцэтгэх Зөвлөл (ГЗ) ху9

4-4. Комисс, Ажлын хэсгүүд ху10

4-5. Томилогдсон Магадлах Байгууллага (ТМБ) ху11

4-6. Төсөлд оролцогчид (ТО) ху13

4-7. Харилцааны дэг, журам ху14

## 5. ЦХМ төсөлд тавигдах нөхцөл ху15

## 6. Төслийн баримт бичиг (ТББ) боловсруулах нь ху17

## 7. Суурь өгөгдөл

7-1. Суурь өгөгдөл болон нэмэгдэл чанарын тухай ойлголт ху19

7-2. Суурь хувилбар ху20

7-3. Суурь өгөгдлийн аргачлал ху21

7-4. Шинэ аргачлал (ШАр)-ын санал өргөн мэдүүлэх журам ху22

7-5. Батлагдсан аргачлал (БАр), зааварт засвар өөрчлөлт оруулах журам ху24

7-6. Батлагдсан аргачлал (БАр)-д тайлбар хүсэх журам ху26

## 8. ТББ-ийн бусад агуулга

8-1. Төслийн хил хязгаар болон нэвчилт ху27

8-2. Хяналт шинжилгээний төлөвлөгөө ху27

8-3. Тооцоот хугацаа ху28

## 9. Оролцогч Талуудын зөвшөөрөл ху30

## 10. Магадлагаа

10-1. Магадлагаа хийх журам ху31

10-2. Магадлагаанд тавигдах шаардлагууд ху32

## 11. Бүртгэл

11-1. Бүртгэлийн журам ху33

11-2. Бүртгэлийг дахин нягтлах журам ху34

11-3. Бүртгэлийн хураамж ху35

## 12. Хяналт шинжилгээний төлөвлөгөөнд засвар өөрчлөлт оруулах нь ху36

## 13. ЯББ-ын нотолгоо, баталгаажуулалт, олголт

13-1. ЯББ-ыг нотлох, баталгаажуулах, олгох журам ху37

13-2. Олголтыг дахин нягтлах журам ху39

## 14. Гажилт ху40

## 15. ЯББ-ын хуваарилалт ху41

## 16. Тооцоот хугацааг сунгах нь ху42

# Агуулга

## 17. ЦХМ-ын Жижиг төсөл (ЦЖТ)

17-1. ЦХМ-ын жижиг төслийн тодорхойлолт ху43

17-2. Хялбарчилсан дэг, журам ху45

17-3. ЦЖТ-г багцлах нь ху47

## 18. ЦХМ-ын Ойжуулалт, ой нөхөн сэргээх төсөл (О/НС ЦХМ)

19-1. О/НС ЦХМ-ын тойм ху48

19-2. О/НС ЦХМ-ын байнгын бус байдал (ТЯББ, УЯББ) ху49

19-4. О/НС ЦХМ-ын жижиг төсөл ху53

## 19. ЦХМ Хөтөлбөрт үйл ажиллагаа ху52

## 20. Регистр болон Олон улсын гүйлгээний бүртгэл (ОУГБ)

20-1. ЦХМ-ын регистр ху55

20-2. Үндэсний регистр ху56

20-3. Олон улсын гүйлгээний бүртгэл (ОУГБ) ху58

## Хавсралт 1. ЦХМ-ын баримт бичгүүд

1-1. Төслийн баримт бичиг (ЦХМ-ТББ) ху59

1-2. Жижиг төслийн үйл ажиллагааны төслийн баримт бичиг (ЦЖТ-ТББ) ху61

1-3. ЦХМ-ын багцалсан жижиг төслийн үйл ажиллагааг өргөн мэдүүлэх маягт (М-ЦХМ-ЦЖТ-БАГЦ) ху62

1-4. Хөтөлбөрт үйл ажиллагааны ТББ-ийн маягт (ЦХМ-ХҮа-ББ) ху63

1-5. ЦХМ Хөтөлбөрт үйл ажиллагааны ТББ-ийн маягт (ЦХМ-ЦХҮа-ББ) ху64

## Хавсралт 2. Аргачилсан зааврууд ху65

## Хавсралт 3. Нэмэгдэл чанарыг батлан харуулах, үнэлэх арга ху67

## Хавсралт 4. Цахилгаан эрчим хүчний сүлжээний ялгаралтын факторыг тооцоолох арга ху69

## Хавсралт 5. Холимог биотүлш ашиглах нь ху76

## Хавсралт 6. Батлагдсан аргачлалууд ху77

## Хавсралт 7. Дэлхийн дулааралтын чадамж (ДДЧ) болон нүүрстөрөгч ялгаралтын фактор (НЯФ) ху84

Өмнөх хувилбарт орсон гол өөрчлөлтүүд (Хув. 4.0 / 2007 оны 11 сар) ху85

# Товчлолын тайлбар

Тус баримтад хэрэглэсэн товчлол болон холбогдох албан ёсны баримт бичгийн бүтэн нэр, тэмдэглэгээний жишээ

[ ] хашилтад бичигдсэн товчлол	Албан ёсны баримт бичгийн бүтэн нэр, тэмдэглэгээ
КП зү.2 хэ1(а)	Киотогийн протоколын зүйл 2, хэсэг 1(а)
ТБХ/2001/13/Н.2, ху1, хэ2(а)	УӨСК/ТБХ/2001/13/Нэмэлт 2, хуудас 1, хэсэг 2(а)
ТХ/2005/8/Н.1, ху1 хэ2(а)	УӨСК/КП/ТХ/2005/8/Нэмэлт 1, хуудас 1, хэсэг 2(а)
ГЗ.01 Тай, хэ3(а)	Цэвэр хөгжлийн механизмын Гүйцэтгэх зөвлөлийн Анхдугаар хурлын тайлан, хэсэг 3(а)
ГЗ.01 Х1, хэ3(а)	Цэвэр хөгжлийн механизмын Гүйцэтгэх Зөвлөлийн Анхдугаар хурлын тайлан, Хавсралт 1, хэсэг 3(а)
ТББ Е3 хув6.2, ху1	Төслийн баримт бичгийг (ЦХМ-ТББ) бүрдүүлэх ерөнхий заавар болон ашиглавал зохих суурь өгөгдөл, хяналт шинжилгээний шинэ аргачлал (ЦХМ-ША) Хувилбар 6.2, хуудас 1 (Хув6.2 нь 2006 оны 12-р сарын 19-ний өдөр нийтлэгдсэн)
ЦЖТ Е3 хув5, ху1	ЦХМ-ЦЖТ-ТББ, А-ЦХМ-ЦЖТ-Өгөх болон А-ЦХМ-ЦЖТ-БАГЦ зэргийг бүрдүүлэх ерөнхий заавар, хувилбар 05, хуудас 1(Хув5 нь 2007 оны 9-р сарын 14-ний өдөр нийтлэгдсэн)
НэрТ хув3, ху1	ЦХМ-ын Нэр томъёоны тайлбар, хувилбар 03, хуудас 1(Хув3 нь 2007 оны 11-р сарын 30-ны өдөр нийтлэгдсэн)
Х гэдэг нь Хавсралт, Н гэдэг нь Нэмэлт, Т гэдэг нь Тайлбар гэсэн утгатай байна.	
ЦХМ ДЖ гэдэг нь ЦХМ дэг, журам (Шийдвэр 17/ТБХ.7-ийн хавсралт) (УӨСК/ТХ/2001/13/Н.2, ху26-41) гэсэн утгатай байна.	
ЦХМ О/НС ДЖ гэдэг нь ЦХМ-д хамаарах Ойжуулалт, ой нөхөн сэргээлтийн төслийн ажиллагааны дэг, журам (Шийдвэр 19/ТБХ.9-ийн хавсралт) (УӨСК/ТХ/2003/6/Н.2, ху16-27) гэсэн утгатай байна.	

# 1. Киотогийн протокол

- ◆ Киотогийн протоколыг 1997 оны 12-р сард Япон улсын Киото хотноо болсон Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын Суурь конвенцийн (НҮБУӨСК) Талуудын Гуравдугаар Бага хурлаар (ТБХЗ) баталсан билээ.
- ◆ Протоколоор Хавсралт 1-д орсон Талуудын хүлэмжийн хийн (ХүХ) ялгаралтыг бууруулах тоон үүргийг тодорхойлсон болно. [КП зү.3 хэ1]

Протокол нь нүүрсхүчлийн хий ( $\text{CO}_2$ ), метан ( $\text{CH}_4$ ), азотын хүчил ( $\text{N}_2\text{O}$ ), УФН, ПФН болон ГФХ-г ХүХ хэмээн тогдорхойлов. [КП Х.А]

Хавсралт 1-д орсон Талууд гэж НҮБУӨСК-ийн Х.1-д бичигдсэн хөгжингүй орнууд болон ОХУ, Зүүн Европын зэрэг шилжилтийн эдийн засагтай орнуудыг хэлнэ.

Хавсралт 1-д орсон Талуудад тогтоосон 2008-2012 оны хооронд буюу 1-р үүрэгт хугацааны ХүХ-н ялгаралтын дээд хязгаар харилцан адилгүй байна.

- ☞ “Тогтоосон хэмжээ” гэгдэх ялгаралтын дээд хязгаарыг Тал тус бүрд дараах байдлаар тооцно. Үүнд:  
“Суурь оны ялгаралтын хэмжээ” х “Ялгаралтыг бууруулах тоон үүрэг” х тав [КП зү.3 хэ7]
- ☞ Суурь оны ялгаралтын хэмжээ гэдэг нь тухайн Талын 1990 оны ХүХ-н ялгаралтын нийт хэмжээг хэлнэ. (УФН, ПФН болон ГФХ-ийн хувьд 1995 оныг суурь оноор тооцож болно). [КП зү.3 хэ1&8]

- ◆ Протокол нь Киотогийн механизмууд гэгдэх зах зээлийн дараах 3 механизмыг тодорхойлж өгсөн. Эдгээрийг ашигласнаар Х.1-д орсон Талууд ХүХ ялгаралтыг бууруулах тоон үүргээ бага өртгөөр хэрэгжүүлэх боломжтой болно.

**Хамтарсан хэрэгжүүлэлт (ХаХ)**

<Протоколын 6-р зүйл>

**Цэвэр хөгжлийн механизм (ЦХМ)**

<Протоколын 12-р зүйл>

**Ялгаралтын олон улсын худалдаа**

<Протоколын 17-р зүйл>

- ◆ Киотогийн механизмуудыг Талуудаас гадна хувийн компаниуд ашиглаж болно. [ТХ/2005/8/Н2, ху7 хэ29][ТХ/2005/8/Н1, ху13 хэ33][ТХ/2005/8/Н2, ху19 хэ5]
- ☞ Үүний тулд Талууд Киотогийн механизмыг ашиглахад тавигдах шаардлагад нийцсэн байх учиртай.

## НЭМЭЛТ: Киотогийн протокол хүчин төгөлдөр болох нь

НҮБУӨСК-ийн 55-аас цөөнгүй Талууд, үүний дотор Х.1-д орсон Талуудын 1990 оны  $\text{CO}_2$ -н нийт ялгаралтын 55-аас доошгүй хувийг гаргадаг Талууд протоколыг батламжилсан, хүлээн зөвшөөрсөн, сайшаан дэмжсэн буюу нэгдэн орсон тухай баримт бичгээ өргөн мэдүүлсний дараах 90 дэх хоногт Киотогийн протокол хүчин төгөлдөр болсон гэж үзнэ. [КП зү.25 хэ1]


- ☞ 2007 оны 12-р сарын 12-ны байдлаар нийт 176 улс болон бүс нутгийн нэгдсэн 1 байгууллага (ЕЭЗХН) протоколыг батламжилсан, хүлээн зөвшөөрсөн, сайшаан дэмжсэн буюу нэгдэн орсноо өргөн мэдүүлээд байна.
- ☞ Х.1-д орсон Талуудын 1990 оны  $\text{CO}_2$ -н нийт ялгаралтын 63.7%-г гаргадаг Талууд уг протоколыг баталсан байна.  
⇒ Протокол нь 2005 оны 2-р сарын 16-ний өдөр хүчин төгөлдөр болсон байна.



## 2. Киотогийн механизмууд

### 2-1. Цэвэр хөгжлийн механизм (ЦХМ)


- ◆ ХүХ-н ялгаралтын дээд хязгаар (ялгаралтын хязгаар) заагдсан, Х.1-д орсон Талууд нь ийм хязгаар заагдаагүй, Х.1-д ороогүй Талуудын ХүХ-н ялгаралтыг бууруулах (эсвэл шингээх) төсөл хэрэгжүүлэхэд туслан, уг төслийн үр дүнд буурсан ХүХ-н ялгаралтын хэмжээг тодорхой нэгжээр тооцон бүртгэж, баталгаажуулна.
  - ☞ ЦХМ төсөл хэрэгжиж буй орон буюу Талыг Хүлээн авагч Тал гэнэ.
  - ☞ ЦХМ-ын ХүХ-н бууралтын нэгжийг Ялгаралтын баталгаажсан бууралт (ЯББ) гэнэ. [ТХ/2005/8/Н1, ху7 хэ1(б)]
  - ☞ ХүХ-н ялгаралтын энэхүү бууралт нь тухайн бүртгэгдсэн төсөл хэрэгжээгүй байх үеийн ялгаралтад нэмэгдэл байх ёстой. [КП зү.12 хэ5(в)].
- ◆ Х.1-д орсон Талууд Киотогийн протоколын дагуу ХүХ-н ялгаралтаа бууруулах өөрсдийн тоон үүргээ биелүүлэхэд ЯББ-г ашиглаж болно [КП зү.12 хэ3(б)].
  - ☞ Ингэснээр, Х.1-д орсон Талуудын ялгаралтын дээд хязгаар нэмэгдэнэ.
- ◆ ЦХМ нь 1-р үүрэгт хугацаа эхлэхээс өмнө ЯББ-г олгох болно.
  - ☞ 2000-2012 онд хэрэгжсэн төслийн үйл ажиллагааны дүнд олгогдсон ЯББ-г Х.1-д орсон Талуудын 1-р үүрэгт хугацааны гүйцэтгэлд ашиглаж болно. [КП зү.12 хэ10]



2-2. Хамтарсан хэрэгжүүлэлт (ХаХ)

- ◆ ХүХ-н ялгаралтын дээд хязгаар (ялгаралтын хязгаар) бүхий Х.1-д орсон Талууд нь бусад Х.1-д орсон Талуудын ХүХ-н ялгаралтыг бууруулах (эсвэл шингээх) төсөл хэрэгжүүлэхэд туслан, уг төслийн үр дүнд буурсан ХүХ-н ялгаралтын хэмжээг тодорхой нэгжээр тооцон бүртгэж, баталгаажуулна.
  - ☞ ХаХ төсөл хэрэгжиж буй орон буюу Талыг хүлээн авагч Тал гэнэ.
  - ☞ ХаХ-ийн ХүХ-н бууралтын нэгжийг Ялгаралтын бууралтын нэгж (ЯБН) гэнэ. [ТХ/2005/8/Н1, ху7 хэ1(a)]
  - ☞ ХүХ-н ялгаралтын энэхүү бууралт эсвэл шингээлт нь тухайн төсөл хэрэгжээгүй байх үеийн ялгаралтад нэмэгдэл байх ёстой. [КП зү.6 хэ1(б)]
- ◆ Х.1-д орсон Талууд Киотогийн протоколын дагуу ХүХ-н ялгаралтаа бууруулах өөрсдийн тоон үүргээ биелүүлэхэд ЯБН-г ашиглаж болно. [КП зү.6 хэ1]
  - ☞ ХаХ-ийн хүрээнд ЯБН нь ялгаралтын дээд хязгаар бүхий Талуудын хооронд шилжиж буй тул тухайн Талуудын ялгаралтын дээд хязгаарын хэмжээ өөрчлөгдөхгүй.
- ◆ ЯБН-г 2008 оноос хойш олгоно. [ТХ/2005/8/Н2, ху2 хэ5]


Х.1-д орсон Талуудын ялгаралтын дээд хязгаарын нийлбэр өөрчлөгдөхгүй



2-3. Ялгаралтын олон улсын худалдаа (ЯОУХ)


- ◆ Х.1-д орсон Талууд хоорондоо ялгаралтын тогтоосон хэмжээний хэсэг, ЯББ, ЯБН гэх мэт Киотогийн протоколын нэгжүүд (КП-ын нэгжүүд)-ийг арилжихыг Ялгаралтын олон улсын худалдаа гэнэ.
  - ☞ Х.1-д орсон Талуудын ялгаралтын дээд хязгаарын нийлбэр дүн өөрчлөгдөхгүй.
  - ☞ Ялгаралтын олон улсын худалдаанд гагцхүү Киотогийн протоколын Хавсралт Б-д орсон Талууд оролцож болно.
  - ☞ Худалдааны хамгийн бага нэгж нь 1 тонн нүүрсхүчлийн хий (1т CO<sub>2</sub>)-тэй тэнцэх нэгж байна.
- ◆ Ялгаралтын олон улсын худалдаа нь зах зээлийн механизмыг ашигласнаар Х.1-д орсон Талуудын ХүХ-н ялгаралтыг бууруулах хамтын тоон үүргээ биелүүлэх нийт өртгийг багасгах боломж олгоно.

Ялгаралтын олон улсын худалдаагүйгээр



	А тал	Б тал	Дүн
ЯХ-аас өмнө: Ялгаралтын хязгаар	10	8	18
КП-ын нэгжийн худалдаа	-	-	-
ЯХ-ын дараа: Ялгаралтын хязгаар	10	8	18
ХүХ-н ялгаралт	12	10	22
Бууруулах хэмжээ	2	2	4
Бууралтын нэгж өртөг	\$200	\$100	-
Бууралтын нийт өртөг	\$400	\$200	\$600
Худалдааны өртөг	-	-	-
Гүйцэтгэлийн нийт өртөг	\$400	\$200	<b>\$600</b>

Ялгаралтын олон улсын худалдаатайгаар



	А тал	Б тал	Дүн
ЯХ-аас өмнө: Ялгаралтын хязгаар	10	8	18
КП-ын нэгжийн худалдаа	1	-1	0
ЯХ-ын дараа: Ялгаралтын хязгаар	11	7	18
ХүХ-н ялгаралт	12	10	22
Бууруулах хэмжээ	1	3	4
Бууралтын нэгж өртөг	\$200	\$100	-
Бууралтын нийт өртөг	\$200	\$300	\$500
Худалдааны өртөг	150	-150	0
Гүйцэтгэлийн нийт өртөг	\$350	\$150	<b>\$500</b>


Тайлбар: Б тал А талд 1 КП-ын нэгжийг 150 ам.доллараар худалдана.

2-3. Ялгаралтын олон улсын худалдаа

- ◆ Х.1-д орсон Талууд нь Киотогийн протоколын дараах нэгжүүдийг арилжиж болно. Үүнд:
  - ☞ **Тогтоосон хэмжээний нэгж (ТХН)** [ТХ/2005/8/Н1, ху7 хэ1(в)]
    - ⇒ Х.1-д орсон Талын ТХН-ийн хэмжээг түүний суурь оны ялгаралт болон ялгаралтыг бууруулах тоон үүрэгт үндэслэн тодорхойлно.
  - ☞ **Шингээлтийн нэгж (ШГН)** [ТХ/2005/8/Н1, ху7 хэ1(г)]
    - ⇒ Х.1-д орсон Талын ШГН-ийн хэмжээг ойжуулалт болон ой нөхөн сэргээх (О/НС) төслөөр [ТХ/2005/8/Н3, ху5 хэ1(а)-(г)] болон ХүХ шингээгчтэй холбогдсон бусад үйл ажиллагаагаар шингээгдсэн ХүХ-н цэвэр хэмжээнд үндэслэн тодорхойлно. [ТХ/2005/8/Н3, ху5 хэ1(д)-(э)]
  - ☞ ХаХ-ийн Ялгаралтын бууралтын нэгж (ЯБН)
  - ☞ ЦХМ-ын Ялгаралтын баталгаажсан бууралт (ЯББ)
  - ☞ Ялгаралтын баталгаажсан түр бууралт (тЯББ) болон Ялгаралтын баталгаажсан урт хугацааны бууралт (уЯББ)
    - ⇒ тЯББ болон уЯББ-г ЦХМ-д хамаарах ойжуулалт болон ой нөхөн сэргээх (О/НС) төслийн үр дүнд олгоно [ТХ/2005/8/Н1, ху62 хэ1(ж)-(э)]

**НЭМЭЛТ: Гүйцэтгэлийн үнэлгээ**

Х.1-д орсон талын 1-р үүрэгт хугацааны эцэс дэх ХүХ-н ялгаралтын хязгаарыг дараах байдлаар тооцно. Үүнд:



**Он дамжуулах**


Хэрэв Х.1-д орсон Талын ХүХ-н ялгаралтын хязгаар нь түүний 1-р үүрэгт хугацааны ялгаралтын хэмжээнээс их байвал уг зөрүүг үүргийн дараагийн хугацаанд шилжүүлэн тооцох боломжтой. [ТХ/2005/8/Н2, ху27 хэ15] [ТХ/2005/8/Н2, ху30 хэ36]


- ☞ Нэмэлт хугацаа нь ТБХ/ТХ-аар тогтоосон өдрөөс хойшхи 100 дахь өдрөөр дуусгавар болно. [ТХ/2005/8/Н3, ху101 XIII]
- ☞ КП-ын нэгжийн төрлөөс хамаараад ийнхүү он дамжуулан шилжүүлэхэд зарим хязгаарлалт тавигдана.

**Үл гүйцэтгэлийн үр дагавар**

- ◆ Хэрэв Х.1-д орсон Талын ХүХ-н ялгаралтын хэмжээ нь түүний 1-р үүрэгт хугацааны ялгаралтын хязгаараас их байвал түүнийг Киотогийн протоколын дагуу үүргээ зөрчсөнд тооцно.
- ◆ Үүргээ зөрчсөн Талд дараах арга хэмжээг авна. Үүнд: [ТХ/2005/8/Н3, ху102 хэ5]
  - ☞ Тухайн Талын үүргийн хоёрдугаар хугацааны ялгаралтын тогтоосон хэмжээг түүний илүүдэл ялгаралтын дүнг 1.3 дахин үржүүлсэнтэй тэнцэх (тонноор илэрхийлэгдэх) хэмжээгээр багасгах;
  - ☞ Гүйцэтгэлийн ажлын төлөвлөгөө боловсруулах; болон
  - ☞ Тухайн Талын статус сэргээгдэх хүртэл Протоколын 17-р Зүйлд заасны дагуу шилжүүлэг хийх эрхийг нь түдгэлзүүлэх.

### 3. ЦХМ төслийн мөчлөг





## 4. ЦХМ-ын холбогдох байгууллагууд

### 4-1. ТБХ/ТХ

Киотогийн протоколд нэгдсэн талуудын хуралдааны үүрэг гүйцэтгэх Талуудын бага хурал (ТБХ/ТХ) нь [ТХ/2005/8/Н1, ху7 хэ2-4]:

- ☞ ЦХМ-ын талаарх бүрэн эрх эдэлж, удирдан, зааварчилна;
- ☞ Ажлын журмын талаарх ГЗ-ийн зөвлөмж болон 17/ТХ.7 тоот шийдвэр [ТБХ/2001/13/Н2 ху20-49]-ийн дагуу энэхүү хавсралт болон ТБХ/ТХ-ын холбогдох тогтоолуудын талаар шийдвэр гаргана;
- ☞ ГЗ-ийн итгэмжилсэн магадлах байгууллагуудыг (МБ) томилох шийдвэр гаргана;
- ☞ ГЗ-ийн жилийн тайланг хянана;
- ☞ Томилогдсон магадлах байгууллага (ТМБ) болон ЦХМ төслүүдийн бүс нутаг болон дэд бүс нутаг дахь хуваарилалтыг хянан үзнэ;
- ☞ Шаардлагатай үед ЦХМ төслийн санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг туслалцаа үзүүлнэ.

**НЭМЭЛТ: ЦХМ-ын Дэг журамд засвар өөрчлөлт оруулах нь** [ТХ/2005/8/Н1, ху6 хэ4]

- ◆ ЦХМ-ын Дэг журамд засвар өөрчлөлт оруулах асуудлыг ТБХ/ТХ-ын журмын дагуу шийдвэрлэнэ.
  - ☞ 1-р үүрэгт хугацаа дууссанаас хойш 1 жилийн дотор эхний хяналт явуулна.
  - ☞ Эхний хяналтыг ГЗ болон шаардлагатай бол ШУТЗСХ-ын техникийн саналд үндэслэсэн ХСХ-ын зөвлөмжинд тулгуурлан хийнэ.
  - ☞ Удаах хяналтуудыг тогтмол давтамжтайгаар хийнэ.
- ◆ Шийдвэрт оруулсан өөрчлөлтүүд нь нэгэнт бүртгэгдсэн цэвэр хөгжлийн механизмын төслийн үйл ажиллагаанд нөлөөлөх ёсгүй.

### 4-2. Томилогдсон Үндэсний Товчоо (ТҮТ)

- ◆ ЦХМ-д оролцогч Талууд өөрсдийн ЦХМ-ын томилогдсон үндэсний товчоог (ТҮТ) байгуулна. [ТХ/2005/8/Н1, ху12 хэ29]
- ◆ ЦХМ төслийн оролцогчид (ТО) төсөлд сайн дураар оролцож буй тухай бичгээр үйлдсэн зөвшөөрлийг оролцогч Тал тус бүрийн ТҮТ-оос авна.
  - ☞ Зөвшөөрөл нь тухайн төслийн үйл ажиллагаа уг орны тогтвортой хөгжлийг дэмжиж буй тухай Хүлээн авагч Талын баталгааг агуулсан байна. [ТХ/2005/8/Н1, ху15 хэ40(а)]
  - ☞ Зөвшөөрөл авах журмыг Талууд бие даан тогтооно.

## 4-3. ЦХМ-ын Гүйцэтгэх Зөвлөл (ГЗ)

- ◆ ГЗ нь ТБХ/ТХ-ын удирдлага, зааврын дагуу ЦХМ-ын үйл ажиллагааг хянахын [ТХ/2005/8/Н1, ху8 хэ5] зэрэгцээ:
  - ☞ ЦХМ-ын Дэг журмын нэмэлт өөрчлөлтийн талаар ба/эсвэл ГЗ-ийн ажлын дүрэм журамд засвар нэмэлт оруулах асуудлаар ТБХ/ТХ-д зөвлөмж өгнө;
  - ☞ Суурь өгөгдөл, хяналт шинжилгээний хуваарь, төслийн хил хязгаар болон бусад асуудалтай холбоотой шинэ аргачлалуудыг батална;
  - ☞ ЦХМ-ын жижиг төсөл (ЦЖТ)-ийн үйл ажиллагааны тодорхойлолт, хялбарчилсан дэг журмын агуулгыг хянаж, шаардлагатай бол ТБХ/ТХ-д холбогдох зөвлөмж гаргана;
  - ☞ Магадлах байгууллагууд (МБ)-ыг итгэмжлэх ажлыг хариуцаж, тэдгээрийн томилгооны талаар ТБХ/ТХ-д зөвлөмж гаргана.
  - ☞ Олон нийтэд техникийн тайлан гаргаж, аргачлал, зааврын төслийн талаар 8 долоон хоногоос багагүй хугацаанд нийтийн өмчит саналыг хүлээн авч ажиллана;
  - ☞ ЦХМ-ын регистр (бүртгэлийн систем)-ийг боловсруулж хөтөлнө;
  - ☞ Магадлагаа хийгдсэн төслийг ЦХМ-ын төсөл хэмээн албан ёсоор бүртгэнэ (бүртгэл); [ТХ/2005/8/Н1, ху14 хэ36]
  - ☞ ЦХМ-ын регистр эрхлэгч (админ)-д тухайн ЦХМ төсөлд ЯББ олгох заавар өгнө; [ТХ/2005/8/Н1, ху19 хэ66]
  - ☞ Бусад.
- ◆ ГЗ-ийн үйл ажиллагаа, ЦХМ-д хамааралтай батлагдсан дүрэм, журам, аргачлал болон стандартыг <<http://CDM.unfccc.int/>> вэб хуудсаас авч болно

## ГЗ-ийн гишүүд [ТХ/2005/8/Н1, ху9 хэ7-12]

- ☞ ГЗ нь КП-д нэгдсэн Талуудыг төлөөлөх 10 гишүүнээс бүрдэнэ.
  - ⇒ Үүнд НҮБ-ын бүс нутгийн 5 бүлэглэл бүрээс 1, Х.1-д орсон Талуудаас 2, Х.1-д ороогүй Талуудаас 2, хөгжиж буй жижиг арлын улсуудыг төлөөлөх 1 гишүүн орно.
  - ⇒ НҮБ-ын бүс нутгийн 5 бүлэглэл гэдэгт Ази, Африк, Латин Америк, Зүүн Европ, Баруун Европ болон Бусад орно.
  - ⇒ Ийнхүү гишүүдийн 4 нь Х.1-д орсон Талуудаас байх болон Азийн 1 гишүүн Япон улсаас сонгогдоноос бусад тохиолдолд 6 нь Х.1-д ороогүй Талуудаас байна.
  - ⇒ ГЗ-ийн гишүүн бүрт нэг альтернатив (орлох) гишүүн байна.
- ☞ ГЗ-ийн үндсэн болон альтернатив гишүүд дээр дурьдсан улс орон болон бүлэглэлүүдээс нэр дэвших бөгөөд ТБХ/ТХ-аар сонгогдоно.
  - ⇒ Сул орон тоог мөн ижил аргаар нөхнө.
- ☞ Гишүүдийг 2 жилийн хугацаатайгаар сонгох болон 2-оос дээшгүй удаа дараалан сонгогдох эрхтэй байна.
  - ⇒ Альтернатив (орлох) гишүүнээр ажилласан хугацааг үүнд оруулахгүй.
- ☞ Үндсэн 5, альтернатив 5 гишүүнийг эхлэн 3 жилийн хугацаагаар, бусад үндсэн болон альтернатив гишүүдийг 2 жилийн хугацаатай сонгоно. Цаашид ТБХ/ТХ-аас жил тутам шинээр 5 үндсэн болон 5 альтернатив гишүүнийг тус тус 2 жилийн хугацаатайгаар сонгоно.
- ☞ ГЗ нь зөвлөлийн дарга болон дэд даргыг сонгох бөгөөд нэг нь Х.1-д орсон Талаас, нөгөө нь Х.1-д ороогүй Талаас байна.
  - ⇒ Зөвлөлийн дарга болон дэд даргын албан тушаал Х.1-д орсон Тал болон Х.1-д ороогүй Талын хооронд жил бүр ээлжлэн солигдоно.


## ГЗ хуралдах, шийдвэр гаргах [ТХ/2005/8/Н1, ху10 хэ13-16]

- ☞ ГЗ нь шаардлагатай үед, гэхдээ жилд 3-аас доошгүй удаа хуралдана.
- ☞ Х.1-д орсон Талуудын ихэнх болон Х.1-д ороогүй Талуудын ихэнхийг тус тус төлөөлөх, ГЗ-ийн гишүүдийн гуравны хоёроос цөөнгүй гишүүд хуралд оролцох бол ирц (кворум) бүрдсэнд тооцно.
- ☞ ГЗ нь санал нэгтгэйгээр шийдвэр гаргахыг эрмэлзэнэ. Боломжгүй тохиолдолд хуралд оролцож санал өгсөн гишүүдийн дөрөвний гурвын саналаар шийдвэр гаргана. Түдгэлзсэн гишүүдийг санал өгөөгүйд тооцно.
- ☞ ГЗ өөрөөр шийдээгүй бол ГЗ-ийн хуралд ажиглагчид оролцоход нээлттэй байна.



4-4. Комисс, Ажлын хэсгүүд

- ◆ ГЗ нь үйл ажиллагаандаа туслуулахаар хороо, комисс эсвэл ажлын хэсэг байгуулж болно. ГЗ нь тухайн ажил гүйцэтгэхэд шаардагдах мэргэжил, туршлагатай хүмүүсийг, үүний дотор НҮБҮӨСК-ийн мэргэжилтнүүдийн ростер (хүний нөөцийн жагсаалт)-д буй мэргэжилтнүүдээс сонгон шалгаруулж авна. Ингэхдээ бүс нутгийн төлөөллийн тэнцвэрийг бүрэн харгалзаж үзнэ. [ТХ/2005/8/H1, ху10 хэ18]
- ◆ ГЗ нь одоогийн байдлаар дор дурьдсан комисс болон ажлыг хэсгүүдийг байгуулаад байна. <<http://CDM.unfccc.int/EB/Panels>>



## 4-5. Томилогдсон Магадлах Байгууллага (ТМБ)

### ◆ ЦХМ-д хамаарах ТМБ нь:

- ☞ ГЗ-өөр итгэмжлэгдэн томилогдсон (ТБХ/ТХ-аар батлагдах хүртлээ түр хугацаагаар) дотоодын хуулийн этгээд, эсвэл олон улсын байгууллага байна.
- ☞ Үндсэн 2 үүрэгт ажилтай байна. Үүнд:
  - ⇒ Санал болгож буй ЦХМ-ын төслийн үйл ажиллагааг магадлаж, улмаар бүртгүүлэх хүсэлт гаргана.
  - ⇒ Бүртгэгдсэн ЦХМ-ын төслийн үйл ажиллагааны дүнд бий болсон ялгаралтын бууралтанд нотолгоо хийж, үнэн зөв эсэхийг нь баталгаажуулан, Ялгаралтын баталгаажсан бууралт (ЯББ)-г олгох тухай хүсэлтийг ГЗ-д гаргана.
- ◆ Хүсэлт гаргавал, тухайн ЦХМ төслийн үйл ажиллагаатай холбогдох дээрх үүргүүдийг нэг ТМБ гүйцэтгэхийг ГЗ зөвшөөрч болно. [ТХ/2005/8/Н1, ху12 хэ27(д)]

ТМБ-д хамааралтай албан ёсны баримтанд ашиглагдах нэр томъёо:

- ☞ Өргөдөл гаргагч байгууллага (ӨГ)=өргөдлийг зохих журмын дагуу гаргасны дараа;
- ☞ Томилогдсон магадлах байгууллага (ТМБ)= ТБХ/ТХ-аас томилсны дараа.  
[Г334 Х1, ху3 тайлбар]

### МБ-г итгэмжлэх журам [Г334 Х1, хэ3]

- ◆ Магадлах байгууллага (МБ)-г ТБХ/ТХ-аас ГЗ-ийн зөвлөмжинд үндэслэн томилно.
- ◆ ӨГ-г итгэмжлэх, түүнийг томилох тухай саналыг ТБХ/ТХ-д оруулах эсэх шийдвэрийг ГЗ гаргана.
- ◆ ЦХМ-ИК нь ЦХМ-ИБ-ийн хийсэн үнэлгээнд үндэслэн ӨГ-г итгэмжлэх тухай саналыг боловсруулж ГЗ-д танилцуулах үүрэгтэй.
- ◆ ЦХМ-ИК нь төлөвлөгдөөгүй шалгалт хийх, дахин итгэмжлэх, нэмэлт салбар хамаарах хүрээнд итгэмжлэл олгох зэрэг асуудлаар санал боловсруулна.
- ◆ ЦХМ-ИК нь ЦХМ-ИБ бүрийн ажлын төлөвлөгөөг баталж, зааварчилна.
- ◆ ЦХМ-ИБ нь ЦХМ-ИК-ийн зааврын дагуу ӨГ ба/эсвэл ТМБ-д нарийвчилсан үнэлгээ хийнэ. ЦХМ-ИК нь ГЗ-өөс энэ зорилгоор байгуулсан мэргэжилтнүүдийн хэсгээс сонгон бүрдүүлэх замаар ЦХМ-ИБ-г байгуулна

### Итгэмжлэлийг шаталж олгох нь [Г334 Х1, хэ7-8]

- ☞ МБ-ын итгэмжлэлийг гүйцэтгэх үүрэг болон хамрах салбарын хүрээний аль алианаар нь шатлан олгож болох бөгөөд ингэхдээ салбарын тогтоосон ангилалд үндэслэнэ.
- ☞ Тухайн төслийн хамрагдах салбарын хүрээнд үйл ажиллагаа гүйцэтгэх чадвараа гэрчилсний дагуу болон төслийн үйл ажиллагааны цар хүрээгээр (том эсвэл жижиг төсөл) итгэмжлэлийг шатлан олгоно.
- ☞ Аль нэг ажил үүргийг (жишээ нь, магадлагаа) амжилттай гүйцэтгэж буйн гэрч нь тухайн болон холбогдох бусад салбарын ангиллын хүрээнд (салбарын бүлэг)-д өөр үүрэг (жишээ нь, нотолгоо) гүйцэтгэх итгэмжлэл авах авах эрхтэй болж болно.
- ☞ Тухайн байгууллага нь аливаа нэг томоохон төсөлд үүрэгт ажлаа амжилттай гүйцэтгэсэн тохиолдолд л магадлагаа болон нотолгоо/ баталгаажуулалт хийх итгэмжлэлийн аль алиныг хамт авч болно.

### Итгэмжлэлийн хүчин төгөлдөр байх хугацаа

- ☞ МБ-ын тухайн “салбарын хүрээ”-д хамаарах итгэмжлэл нь ГЗ-ийн магадлан итгэмжлэл гарсан өдрөөс хойш 3 жилийн хугацаанд хүчин төгөлдөр байна. ТБХ/ТХ-ын томилгоо нь итгэмжлэл дуусах хүртэл хүчин төгөлдөр байна.
- ☞ Энэхүү 3 жилийн хугацаанд тодорхой давтамжтайгаар хянан шалгалт хийгдэнэ.  
[Г334 Х1, хэ70]
- ☞ ГЗ нь ТМБ-д “гэнэтийн шалгалт” (төлөвлөгдөөгүй шалгалт) хийх эрхтэй байна.  
[Г334 Х1, хэ89]

**ТМБ-н томилгоог түр цуцлах эсвэл эргэн татах** [ТХ/2005/8/Н1, ху11 хэ21]

Хэрэв ГЗ нь ТМБ-д хийсэн үнэлгээгээр тухайн ТМБ нь итгэмжлэлийн шаардлага, эсвэл ТБХ/ТХ-ын шийдвэрийн холбогдох заалтуудад нийцэхгүй болсныг тогтоовол тухайн ТМБ-н томилгоог түр цуцлах эсвэл эргэн татах тухай зөвлөмжийг ТБХ/ТХ-д гаргаж болно.

- ☞ Түр цуцлах, эргэн татах тухай зөвлөмжийг ТМБ-д тайлбар гаргах боломж олгосны дараагаар гаргана.
- ☞ Түр цуцлах, эргэн татах тухай ГЗ-ийн зөвлөмж тэр даруй хүчин төгөлдөр болох бөгөөд ТБХ/ТХ-аас эцсийн шийдвэр гартал хүчин төгөлдөр хэвээр байна.
- ☞ ГЗ нь тухайн байгууллагын томилгоог түр цуцлах эсвэл эргэн татах тухай зөвлөмж гаргасан даруй тус байгууллагад бичгээр мэдэгдэнэ.
- ☞ Энэ асуудлаарх ГЗ-ийн зөвлөмж болон ТБХ/ТХ-ын шийдвэрийг олон нийтэд мэдээлнэ.
  - ⇒ ТБХ/ТХ тухайн ТМБ-г итгэмжлэлийн шаардлагад нийцсэн хэмээн үзсэн тохиолдолд түүний томилгоо сэргээгдэнэ.

**Нэмэлт: Магадлагаа болон нотолгооны тайлангийн чанар, агуулгын нийцтэй байдлыг сайжруулах талаар ТМБ-дад өгөх заавар** [ГЗ32 Х1]

☞ Магадлагаа болон нотолгооны тайлангийн чанар, агуулгын нийцтэй байдлыг сайжруулах талаар зааврыг ЦХМ болон ХА төслийн магадлагаа, нотолгооны заавар зэрэг хэдийнээ хийгдсэн ажлуудад үндэслэн боловсруулахыг ГЗ-өөс НБДНГ-т хүсэлт болгосон болно.

**ТМБ-г томилгоог түр цуцлах, эргэн татах нь бүртгэгдсэн ЦХМ төсөлд хэрхэн нөлөөлөх нь** [ТХ/2005/8/Н1, ху11 хэ22-24]

- ☞ Тухайн ТМБ-н гүйцэтгэсэн магадлагаа, нотолгоо болон баталгаажуулалтын тайланд ямар нэгэн томоохон дутагдал илрээгүй бол түүний томилгоог түр цуцлах эсвэл эргэн татах нь бүртгэгдсэн төслийн үйл ажиллагаанд нөлөөлөхгүй.
  - ⇒ “Томоохон дутагдал” гэдэгт тодорхой тайлбар хийгдээгүй байна.
- ☞ Энэ тохиолдолд ГЗ нь үнэлгээ хийх өөр ТМБ томилох, шаардлагатай засварыг хийлгэх эсэх тухай шийдвэр гаргана.
  - ⇒ Шинээр хийх үнэлгээний зардлыг томилгоо нь түр цуцлагдсан, эсвэл эргэн татагдсан ТМБ хариуцана.
- ☞ Хэрэв үнэлгээгээр хэмжээнээсээ илүү ЯББ олгогдсон нь тогтоогдвол, томилгоо нь түр цуцлагдсан эсвэл эргэн татагдсан ТМБ нь үнэлгээ хийгдсэнээс хойш 30 өдрийн дотор илүүдэл ЯББ-н ГЗ-ээс тодорхойлсон хэмжээтэй тэнцүү нүүрсхүчлийн хийн жиших тонноор илэрхийлсэн хэмжээтэй тэнцэх ЯББ худалдан авч, ЦХМ-ын регистр дэх цуцлалтын данс руу шилжүүлнэ.
- ☞ ТМБ-ын томилгоо түр цуцлагдах, эсвэл эргэн татагдах нь бүртгэгдсэн төслийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх бол ГЗ энэ тухай зөвлөмжөө хохирогч ТО-д тайлбар гаргах боломж олгосны дараа гаргана.

## 4-6. Төсөлд оролцогчид (ТО)

- ◆ ЦХМ төслийн үйл ажиллагаанд сайн дураар оролцоно. [ТХ/2005/8/Н1, ху12 хэ28]
- ◆ ТО гэдэг нь (а) оролцогч Тал ба/эсвэл (б) оролцогч Талын зүгээс итгэмжлэгдсэн ЦХМ төслийн үйл ажиллагаанд оролцох хувийн болон нийтийн өмчит байгууллага байна. [НэрТ, хув3, ху26]

**Оролцогч Тал**

- ☞ Х.1-д ороогүй Тал Киотогийн протоколд нэгдсэн бол ЦХМ төслийн үйл ажиллагаанд оролцож болно. [ТХ/2005/8/Н1, ху12 хэ30]
- ☞ “Оролцогч Тал”-ыг ТББ-н А.3 бүлэгт тодорхой заасан, эсвэл бүртгэгдсэн төслийн хувьд НБДН газарт энэ тухай харилцаа холбооны дэг, журмын дагуу тодорхой мэдээлсэн тохиолдолд түүнийг ТО хэмээн тооцно. [Г325 Тай, хэ110]

**Хувийн болон нийтийн өмчит****байгууллага**

- ☞ Тухайн үедээ эрх олгох эрх бүхий Талаас зөвшөөрөл авсан тохиолдолд л аливаа хувийн болон нийтийн өмчит байгууллага ЯББ шилжүүлэх буюу авч болно. [ТХ/2005/8/Н1, ху13 хэ33]
- ☞ Томилогдсон үндэсний товчоо (ТҮТ)-ноос тухайн байгууллагыг ЦХМ-ын тодорхой үйл ажиллагаанд оролцохыг зөвшөөрөн гаргасан албан тоотыг төсөлд оролцох эрхийн зөвшөөрөл гэнэ. [НэрТ, хув3, ху6]

**ТО-ын өөрчлөлт** [НэрТ, хув3, ху27]

- ☞ ТО өөрчлөгдөх бол энэ тухай харилцааны дэг, журмын дагуу НБДН газраар дамжуулан ГЗ-д даруй мэдээлнэ.
- ☞ Өөрчлөлтийн тухай мэдэгдэлд өмнөх харилцаанд оролцож байсан бүх ТО, мөн шинэ болон үлдэж буй ТО бүгд гарын үсэг зурсан байна.
- ☞ Шинэ ТО бүр төсөлд оролцох эрхийн зөвшөөрөл авсан байх ёстой.

**Сангуудын оролцоо** [НэрТ, хув3, ху7]

Олон талт сангуудын хувьд төсөлд оролцогч бүрийн ТҮТ-ы албан ёсны зөвшөөрөл авсан байх албагүй. Гэхдээ, ийнхүү зөвшөөрөл аваагүй байх нь төсөлд Оролцогч Талын зарим эрх болон давуу талыг эдлэх боломжгүй болох талтай байдаг.

## 4-7. Харилцааны дэг, журам

## Олон нийтийн зүгээс ГЗ-тэй харилцах журам

[ГЗ31 Х37]

- ◆ Санал авах зарын дагуу бус, сайн дураар ГЗ-д ирүүлсэн харилцаа холбоог (цаашид урилгагүй захидал гэх) баримт хүлээж авах эцсийн өдөр (уулзалтаас **2 долоо хоногийн өмнө**)-өөс өмнө хүлээн авсан бол ирэх уулзалтаар хэлэлцэх боломжтой болно.
  - ☞ Харин үүнээс хойш хүлээн авсан урилгагүй захидлыг, шаардлагатай бол, дараагийн уулзалтаар хэлэлцэж болно.
- ◆ ГЗ-д хаягласан урилгагүй захидал хүлээн авснаа НБДН газар нь илгээгчид албан ёсоор мэдэгдэх болон захидлыг ГЗ-д гадаад сүлжээгээр хүргүүлнэ. ГЗ-ийн Нарийн бичгийн дарга, ГЗ-ийн Даргатай зөвшилцөн, шаардлагатай үед ГЗ-аас санал авч хариу арга хэмжээг зохион байгуулах болон ГЗ-ийн Даргыг төлөөлөн зохих хариултыг илгээнэ.
- ◆ Урилгагүй захидал болон түүнд өгсөн хариултыг ГЗ-ийн гишүүн бүрт илгээх эсэхийг ГЗ-ийн Дарга шийднэ.
- ◆ Урилгагүй захидлыг ГЗ-ийн зөвлөлийн Даргад хаяглах болон НҮБУӨСК-ийн НБДН газар руу цахим шуудан (ЦХМ-[info@unfccc.int](mailto:info@unfccc.int) эсвэл [secretariat@unfccc.int](mailto:secretariat@unfccc.int)) эсвэл факсаар илгээнэ (факсын дугаар +49. 228. 815.1999).
- ◆ Хэрэв ГЗ-ийн үндсэн эсвэл альтернатив аль нэг гишүүн өөрийн үүрэг хариуцлагын хүрээнд ийм захидал хүлээн авбал, тэрээр түүнийг НБДН газарт дамжуулан энэ тухай илгээгчид мэдэгдэх бөгөөд дээрх дэг журам үйлчилнэ. Энэ нь комисс болон ажлын хэсгийн гишүүдийн хүлээн авсан харилцаа холбоонд мөн адил хамаарна.

## ТО-ын зүгээс ГЗ-тэй харилцах дэг, журам [НэрТ хув2, ху19]

- ◆ Бүртгэл хийгдэх үед гаргаж өгөх ТО бүрийн гарын үсэг бүхий мэдэгдэлд энэ дэг, журмыг заасан байна.
- ◆ ТМБ-аас бүртгүүлэх тухай өргөдлийг гаргаснаас хойш ТО-оос ирэх буюу тэдгээрт очих албан ёсны бүхий л харилцаа холбоо тус дэг, журмын дагуу явагдана.

## НЭМЭЛТ: Нууц/өмчлөл бүхий мэдээлэл

[НэрТ, хув3, ху13]

- Улсын хууль тогтоомжид өөрөөр зааснаас бусад тохиолдолд, ТО-ын нууц эсвэл өмчлөл хэмээн хүлээн зөвшөөрөгдсөн мэдээллийг түүнийг хүргүүлэгчийн бичгээр үйлдсэн зөвшөөрөлгүйгээр бусдад дэлгэхгүй.
- ☞ Нэмэгдэл чанарыг тогтоох, суурь өгөгдлийн аргачлал болон түүний ашиглалтыг тайлбарлах, мөн түүнчлэн байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн үнэлгээтэй холбоотой мэдээллийг нууц буюу өмчлөл бүхий хэмээн тооцохгүй.
- ◆ ТО нь энэ мэдээллийг 2 хувилбараар хүргүүлнэ. Нэг хувилбарт нь бүхий л нууц/өмчлөл бүхий хэсгүүдийг уншигдахгүй байхаар тэмдэглэн, нөгөө хувилбарт нь бүх мэдээллийг бүрэн харуулах агаад тухайн хувилбартай харьцах бүх этгээд нууцлалыг нь чандлан хадгалах үүрэг хүлээнэ.

## 5. ЦХМ төсөлд тавигдах нөхцөл

ЦХМ төслийн үйл ажиллагааг төлөвлөх үед дараах зүйлийг анхаарвал зохино. Үүнд:

- ☞ ЦХМ-ын зорилго нь Х.1-д ороогүй Талуудын хувьд тогтвортой хөгжлийг хангаж, Конвенцийн эцсийн зорилгыг хэрэгжүүлэхэд хувь нэмрээ оруулахад нь, мөн түүнчлэн Х.1-д орсон Талуудын хувьд өөрсдийн үүргээ биелүүлэхэд нь туслахад оршино. [КП зү.12 хэ2]
  - ⇒ Тухайн ЦХМ төслийн үйл ажиллагаа Хүлээн авагч Талын хувьд тогтвортой хөгжлийг хангахад нь дэмжлэг үзүүлж буй эсэхийг тогтоох нь тухайн Талын асуудал мөн. [ТБХ/2001/13/Н2, ху20]
- ☞ Хэрэв бүртгэгдсэн ЦХМ төслийн үйл ажиллагаа хэрэгжсэний дараах ХүХ-н ялгаралтын хэмжээ уг төсөл хэрэгжихгүй байх тохиолдлоос буурч байвал тухайн ЦХМ төслийн үйл ажиллагааг нэмэгдэл гэж үзнэ. [ТХ/2005/8/Н1, ху16 хэ43]
- ☞ Х.1-д орсон Талууд өөрсдийн ХүХ ялгаралтыг бууруулах тоон үүргээ биелүүлэхдээ цөмийн эрчим хүчний эх үүсвэрээс улбаатай ЯББ-г ашиглахаас зайлсхийвал зохино. [ТБХ/2001/13/Н2, ху20]
- ☞ ЦХМ-д хамаарах газар ашиглалт, газар ашиглалтын өөрчлөлт болон ойн аж ахуйн төслийн үйл ажиллагаа нь ойжуулалт, ой нөхөн сэргээх (О/НС) үйл ажиллагаагаар хязгаарлагдана. [ТБХ/2001/13/Н2, ху22 хэ7(а)]
- ☞ ЦХМ төсөлд төрөөс олгох санхүүжилт нь ODA-Хөгжлийн албан ёсны тусламж (ХАЁТ)-г өөр зорилгод ашигласан тохиолдол байж болохгүйн зэрэгцээ Х.1-д орсон Талуудын санхүүгийн үүрэг хариуцлагаас ангид байж, тооцоонд нь орохгүй. [ТБХ/2001/13/Н2, ху20]
  - ⇒ Ийм санхүүжилт нь ХАЁТ-ыг өөр зорилгоор ашигласан хэлбэр бусаас гадна Х.1-д орсон Талуудын санхүүгийн үүрэг хариуцлагаас ангид, түүнд тооцогдоогүй болохыг Х.1-д орсон Талууд баталгаажуулна. [ТББ Е3 хув6.2, ху9]
  - ⇒ Мөн 2004 оны 4 сарын 15-16-нд болсон DAC-Хөгжлийн Тусламжийн Хорооны Дээд хэмжээний уулзалтаар батлагдсан “ЦХМ-д нийцэх ХАЁТ-ын зардлууд” гэсэн баримт бичиг бий. [DAC/CHAIR(2004)4/FINAL]
- ◆ ЦХМ төслийг бүртгүүлэхийн тулд Төслийн баримт бичиг (ТББ)-г боловсруулсан байх шаардлагатай.
  - ☞ ТББ-ийн агуулгыг Хавсралт 1-3-д тайлбарласан болно.

**НЭМЭЛТ:** Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжих ЦХМ төсөл

[ТХ/2005/8/Н1, ху97 хэ20]

- ◆ Орон нутаг/бүс нутаг/үндэсний бодлого буюу стандартыг ЦХМ төслийн үйл ажиллагаа хэмээн тооцохгүй.
- ◆ Гэхдээ, хил хязгаарыг нь тодорхойлох, давхар бүртгэхээс зайлсхийх, нэвчилтийг хянах, ялгаралтын бууралт нь бодит, хэмжигдэхүйц бөгөөд баталгаажуулахуйц байх, төслийн үйл ажиллагаа хэрэгжээгүй үед байх ялгаралтанд нэмэгдэл байх зэргийг баталгаажуулсан суурь өгөгдөл болон хяналт шинжилгээний батлагдсан аргачлалыг ашиглах нөхцөлд хөтөлбөрийн хүрээнд хэрэгжих төслийн үйл ажиллагааг бие даасан ЦХМ төслийн үйл ажиллагаа хэмээн бүртгэж болно. (Бүлэг 19)

**НЭМЭЛТ:** Нүүрсхүчлийн хийн хураалт болон хадгалалт (НХХ)

- ◆ ТБХ/ТХ нь геологийн тогтоцуудад НХХ хийх ЦХМ төслийн үйл ажиллагааны ТББ-ийн аргачлал зэрэг шинэ аргачлалын саналуудыг үргэлжлэн судлахыг ГЗ-д хүсэлт болгосон. ГЗ-ээс эдгээр аргачлалыг батлах нь ТБХ/ТХ-ын цаашдын холбогдох шийдвэрээс шалтгаална. [ТХ/2006/10/Н1, ху6 хэ19]
- ◆ ТБХ/ТХ нь 27-р чуулган дээрээ геологийн тогтоцуудад НХХ хийхийг ЦХМ төслийн үйл ажиллагаанд тооцох тухай зөвлөмж боловсруулж, ТБХ/ТХ3-т танилцуулахыг ШУТЗСХ-д даалгасан болон энэ талаар ТБХ/ТХ4 шийдвэр гаргана гэж төлөвлөж байна. [ТХ/2006/10/Н1, ху7 хэ24]

### Аргачлалын асуудалтай холбогдсон заавар, тодруулгын жишээ

**Ноу-хау дамжуулах болон сургалтын талаарх заавар [ГЗ 23 Тай, хэ80]**

Ноу-хау дамжуулалт болон сургалтыг тэр байдлаар нь ЦХМ-ын төслийн үйл ажиллагаанд тооцохгүй гэж ГЗ-өөр шийдвэрлэв. Ноу-хау дамжуулалт болон сургалтын үр дүнд хэрэгжих төслийн үйл ажиллагаа нь зөвхөн тухайн төсөлд хамаарах, хэмжигдэхүйц ялгаралтын бууралтад түшиглэн ЦХМ төсөлд тохирох эсэхийг тогтооно.

**Бункерийн түлшний талаарх заавар [ГЗ 25 Тай, хэ58]**

Бункерийн түлшний зарцуулалт багассантай холбогдсон (жишээ нь, олон улсын далайн тээвэрлэлтийн замын урт багассантай холбоотой г.м) ялгаралтын бууралт бий болгох төслийн үйл ажиллагаа болон түүний хэсгийг ЦХМ-д тооцохгүй гэдгийг ГЗ-өөр тохирсон болно.

**Төслийн явцад бий болсон бүтээгдэхүүнийг ашигласны улмаас ялгаралтын хэмжээг бууруулах төслийн үйл ажиллагаа [ГЗ 36 Тай, хэ16]**

Тухайн төслийн хүрээнд бий болсон бүтээгдэхүүнийг ашигласны үр дүнд ялгаралтын хэмжээг бууруулах төслийн үйл ажиллагаа нь дараахь нөхцлийг хангасан тохиолдолд л ЦХМ-ын төслийн үйл ажиллагаанд тооцогдох болно гэдгийг ГЗ тодотгов. Үүнд: (1) бүтээгдэхүүний хэрэглэгчид нь тухайн төслийн хүрээнд хамрагдсан, (2) бодит хэрэглээ, ашиглалт болон тухайн бүтээгдэхүүнийг хэрэглэгчид хэрэглэж, ашигласан газарт мониторинг явагдсан гэсэн нөхцлүүд багтана. Ийм тохиолдолд, тухайн бүтээгдэхүүний бодит хэрэглээ, ашиглалт болон байршилд мониторинг хийхдээ түүвэр судалгааны аргыг ашиглаж болно.

**“Одоо байгаа” болон “шинээр баригдсан” байгууламжийн талаарх заавар [ГЗ38 X1, хэ10]**


Хэрэм ЦХМ төслөөр одоо байгаа байгууламжийг сэргээх, сунгах бол төслийн суурь өгөгдөл нь одоогийн байгаа байгууламжийн суурилагдсан хүчин чадлыг нэмэгдүүлэхгүй, эсвэл ашиглалтын хугацааг нь уртасгахгүй байх үеийн үзүүлэлтийн (ө.х. ялгаралтын) хэмжээгээр хязгаарлагдана. Төслийн үр дүнд бий болох суурилагдсан хүчин чадлын нэмэгдэл буюу уртассан ашиглалтын хугацаанд өөр суурь хувилбар ашиглана.

**Усан цахилгаан станцын эрчим хүчний нягтралтай холбогдох босгоны тодорхойлолт [ГЗ323 X5]**

Усан сангаас ялгарах ХүХ-н талаар шинжлэх ухааны нэгдсэн дүгнэлтэд хүрээгүй байгаа бөгөөд энэ асуудал ойрын хугацаанд шийдвэрлэгдэх боломжгүйг харгалзан, эрчим хүчний нягтрал (суурилагдсан эрчим хүчийг усан сан болгох гадаргуугийн талбайд хуваасан хэмжээ: Вт/м<sup>2</sup>)-д үндэслэн усан цахилгаан станцын ЦХМ төсөлд хамрах эсэхийг тодорхойлох энгийн, ил тод босго тогтоосон байна. Үүнд:

- ☛ 4 Вт/м<sup>2</sup>-аас доош эрчим хүчний нягтралтай бол одоогийн мөрдөгдөж буй аргачлалуудыг ашиглах боломжгүй;
- ☛ Эрчим хүчний нягтрал нь 4 Вт/м<sup>2</sup>-аас их, гэхдээ 10 Вт/м<sup>2</sup>-аас бага буюу тэнцүү бол одоогийн мөрдөж буй аргачлалуудыг төслийн усан сангийн ялгаралтын фактор 90 грСО<sub>2</sub>/кВтцаг байхаар тооцож хэрэглэнэ;
- ☛ Эрчим хүчний нягтрал нь 10 Вт/м<sup>2</sup>-аас их бол одоогийн мөрдөгдөж буй аргачлалуудыг ажиглаж болохын зэрэгцээ төслийн усан сангийн ялгаралтыг хэрэгсэхгүй байж болно.

## 6. Төслийн баримт бичиг (ТББ) боловсруулах нь





ТББ болон аргачлалтай холбоотой маягтууд

		ЦХМ –ын хэвийн хэмжээний төслийн үйл ажиллагаа		ЦХМ –ын жижиг төслийн үйл ажиллагаа		
Ялгаралтын бууралт	ТББ	ЦХМ-ТББ хув.3.1 (Х.1-1)	ЦХМ Төслийн баримт бичиг	ЦХМ-ЦЖТ-ТББ хув.3 (Х.1-2)	Жижиг төслүүдэд зориулсан ЦХМ төслийн баримт бичиг	
		ЦХМ-ХҮА-ББ хув.1	Хөтөлбөрт үйл ажиллагааны баримт бичиг	ЦХМ-ЦЖТ-ХҮА-ББ хув.1	Жижиг ЦХМ Хөтөлбөрт үйл ажиллагааны төслийн баримт бичиг	
		ЦХМ-ЦХҮа-ББ хув.1	ЦХМ Хөтөлбөрт үйл ажиллагааны баримт бичиг	ЦХМ-ЦЖТ-ЦХҮа-ББ хув.1	Жижиг ЦХМ Хөтөлбөрт үйл ажиллагааны төслийн баримт бичиг	
	Аргачлал	М-ЦХМ-БАр-Мэд хув.2	ТМБ-аас АК-д хандан батлагдсан аргачлалыг ашиглах тухай санал тавих маягт			
		М-ЦХМ-БАр-Өөрч хув.1	АК-д хандан батлагдсан аргачлалд засвар өөрчлөлт оруулах санал гаргах маягт			
		ЦХМ-ШАр хув.2	ЦХМ санал болгож буй шинэ аргачлал: суурь болон хяналт шинжилгээ	М-ЦХМ-ЦЖТ-ШАр хув.1	Шинэ жижиг төслийн аргачлал санал болгох маягт	
О/НС (Бүл.18)	ТББ	ЦХМ-О/НС-ТББ хув.4	О/НС төслийн ЦХМ Төслийн Баримт бичиг	ЦХМ-ЦЖТ-О/НС-ТББ хув.2	Жижиг О/НС төслийн баримт бичгийн маягт	
		ЦХМ-ХҮА-ББ-О/НС хув.1	О/НС төслийн Хөтөлбөрт үйл ажиллагааны Баримт бичиг	ЦХМ-ХҮА-ББ-ЦЖТ-О/НС хув.1	ЦЖТ-О/НС төслүүдэд зориулсан Хөтөлбөрт үйл ажиллагааны төслийн баримт бичиг	
		ЦХМ-ЦХҮа-ББ-О/НС хув.1	О/НС төслийн ЦХМ Хөтөлбөрт Үйл ажиллагааны баримт бичиг	ЦХМ-ЦХҮа-ББ-ЦЖТ-О/НС хув.1	ЦЖТ-О/НС төслийн үйл ажиллагаанд зориулсан ЦХМ Хөтөлбөрт үйл ажиллагааны баримт бичиг	
	Аргачлал	М-ЦХМ-О/НС-БАр-Мэд хув.1	ТМБ-аас О/НС Аргачлалыг ашиглах тухай санал авахаар О/НС Ажлын хэсэгт хүргүүлэх маягт			
		М-ЦХМ-О/НС-БАр-Өөрч хув.1	О/НС Ажлын хэсэгт Батлагдсан Аргачлалд засвар өөрчлөлт оруулах хүсэлтийгн маягт			
		ЦХМ-О/НС-ШАр хув.3	ЦХМ санал болгож буй шинэ аргачлал: О/НС-ын суурь өгөгдөл болон хяналт шинжилгээ			
Гажилт (бүл.14)	М-ЦХМ-Гаж хув.2	Гажилт хийх хүсэлтийн маягт				


ТББ: [http://CDM.unfccc.int/Reference/PDDs\\_Forms/PDDs/index.html](http://CDM.unfccc.int/Reference/PDDs_Forms/PDDs/index.html) [http://CDM.unfccc.int/Reference/PDDs\\_Forms/PoA/index.html](http://CDM.unfccc.int/Reference/PDDs_Forms/PoA/index.html)  
 Аргачлал: [http://CDM.unfccc.int/Reference/PDDs\\_Forms/Methodologies/index.html](http://CDM.unfccc.int/Reference/PDDs_Forms/Methodologies/index.html); Гажилт : [EB24 Anx30]

## 7. Суурь өгөгдөл

### 7-1. Суурь өгөгдөл болон нэмэгдэл чанарын тухай ойлголт

- ◆ ЦХМ төслийн суурь өгөгдөл (хувилбар болон ялгаралт) гэдэг нь тухайн санал болгож буй төслийн үйл ажиллагаа хэрэгжихгүй тохиолдолд ялгарах ХҮХ-г үндэслэлтэйгээр тооцон харуулсан байдал юм. [ТХ/2005/8/Н1, ху16 хэ44]

ХҮХ-н ялгаралт



- ◆ Суурь ялгаралт болон төсөл хэрэгжсэний дараах ХҮХ-н ялгаралт (төслийн ялгаралт)-ын зөрүүг ялгаралтын бууралт гэнэ.

- ☞ Суурь өгөгдөл (хувилбар болон ялгаралт)-г дараах байдлаар тогтооно.
  - (а) Батлагдсан, эсвэл шинэ аргачлалын заалтын дагуу ТО-чид тогтооно;
  - (б) Арга барил, төсөөлөл, аргачлал, өгөгдөхүүн, мэдээллийн эх сурвалж, үндсэн хүчин зүйл болон нэмэгдлийг ил тод, болгоомжтой байдлаар сонгохын зэрэгцээ тодорхой бус нөхцөл байдлыг мөн харгалзан үзнэ;
  - (в) Төсөл тус бүрээр тогтооно;
  - (г) ЦХМ-ын жижиг төслийн хувьд, тэдгээрт зориулан боловсруулсан хялбарчилсан журмын дагуу;
  - (д) Тухайн салбарын өөрчлөлт шинэчлэл, дотоодын түлшний хангамж, эрчим хүчний салбарын хөгжлийн төлөвлөгөө, төсөл хамаарах салбарын эдийн засгийн байдал зэрэг үндэсний болон салбарын бодлого, нөхцөл байдлыг харгалзан тодорхойлно. [ТХ/2005/8/Н1, ху16 хэ45]
- ☞ Суурь ялгаралтыг тооцохын өмнө суурь хувилбаруудыг тодорхойлох шаардлагатай.
- ☞ Суурь өгөгдөл (ялгаралт) нь төслийн хил хязгаарт багтах бүх салбар, эх сурвалжийн ялгаруулах бүх төрлийн хийн хэмжээг багтаана. [ТХ/2005/8/Н1, ху16 хэ44]

- ◆ Хэрэв ЦХМ төслийн үйл ажиллагаа хэрэгжсэний дараах ХҮХ-н ялгаралтын хэмжээ тэрхүү үйл ажиллагаа хэрэгжихгүй тохиолдолд ялгарах хэмжээнээс буурч байвал тухайн ЦХМ төслийн үйл ажиллагааг **нэмэгдэл чанартай** гэж үзнэ. [ТХ/2005/8/Н1, ху16 хэ43]
  - ⇒ ТМБ нь төслийн үр дүнд бий болох ХҮХ-н ялгаралт нь санал болгож буй төслийн үйл ажиллагаа хэрэгжихгүй тохиолдолд ялгарах хэмжээнээс **нэмэгдэл** бууралт бий болгохыг тодруулах зорилгоор ТББ-г хянан үзнэ. [ТХ/2005/8/Н1, ху14 хэ37(г)]
- ◆ Төсөл хэрхэн, яагаад **нэмэгдэл чанартай** болох буюу тухайн сонгосон суурь өгөгдлийн аргачлалаар нягтлахад суурь хувилбар биш болохыг ТО тайлбарлан бичнэ. [ТББ Е3 хув6.2, ху11]
  - ⇒ Хэрэв төслийн үйл ажиллагаа хэрэгжиж эхэлсэн өдөр нь магадлагаа хийгдсэн өдрөөс өмнө бол, уг төслийг хэрэгжүүлэх шийдвэр гаргахад ЦХМ-ын урамшууллыг нухацтай харгалзан үзсэн болохыг батлах баримт гаргана. Энэ баримтыг төсөл эхлэхэд эсвэл өмнө нь боловсруулсан (албан ёсны, хуулийн эсвэл компанийн батламжилсан бичиг байвал зүгээр) бичиг баримтанд үндэслэнэ. [ТББ хую6.2, ху11]
- ◆ “Нэмэгдэл чанарыг батлах, үнэлэх арга” нь түүнийг тодорхойлох, үнэлэх ерөнхий арга горимыг заасан агаад ТО нь өөр арга горимыг санал болгож болно. [Г322 X8 хэ1]

**НЭМЭЛТ: Үг хэллэг**  
ТО нь ТБХ-ын баримт, ЦХМ-ын нэр томъёоны тайлбарт ороогүй үндсэн үг хэллэг ашиглах, өөрийн нэр томъёоны тайлбар хавсаргах зэргээс зайлсхийвэл зохино. (байгаль орчин/хөрөнгө оруулалтын **нэмэгдэл чанар** гэх мэт)  
[Г309 X3, хэ3]

## 7-2. Суурь хувилбар

- ◆ ЦХМ төслийн суурь хувилбар гэдэг нь тухайн санал болгож буй төслийн үйл ажиллагаа хэрэгжихгүй тохиолдолд ялгарах ХүХ-г үндэслэлтэйгээр тооцон харуулсан байдал юм. [НэрТ, хув3, ху10]
- ◆ Санал болгож буй ЦХМ төслийн үйл ажиллагаа хэрэгжихээс өмнө тухайн нөхцөл байдал хэрхэн өөрчлөгдөж болох талаар хэд хэдэн хувилбарыг тодорхойлж болно.
  - ☞ Одоогийн нөхцөл байдал хэвээр үргэлжлэх хувилбар байж болно;
  - ☞ Санал болгож буй төслийн үйл ажиллагааг өөр байдлаар хэрэгжүүлэх хувилбар байж болно;
  - ☞ Өөр бусад хувилбаруудыг тодорхойлж болно.
- ◆ Суурь өгөгдлийн аргачлалыг тодорхойлохын тулд байж болох бүх суурь хувилбарыг тодорхойлох шаардлагатай.
- ◆ Харилцан адилгүй хувилбаруудыг боловсруулахын тулд харилцан адилгүй хүчин зүйлсийг авч үзнэ.
  - ☞ Жишээ нь, ТО-д үндэсний/салбарын бодлого, нөхцөл байдал, технологийн хөгжил дэвшил, хөрөнгө оруулалтын саад гэх мэт хүчин зүйлүүдийг харгалзан үзсэн байх ёстой.
- ◆ Хүлээн авагч Талын зарим нөхцөл байдлаас улбаалан ХүХ-н ялгаралт одоогоос өсөх хувилбар нь мөн суурь хувилбарын жишээ байж болно. [ТХ/2005/8/Н1, ху16 хэ46]

## Суурь хувилбарыг тодорхойлоход үндэсний болон салбарын бодлого, дүрэм журмыг хэрхэн тусгах тухай тайлбар

Суурь хувилбарыг тодорхойлоход харгалзвал зохих үндэсний болон салбарын бодлогыг 2 үндсэн төрөлд ангилахыг ГЗ-ээс зөвшөөрсөн аж: [Г322 Х3]

**Я+ төрөл** Ялгаралт ихтэй технологи, түлшний ашиглалтанд харьцангуй давуу талыг олгох

- ☞ Суурь хувилбарыг боловсруулахад зөвхөн Киотогийн протокол зурагдсан (1997 оны 12-р сарын 11) өдрөөс өмнө хэрэгжиж эхэлсэн үндэсний болон салбарын бодлого, зохицуулалтуудыг харгалзана.
- ☞ Хэрэв ийм үндэсний болон салбарын бодлого нь Киотогийн протокол зурагдсанаас хойш батлагдсан бол суурь хувилбарт эдгээр бодлого, зохицуулалтууд мөрдөгдөөгүй байх хийсвэр нөхцөл байдлыг авч үзнэ.

**Я- төрөл** Ялгаралт багатай технологид харьцангуй давуу талыг олгох (Жишээ нь, сэргээгдэх эрчим хүчний хэрэглээг дэмжих татаас олгох, эрчим хүчний ашиглалтыг сайжруулах хөтөлбөр санхүүжүүлэх гэх мэт).

- ☞ ТБХ-аас ЦХМ-ын дэг, журмыг баталсан (2001 оны 11-р сарын 11) өдрөөс хойш хэрэгжсэн үндэсний болон салбарын бодлого, дүрэм журмыг суурь хувилбар боловсруулахад харгалзахгүй.
  - ⇒ Өөрөөр хэлбэл, суурь хувилбарт эдгээр бодлого, зохицуулалт мөрдөгдөөгүй байх хийсвэр нөхцөл байдлыг авч үзэж болно.

## 7-3. Суурь өгөгдлийн аргачлал

◆ Тухайн суурь хувилбар дахь суурь ялгаралтын хэмжээг ТО **батлагдсан аргачлал (БАр)** эсвэл **шинэ аргачлал (ШАр)**-н дагуу тооцно.

◆ Аль ч аргачлалд урьдчилан хориг тавихгүй тул ТО нь ямар ч аргачлалыг санал болгох эрхтэй байна. [НэрТ, хув3, ху8]

ГЗ-ийн баталсан суурь өгөгдлийн аргачлал болон холбогдох зааврыг НҮБҮӨСК ЦХМ-ын вэб хуудсаас авч болно (<http://unfccc.int/ЦХМ>). [НэрТ, хув3, ху9]

☞ ТМБ нь батлагдсан аргачлалыг ашиглаж болох эсэх талаар лавлагаа хүсч болно.

Хэрэв тухайн санал болгож буй төслийн үйл ажиллагаанд шинэ суурь өгөгдлийн аргачлал ашиглах шаардлагатай хэмээн ТМБ тогтоосон бол төсөл бүртгүүлэх хүсэлт гаргахаас өмнө тухайн аргачлалыг ГЗ-д хүргүүлж хянуулах буюу шаардлагатай бол батлуулна. [Г332 X13, хэ2]

☞ “Суурь өгөгдөл, хяналт шинжилгээний шинэ аргачлал боловсруулах техникийн заавархувилбар 01” гэж бий [Г324 X16]

◆ Суурь өгөгдлийн аргачлалаар боловсруулсан суурь хувилбар болон суурь ялгаралтыг тооцох журам, томъёонууд хоорондоо уялдаатай байх нь чухал. [ТББ Е3 хув6.2, ху24]

**Суурь арга (ЦХМ Д/Ж-ын 48-р хэсэг)** [НэрТ, хув3, ху8][ТХ/2005/8/Н1, ху16 хэ48]

Суурь арга нь суурь өгөгдлийн үндэс юм. ЦХМ төслийн үйл ажиллагааны хувьд зөвхөн дараах 3 аргыг ашиглахыг ГЗ-өөр зөвшөөрчээ. Үүнд:

(а) Өмнөх юм уу одоогийн бодит ялгаралтын аль тохирох нь;

(б) Эдийн засгийн хувьд үр ашигтай (үүнд хөрөнгө оруулалтын саад бэрхшээлийг тооцсон байна) технологийн үр дүнд бий болох ялгаралт;

(в) Ижил төстэй нийгэм, эдийн засаг, байгаль орчин, техник технологийн нөхцөл байдалд өмнөх 5 жилд хэрэгжсэн, үр дүнгээрээ тухайн төрөлдөө хамгийн сайн 20 хувьд багтах ижил төстэй төслийн дундаж ялгаралт. <[Г308 X1 хэ4-5]-г үзнэ үү>

**Нэмэлт: “Сөрөг ялгаралтын бууралт”-д хүрэх түр үр дүн** [Г321 Тай, хэ18]

☞ Зарим тохиолдолд, эсвэл зарим аргачлалаар төслийн үйл ажиллагаа нь тодорхой жилд “сөрөг ялгаралтын бууралт”-ын үр дүнд хүрч болно. Жишээ нь, үйл ажиллагааны үр дүн муу байх, эсвэл нэвчилт нь ялгаралтын бууралтаас илүү гарах зэрэг г.м.

☞ Энэ тохиолдолд, шинэ аргачлал боловсруулахдаа хэрэв төслийн үйл ажиллагаа түр хугацаагаар “сөрөг ялгаралтын бууралт”-д хүрэхээр бол цаашид олгох ЯББ-ыг зөвхөн уг ихэссэн ялгаралтыг тухайн төслийн үйл ажиллагааны дараагийн ялгаралтын бууралтаар нөхөн төлсөн тохиолдолд л олгож байх талаар заагдсан байх ёстой.

**Нэмэлт: Нэгээс олон аргачлал ашиглах төслийн үйл ажиллагааны санал** [Г308 X1, хэ6]

☞ Хэрэв санал болгож буй төсөл нь хэд хэдэн “дэд үйл ажиллагаанаас” бүрдэн, тус бүр өөр өөр аргачлал ашиглах шаардлагатай бол ТО тухайн төслийн аргачлалын хэсгийг “дэд үйл ажиллагаа” бүрээр хийн нэг ЦХМ-ТББ хийж болно.

## 7-4. Шинэ аргачлал (ШАр)-ын санал өргөн мэдүүлэх журам

(1) Суурь өгөгдөл болон хяналт шинжилгээний шинэ аргачлалууд (ШАр)-ыг хамтад нь өргөн мэдүүлж, батлуулна. ШАр саналыг “ЦХМ-ШАр” маягтын дагуу, А-В хэсгүүдийг нь бөглөсөн ТББ-г холбогдох хавсралтуудын хамт өргөн мэдүүлнэ. Хэд хэдэн хэсгээс бүрдэх төслийн хувьд, хэсэг тус бүрт хамаарах шинэ аргачлалыг ЦХМ-ШАр-ын нэг маягтаар ижил ЦХМ-ТББ-ын хамт мэдүүлж болно. [Г324 Х16, хэ1]

(2) ТМБ/ӨГ нь ШАр мэдүүлэхийн өмнө түүнд сайн дураар урьдчилсан үнэлгээ хийж болно. Хэрэв ийм урьдчилсан үнэлгээ хийгдсэн бол 5-р хэсэгт заасан Аргачлалын комиссоор урьдчилсан үнэлгээ хийлгэх шаардлагагүй болно.

Энэ тохиолдолд, өргөн мэдүүлсэн аргачлалыг (3) болон (4) алхам хийгдсэний дараа хүлээн авсанд тооцно.

(3) ТО нь ердийн төслийн үйл ажиллагаанд ШАр өргөн мэдүүлэхэд 1,000 ам.долларын хураамж авна.

- Хэрэв аргачлал нь батлагдаж, тухайн төсөл бүртгэгдвэл бүртгэлийн хураамжийг энэ хэмжээгээр бууруулна.
- Хэрэв санал болгож буй аргачлалыг мөрдөгдөж буй БАр-д болон бусад аргачлалуудтай нэгтгэвэл төлбөрийг буцаан олгоно.
- Энэ нь жижиг төсөл болон ойжуулалт, ой нөхөн сэргээх төслийн үйл ажиллагаанд хамаарахгүй.

(4) ТМБ-ын мэдүүлсэн баримт бичгийн бүрдэл болон мэдүүлгийн хураамж төлсөн баримтыг хүлээн авсан эсэхийг НБДН газар хянаана. НБДН газар нь ЦХМ-ын шинэ аргачлалын үнэлгээны маягт (М-ЦХМ-ШАр-үнэл)-ий дагуу ирүүлсэн мэдүүлэгт урьдчилсан үнэлгээний төсөл хийж, ТО-аас ирүүлсэн баримтуудын хамт АК-ийн нэг гишүүнд хянуулахаар өгнө.

(5) Уг гишүүн нь мэдүүлгийг нягтлан, маягт (М-ЦХМ-ШАр.үнэл)-д заагдсан урьдчилсан үнэлгээ хийх шалгуурын дагуу 1 эсвэл 2 гэсэн үнэлгээ өгнө.

- Хэрэв 2 гэж ангилсан бол мэдүүлгийг ТО-д буцаах бөгөөд түүнийг дахин 1,000 ам.долларын хураамж төлөн, ШАр-н саналаар өргөн мэдүүлж болно.
- Хэрэв 1 гэж ангилсан бол мэдүүлгийг ГЗ хүлээн авсанд тооцон, ГЗ болон АК-оор хэлэлцүүлэхээр хүргүүлнэ.

ШАр-н санал хүлээн авсан өдөр

(6) Мөн, НБДН газар нь мэдүүлсэн ШАр-г НҮБУӨСК-ийн ЦХМ-ын вэб хуудсанд байрлуулж, олон нийтээс (о/н) “М-ЦХМ-ШАр-о/н” маягтын дагуу санал авах ажлыг **15 ажлын өдрийн** хугацаатайгаар явуулна. Ирүүлсэн саналыг тэр даруйд нь АК-ийн гишүүдэд хүргүүлж, 15 хоногийн хугацаа дуусмагц олон нийтэд танилцуулна.

(7) ШАр-ын мэдүүлэг хүлээн авмагц АК-ийн 4 гишүүн (түүний 1 нь ахлагч байх бөгөөд хуралд санал танилцуулна) НБДН газраас бэлтгэсэн саналын төслийг хянан үзнэ.

- Гишүүдийг цагаан толгойн дэс дарааллаар ээлжлэн сонгоно.
- НБДН газар нь мөн тусдаа АК-ийн хурлаар хэлэлцэх саналын төсөл бэлтгэх үүрэгтэй.
- НБДН газар нь ТО-оос нэмэлт шаардлагатай техникийн мэдээллийг тодорхой хугацаа заан гаргуулан авч болно.

[Г337 Х3][Хувилбар 13 / 2008 оны 2 сарын 1]

(8) АК-ын Дарга, Дэд дарга нь НБДН газар болон 4 сонгогдсон гишүүдийн тусламжтайгаар ШАр хүлээн авснаас хойш **7-оос илүүгүй ажлын өдрийн** дотор мэргэжилтний багаас тухайн аргачлалын үндэслэлд дүн шинжилгээ хийх 2 шинжээчийг сонгох бөгөөд тэдгээрийн нэг нь ахлагч байна. 2 шинжээч тайлангаа тус тусдаа бэлтгэнэ.

(9) Шинжээчид санал болгож буй ШАр хүлээн авснаас хойш, боломжтой бол **10 ажлын өдрийн** дотор, ахлагч нь “М-ЦХМ-ША ши\_3”, хоёрдахь шинжээч нь “М-ЦХМ-ША ши\_2” маягтуудыг тус тус бөглөж, АК-т өөрсдийн саналыг тусад нь хүргүүлнэ.

(10) АК нь мэдүүлж буй ШАр-г батлах эсэх талаар зөвлөмж боловсруулж, “М-ЦХМ-ШАак” болон түүний хураангуй “М-ЦХМ-ШАХУРаК” маягтуудыг бөглөж ГЗ-д хүргүүлнэ.

- Урьдчилсан зөвлөмж боловруулахаасаа өмнө НБДН газар нь мэдүүлж буй ШАр-д үнэлгээ хийхэд дэмжлэг болох техникийн холбогдолтой мэдээллийг АК-ийн нэрийн өмнөөс гишүүд, ТМБ болон ТО-оос тодорхой хугацаа заан гаргуулж авч болно.
- ТО-оос АК-д ирүүлсэн нэмэлт техникийн мэдээллийг НБДН газар хүлээн авсан даруйд ГЗ болон олон нийтэд танилцуулна.

(11) АК нь НБДН газар болон ТМБ-аар дамжуулан ТО-д урьдчилсан зөвлөмж хүргүүлнэ.

Дараагийн хуудаст

## 7-4. ШАр-ын санал өргөн мэдүүлэх журам

(12) АК-ын урьдчилсан зөвлөмжид заасан асуудалтай холбоотой техникийн тайлбаруудыг тухайн заасан хугацаанд, гэхдээ АК-өөс ТО урьдчилсан зөвлөмж хүлээн авснаас хойш **4 долоо хоногийн** дотор, ТО нь ТМБ-ын нэрийн өмнөөс НБДН газраар дамжуулан АК-д хүргүүлж болно. ТО-н мэдүүлэх техникийн тайлбарт ЦХМ-ШАр тодруулсан өөрчлөлт орсон байна.

- Төсөлд оролцогчдоос АК-д ирүүлсэн нэмэлт техникийн тайлбарыг НБДН газар хүлээн авсан даруйд ГЗ болон олон нийтэд танилцуулна.

(13) Хэрэв ТО нь АК-ийн урьдчилсан зөвлөмжийн дагуу тайлбар ирүүлсэн бол АК нь тэдгээр тайлбарыг **удаах хурлаараа** хэлэлцэн, ГЗ-д танилцуулах эцсийн зөвлөмжөө боловсруулна.

- Эцсийн зөвлөмжийг ГЗ-д хүргүүлж, нийтэд танилцуулна.
- Хэрэв ТО-д АК-аас гаргасан урьдчилсан зөвлөмжийн дагуу холбогдох тодруулгыг 3 сарын дотор гаргаж ирүүлээгүй бол тухайн саналыг татан авсанд тооцно.

(14) ГЗ нь ШАр-ын саналыг АК-ийн дэмжих /А үнэлгээ/, үл-дэмжих /Д үнэлгээ/ талаарх эцсийн зөвлөмжийг хүлээн авсны **удаах хурлаараа** хэлэлцэнэ.

ГЗ баталсан бол тус батлагдсан аргачлал (БАр)-г нийтэд мэдээлэн, ТМБ нь төслийн магадлагаа хийх, ТББ бүртгүүлэхээр мэдүүлгээ өгөх боломжтой болно.

**НЭМЭЛТ: АК-оос анализ/зөвлөмж гаргах болон ГЗ-өөр авч хэлэлцэх/зөвшөөрөл гаргах хугацаа**

- Санал болгож буй ШАр-г АК-ийн **удаах хурлаас наад зах нь 10 долоо хоногийн өмнө** хүргүүлсэн байвал зохино.
- Заасан хугацаанд 10-аас олон ШАр өргөн мэдүүлсэн тохиолдолд АК-ийг удаах хурлаар хэдэн ШАр хэлэлцэх, хэдийг нь хойшлуулахыг АК-ийн Дарга шийднэ.
- АК нь боломжтой бол удаах хурлаасаа ГЗ-д зөвлөмж гаргаж хүргүүлнэ. АК нь өөрийн 2 удаагийн хурлын явцад ГЗ-д зөвлөмж гаргаж хүргүүлнэ.
- Мэдүүлсэн аргачлалуудыг “Түрүүлж ирсэнд түрүүлж үйлчилнэ” зарчмаар хэлэлцэнэ.
- ГЗ нь АК-ийн ажлын ачааллыг харгалзан, санал болгох ШАр өргөн мэдүүлэх хугацааг өөрчилж болно.
- ГЗ нь боломжтой бол **удаах хурлаараа**, үгүй бол санал болгож буй ШАр хүлээн авснаас хойш **4 сараас хэтрэхгүй хугацаанд** ЦХМ Д/Ж-ын дагуу тухайн ШАр-г хянан үзнэ.

- “Аргачлал хэлэлцэх процесст хийх өөрчлөлт” гэсэн зааварчилгаа нь ЦХМ-ын аргачлал, заавар, удирдамжийг батлахад шаардлагатай асуудлууд болон цаг хугацааны интервалыг зааж өгдөг. Комисс, ГЗ-ын ажлын хэсгүүдийн ажлын ачааллыг жигд байлгахын үүднээс гүйцэтгэлд тулгуурласан урамшууллын системийг нэвтрүүлэх замаар хүний нөөцийг үр ашигтай ашиглахад энэ зааварчилгаа чиглэгдсэн болно. [ГЗ 32 Х12]
- ГЗ нь Хөтөлбөрт үйл ажиллагааны хүрээнд баталсан аргачлал нь ЦХМ-ын төслийн үйл ажиллагаа болон ЦХМ-ын хөтөлбөрт үйл ажиллагааны аль алинд ашиглагдах болохыг тодотгов (Бүл.19). Мөн түүнчлэн, ГЗ-д хэлэлцүүлэхээр санал болгон хүргүүлсэн ШАр нь тухайн аргачлалыг ашиглах үйл ажиллагааг маш тодорхой зааж өгсөн байх ёстойг ГЗ-өөс тодотгож өгөв. [ГЗ 35 Тай, хэсэг15]
- “ЦХМ-д хамаарах Ойжуулалт, ой нөхөн сэргээх төслийн үйл ажиллагааны шинэ аргачлалыг өргөн мэдүүлэх болон хэлэлцэх журам (хувилбар 07)” гэж бий. [ГЗ37 Х4]

## 7-5. Батлагдсан аргачлал (БАр) болон зааварт засвар өөрчлөлт оруулах журам

**БАр-д засвар өөрчлөлт оруулах хүсэлт гаргах нь** [Г330 X1, хэ5-9]

- ◆ БАр-д засвар өөрчлөлт оруулах шийдвэрийг ТО, сонирхлын бүлэг, ГЗ, АК эсвэл АХ зэргээс ирүүлсэн хүсэлтээр, холбогдох журмын сүүлийн хувилбарын заалтын дагуу гаргана.
- ◆ Дараах тохиолдолд ийм хүсэлт гаргаж болно. Үүнд:
  - ☞ Тухайн БАр төслийн үйл ажиллагаанд ашиглагдах боломжгүй, гэтэл тус төсөл нь тухайн БАр ашиглагддаг өөр төслүүдтэй ижил төстэй байх;
    - ⇒ Ижил төстэй чанарыг төслийн үйл ажиллагааны мөн чанар (технологи/арга) болон тухайн төсөлд хамрагдах ХүХ ялгаралтын эх үүсвэрээр тогтооно. Жишээ нь, тухайн төслийн үйл ажиллагаанд хамрагдах ХүХ ялгаралтын эх үүсвэр ижил хэдий ч тухайн төсөлд хэрэглэх технологи/арга нь тухайн БАр-д тусгагдаагүй байгаагаас түүнийг ашиглах боломжгүй байж болно.
  - ☞ Эсвэл, төслийн үйл ажиллагаанд сонгосон бүтэц, үйл явдлын өрнөл болон арга барил нь бага зэрэг ялгаатайн улмаас тухайн аргачлалд заасан ялгаралтыг эх үүсвэрээр нь тооцох журмыг ашиглах боломжгүй байх.
- ◆ Ашиглаж болох БАр байхгүй тохиолдолд, БАр-д засвар өөрчлөлт оруулах хүсэлт гаргаж болно.
  - ☞ Энэ тохиолдолд төслийн байж болох бүх хувилбарт ашиглагдах боломжтой болгохын тулд ихээхэн өөрчлөлт оруулах хэрэгтэй болно. Учир нь:
    - ⇒ Санал болгож буй төслийн үйл ажиллагаанд тухайн аргачлал ашигласнаар төслийн хил хязгаар буруу тодорхойлогдох, давхар тооцох, нэвчилтийг буруу бүртгэх, бодит бус, хэмжигдэхгүй, магадлагдахгүй эсвэл төсөл хэрэгжээгүй үеийн ялгаралтанд нэмэгдэл бус ялгаралтын бууралтыг бий болгох үр дүнд хүргэж болно.

**НЭМЭЛТ: Засвар өөрчлөлт хийснээр батлагдсан аргачлалыг эргэн татсан бол**

☞ Ийнхүү эргэн татах нь (а)тооцоот хугацаандаа байгаа тухайн аргачлалыг ашиглаж буй бүртгэгдсэн ЦХМ төсөл; болон (б) тухайн аргачлалыг ашиглан магадлагаа хийж, олон нийтийн санал асуулгын явцад буй төслийн үйл ажиллагааны хувьд аргачлалыг эргэн татсанаас хойш 8 сарын дотор бүртгүүлэхээр өргөн мэдүүлсэн бол тус тус нөлөөлөхгүй.

[Г335 X13, хэ17]

Хэрэв БАр-д засвар өөрчлөлт оруулснаар түүний агуулгын талаас илүүд нь шинэ журам, хувилбар нэмэхээр байвал, ТО нь ШАр санал болгож, батлуулах журмын хамгийн шинэ хувилбарын заалтын дагуу ШАр өргөн мэдүүлэх нь илүү зохистой юм.(Бүлэг 7-4)

Засвар өөрчлөлт оруулах тухай хүсэлтэд тухайн БАр-г өөр төслүүдэд ашиглах нөхцлийг хасах, хязгаарлах, нарийсгахад хүргэх агуулгатай байх ёсгүй. Хэрэв уг хүсэлт нь ийм үр дүнд хүргэхээр байвал тухайн ТО нь ШАр өргөн мэдүүлэх нь зохистой юм.

“Аргачлалыг нэгтгэх, засвар өөрчлөлт оруулах шалгуурын заавар” гэж бий. [Г327 X10]

7-5. БАр болон зааварт засвар өөрчлөлт оруулах журам

[Г335 Х13 хэ1-16] [Хувилбар 9]

(1) Суурь өгөгдөл, хяналт шинжилгээний батлагдсан аргачлал (БАр), зааварт өөрчлөлт оруулах хүсэлтэй ТО, энэ тухай хүсэлтээ АК-д (1) "М-ЦХМ-БАр-Өөрч" маягт, (2) санал болгож буй өөрчлөлтүүдийг нь тодруулсан БАр-н төсөл (3) А-В бүлгүүдийг бөглөсөн ТББ-г холбогдох хавсралтуудын хамт ТМБ-д хүргүүлнэ.

(2) ТМБ нь дээрх шаардлага хангагдсан эсэх, баримт бичиг бүрэн гүйцэд болохыг шалгасны дараа материалыг НБДН газарт хүргүүлнэ.

(3) НБДН газар нь (а) маягт зөв бөглөгдсөн, (б) ТМБ-ын бүрдүүлсэн бичиг баримт бүрэн гүйцэд болохыг шалгасны дараа ГЗ болон АК-д хүргүүлнэ. НБДН газраас ГЗ-д шилжүүлсэн өдөр нь ГЗ БАр-д засвар өөрчлөлт оруулах тухайн хүсэлтийг хүлээн авсан өдөрт тооцогдоно.

(4) Аргачлалд засвар, өөрчлөлт оруулах саналаас шалтгаалан, АК эсвэл ГЗ нь НБДН газарт хүсэлт тавьж, нийтийн өмчит саналыг тухайн засвар өөрчлөлт оролцуулах эсэхийг 15 ажлын өдрийн дотор шийдэх эрхтэй.

(5) АК-ын Даргын удирдлаган дор АК-ын нэг гишүүн томилогдож, НБДН газраас боловсруулсан зөвлөмжийн төслийг хянана. Илүү нарийвчилсан хэлэлцүүлэг шаардлагатай тохиолдолд, Дарга дахин нэг гишүүнийг сонгон томилох эрхтэй.

(6) Хэрэв хүсэлтийг АК-ийн дараагийн уулзалтаас дор хаяж 6-аас доошгүй долоо хоногийн өмнө НБДН газарт хүргүүлсэн бөгөөд АК-ийн хувьд боломжтой бол хүсэлтийг дараагийн хурлаар хэлэлцэнэ.

(7) АК нь зохих үндэслэлтэйгээр, БАр-г өөрчлөх, эсвэл ялимгүй өөрчлөлт, засвартайгаар үргэлжлүүлэн ашиглах зөвлөмж гаргана.

(8) АК нь зөвшөөрөл өгөх явцыг оновчтой нийцтэй байлгахын үүднээс ШАр-ын саналуудыг судалсан туршлагад үндэслэн зөвлөмж гаргах эрхтэй. БАр-д засвар өөрчлөлт оруулах саналын тухай мэдээллийг НҮБҮӨСК-ийн ЦХМ-ын вэб хуудсанд байрлуулах бөгөөд зөвлөмжийг төслийг ГЗ-д жагсаалтаар, олон нийтэд ЦХМ-ын шинэ мэдээ хүргэх хэрэгслээр дамжуулан хүргэнэ.

(9) АК нь хүсэлтийг хүлээн авах эсэх талаар ГЗ-д зөвлөмж гаргах бөгөөд, хүлээн авах тохиолдолд шинэчлэгдсэн БАр-ын хувилбарын хамт өгнө.

(10) ГЗ нь БАр болон аргачлалд хамааралтай хэрэгсэлд засвар өөрчлөлт оруулах зөвлөмжийг дараагийн хуралаараа АК-аар хэлэлцүүлэх ёстой.

(11) ГЗ БАр-д орсон засвар өөрчлөлтийг баталсан тохиолдолд өмнөх аргачлалыг энэ аргачлалаар солино. Засвар өөрчлөлт нь ГЗ-ын тайлан зөвлөгдөн гарснаас хойш 5 хуанлийн өдрийн дотор НҮБҮӨСК-ийн вэб хуудсанд байрлах ёстой бөгөөд энэ өдрөөс хойш хуанлийн 14 дэх өдрөөс эхлэн хүчинтэйд тооцогдоно.

НЭМЭЛТ: БАр-д засвар өөрчлөлт оруулах

БАр-д засвар өөрчлөлт оруулах нь (а) тооцоот хугацаандаа буй бүртгэгдсэн ЦХМ төсөл; (б) тухайн аргачлалыг ашиглан магадлагаа хийж, нийтийн өмчит санал авч буй төслийн үйл ажиллагааны хувьд аргачлалд орсон өөрчлөлт мөхдөгдөж эхэлснээс хойш 8 сарын дотор бүртгүүлэхээр өргөн мэдүүлсэн бол тус тус нөлөөлөхгүй. Засвар өөрчлөлт хүчин төгөлдөр болох өдөр нь НҮБҮӨСК-ийн вэб хуудсанд энэ тухай мэдээлэл нийтлэгдсэнээс хойшхи 14 дэх өдөр байхын зэрэгцээ ГЗ-ийн тайлан нийтлэгдсэнээс хойшхи хуанлийн 5 өдрийн дотор байна.

[Г332 Х13, хэ16-17]

Хэрэв ГЗ нь тухайн аргачлалд засвар өөрчлөлт оруулснаар түүний ашиглалтад ноцтой үр дагавар бий болгоно хэмээн үзвэл, тус аргачлалын ашиглалтыг "түр зогсоох" тухай нэн даруй мөрдөгдөж эхлэх шийдвэр гаргаж болно.

Тус аргачлалыг ашиглаж буй төслүүдийн хувьд хэрэв "түр зогсоох" шийдвэр гарснаас хойш 4 долоо хоногийн дотор бүртгүүлэхээр өргөдлөө гаргаагүй бол ГЗ-өөс тус аргачлалд засвар өөрчлөлт оруулах шийдвэр гаргахаас нааш тухайн аргачлалыг ашиглах боломжгүй болно.

Хэрэв ГЗ нь "түр зогсоох" шийдвэр гаргасан бол үүнээс хойш хамгийн оройдоо дараагийн 3 дахь хурлаар уг аргачлалын засвар өөрчлөлт орсон хувилбарыг батална.

[Г332 Х13, хэ18-20]

Дараахь зүйлүүд эдгээр журмуудын хувьд хамаарахгүй болно: хэрэв ТБХ/ТХ –ийн зүгээс БАр-д засвар өөрчлөлт оруулахыг хүссэн тохиолдолд ямар ч ЦХМ төслийн үйл ажиллагаанд тухайн аргачлалыг ашиглахыг хориглоно. ГЗ нь комисс болон ажлыг хэсэгт аргачлал болон аргачлалд хамааралтай хэрэгслийг дахин хянуулах хүсэлт тавих ёстой бөгөөд ГЗ-аас авсан аливаа зааварчилгаа зохих ёсны дагуу мөрдөгдөнө. Эдгээр журам нь О/НС төслийн үйл ажиллагааны БАр-д үйлчлэхийн зэрэгцээ зөвхөн жижиг оврын төслүүдийн аргачлалаар хязгаарлагдахгүй бусад батлагдсан журмуудад мөн хамаарна.

[ЕВ35 Anx13, para3, 6]



## 7-6. Батлагдсан аргачлал (БАр)-д тайлбар хүсэх журам

[Г332 Х15] [Хувилбар 5]

## БАр-д тайлбар хэзээ хүсэх вэ

[Г330 Х1, хэ3-4]

- ◆ Батлагдсан аргачлал (БАр)-д төслийн оролцогч, сонирхлын бүлэг, ГЗ, АК эсвэл АХ-ийн хүсэлтээр, холбогдох журмын хамгийн шинэ хувилбарын заалтын дагуу тайлбар хүсч болно.
- ◆ Тайлбар хүсэх журам нь ТМБ болон ТМБ-аар дамжуулан ТО-ын зүгээс тухайн БАр төсөлд нийцэх эсэх, суурь хувилбарыг тодорхойлох, нэмэгдэл чанарыг нотлох, суурь ялгаралт, төслийн ялгаралт, нэвчилт зэргийг тооцох, хяналт шинжилгээний өгөгдөл болон дүрэм журам гэх мэт БАр-д багтах журмуудтай холбоотой асуудлаар тайлбар авах боломжийг бүрдүүлэх зорилготой.
- ◆ Хэрэв тухайн аргачлал нь ойлгомжгүй, эсвэл утга нь бүрхэг байж, тохирох нөхцлүүдийн талаар нэмэлт мэдээлэл шаардлагатай байвал ТО нь тайлбар авах хүсэлт гаргавал зохино.

- (1) Хэрэв ТМБ нь батлагдсан аргачлал (БАр)-ын тохирох эсэх тухай АК-т асуулга тавих бол “М-ЦХМ-БАр-Мэд” гэсэн БАр-ын ашиглалттай холбоотой маягтыг бөглөж, НБДН газарт хүргүүлнэ. БАр-ын тохирсон эсэх талаар асуулга авах сонирхолтой ТО ТМБ-д “М-ЦХМ-БАр-Мэд” маягтыг бөглөн хүргүүлнэ. ТМБ нь ТО-ын саналыг хүлээн авснаас хойш ажлын 5 хоногоос оройтуулахгүйгээр аль болох эрт НБДН газарт хүргүүлнэ.
- (2) НБДН газар нь асуулгыг АК-ийн тусгай сүлжээ рүү оруулах, ТМБ-ууд болон АК-ийн гадаад сүлжээ /экстранэт/-ний хуудаст байрлуулах, ГЗ-д хүргүүлэх, НҮБҮӨСК-ийн ЦХМ-ын вэб хуудсаар нийтэд танилцуулах зэрэг ажлыг гүйцэтгэнэ.
- (3) БАр-ын ашиглалтын асуудлыг АК-ийн хурлаар хэлэлцүүлэхийн тулд асуулга нь **тус хурлаас дор хаяж 1 долоо хоногийн өмнө** АК-д танилцуулсан байх шаардлагатай. АК-ийн ажлын ачааллаас шалтгаалан асуулгыг хэлэлцэх эсэхийг комиссийн Дарга шийднэ.
- (4) Комиссын Дарга нь хяналт тавих үүрэг бүхий нэг гишүүнийг томилно. Илүү нарийвчилсан хэлэлцүүлэг шаардлагатай тохиолдолд Дарга дахин нэг гишүүнийг томилох эрхтэй.
- (5) НБДН газар нь асуулгын хариултыг боловсруулах явцдаа тайлбарыг АК-аар хэлэлцүүлэх шаардлагагүй хангалттай энгийн гэж үзсэн тохиолдолд уг хариултыг томилогдсон 2 гишүүнд хүргүүлж, урьдчилсан хэлэлцүүлэгт оруулна.  
Зөвшилцөлд хүрэхгүй эсвэл батлах боломжгүй тохиолдолд, саналыг АК-ын хурлаар хэлэлцүүлнэ.
- (6 а) Тайлбар авах хүсэлтийн АК-ийн зөвлөмжөөр гарсан бүх хариулт нь ГЗ-аар зөвшөөрөгдсөн гэж тооцогдох бөгөөд ГЗ-ийн дараагийн ээлжит хурал дээр өөрөөр шийдэгдээгүй бол энэ нь ГЗ-ийн тайланд хэвээр тусгагдана.
- (6 б) Комиссоос томилогдсон хоёр гишүүн хоёул төслийн эхний хувилбарыг **2 хоногийн дотор** зөвшөөрсөн тохиолдолд, НБДН нь АК-ын Даргаас нэг өдрийн дотор зөвшөөрөл авах ёстой бөгөөд батлагдсан даруйд хариултын эцсийн хувилбарыг ТМБ руу хүргүүлж, НҮБҮӨСК-ийн вэб хуудсанд байршуулж, аргачлалын тайлбар хийнэ. Зөвлөмжийн төслийг **АК-ийн хурлаас дор хаяж 1 долоо хоногийн өмнө** боловсруулж АК-д хүргүүлсэн байна. Хариултыг хэвлэсэн даруй, АК-ын хурлын тайланд тусгасан байх шаардлагатай.
- (7) АК-аар хэлэлцүүлэх зөвлөмжийг **АК-ийн дараагийн хурлаас дор хаяж 1 долоо хоногийн өмнө** боловсруулан бэлэн болгож, АК-ийн хэлэлцүүлэгт оруулах ёстой. НБДН газар тайлбар авах саналын хариултыг боловсруулан АК-ын хурлын хэлэлцүүлэгт оруулах үүрэг хүлээнэ. Зөвлөмж болон хариултыг “М-ЦХМ-БАр-Мэд”-г ашиглаж боловсруулна.
- (8) АК зөвлөмжийг эцсийн байдлаар батласны дараагаар, НБДН нь
  - ☞ хариултын эцсийн хувилбарыг ТМБ болон ГЗ-д хүргүүлэх,
  - ☞ НҮБҮӨСК-ийн вэб хуудасны зохих хэсэг болон батлагдсан аргачлалын архив вэб хуудаст тус тус байрлуулж олон нийтэд хүргэх үүргийг тус тус хүлээнэ.

## 8. Төслийн баримт бичиг (ТББ)-ийн бусад бүрэлдэхүүн хэсгүүд

### 8-1. Төслийн хил хязгаар болон нэвчилт

#### Төслийн хил хязгаар

- ◆ ТО-ын хяналтанд буй, тухайн ЦХМ төслийн үйл ажиллагаанд хамаарах үндэслэлтэй, хүний үйл ажиллагаанаас улбаатай бүх төрлийн ХүХ ялгаруулах томоохон эх үүсвэрүүд төслийн хил хязгаарт багтана. [ТХ/2005/8/Н1, ху17 хэ52]
  - ☞ “Хяналтанд буй”, “томоохон”, “хамаарах үндэслэлтэй” зэрэг нэр томъёог хэрхэн тайлбарлах тухай Аргачлалын комисс (АК)-оос ГЗ-д тодорхой санал боловсруулж хүргүүлнэ. [НэрТ, хув3, ху25]
  - ☞ Эдгээр нэр томъёоны талаарх ГЗ-ийн шийдвэр хүлээгдэж буй хугацаанд, ТО нь ЦХМ-ШАр-ын төсөл боловсруулахдаа өөсдийн тайлбар оруулахыг дэмжинэ.

#### Нэвчилт

- ☞ Нэвчилт гэдэг нь ЦХМ төслийн үйл ажиллагаанаас улбаатайгаар, төслийн хил хязгаараас гадна бий болсон ХүХ-н ялгаралтын хэмжээний хэмжигдэхүйц цэвэр өөрчлөлтийг хэлнэ. [ТХ/2005/8/Н1, ху17 хэ51]
  - ⇒ Хэрэглэх утгын хувьд, “хэмжигдэхүйц” болон “улбаатайгаар” гэсэн нэр томъёог “хэмжиж болохуйц” болон “төслөөс шууд улбаалсан” хэмээн ойлгоно. [НэрТ, хув3, ху21]
- ☞ Хяналт шинжилгээ, нотолгооны журмын дагуу ХүХ-н ялгаралтын бууралтын хэмжээнд тухайн нэвчилтийг тооцсон засвар оруулна. [ТХ/2005/8/Н1, ху17 хэ50]

### 8-2. Хяналт шинжилгээний төлөвлөгөө

- ◆ Хяналт шинжилгээ гэдэг нь ЦХМ төслийн үйл ажиллагааны суурь өгөгдлийг тодорхойлох, төслийн хил хязгаар дахь ХүХ-н ялгаралт, нэвчилтийг тооцоход ашиглагдах бүхий л мэдээллийг цуглуулж архивлахыг хэлнэ. [НэрТ, хув3, ху22]
- ◆ Санал болгож буй төслийн үйл ажиллагааны хяналт шинжилгээний төлөвлөгөө нь хяналт шинжилгээний батлагдсан эсвэл шинэ аргачлалд үндэслэсэн байна. [ТХ/2005/8/Н1, ху17 хэ54]
- ◆ Хяналт шинжилгээгээр цуглуулах мэдээллийн үнэн зөв, бүрэн гүйцэд байдлыг сайжруулах зорилгоор уг төлөвлөгөөнд засвар өөрчлөлт оруулах бол ТО үндэслэлээ гаргаж, ТМБ-аар магадлуулна. [ТХ/2005/8/Н1, ху18 хэ57]
  - ☞ ГЗ нь бүртгэгдсэн ЦХМ төслүүдийн хяналт шинжилгээний төлөвлөгөөнд засвар өөрчлөлт оруулах журмын төслийг боловсруулах даалгаврыг НБДН газарт өгөөд байна. [Г325 Тай, хэ109]

- ☞ ГЗ-өөс баталж, зохих зааврын дагуу олон нийтэд танилцуулсан бол батлагдсан хяналт шинжилгээний аргачлал гэнэ. [НэрТ хув3, ху22]
- ☞ ТО нь хяналт шинжилгээний шинэ аргачлал санал болгож болно.
  - ⇒ Суурь өгөгдөл болон хяналт шинжилгээний шинэ аргачлал (ШАр)-г нэгэн зэрэг өргөн мэдүүлж, батлуулна.

#### НЭМЭЛТ: Хяналт шинжилгээнд хэмжих хэрэгслэл ашиглахад тавигдах нөхцөл

[Г323 Тай, хэ24]

- ◆ Өгөгдөхүүн, хэмжигдэхүүнийг тодорхойлоход ашиглах хэмжих хэрэгслэлийн нарийвчлалын зэрэг, ашиглалт, тохиргооны журам болон тодорхой бус байдлын түвшинг ТББ-д тодорхой заахын зэрэгцээ чанарын хяналт, менежментийн журмыг дэлгэрэнгүй тайлбарласан байна.
- ◆ Түүнчилэн, ашигласан стандарт нь улсын эсвэл олон улсын стандарт байна.
- ◆ Хэмжих хэрэгслэл болон тодорхой бус байдлын түвшин үнэн зөв заагдсан эсэхийг ТМБ-аас магадлагаа хийх үед баталгаажуулна..
- ◆ Тэг тохиргоог хэмжих хэрэгслэлийн тохиргоо хэмээн үзэхгүй. [Г324 Тай, хэ37]


8-3. ХүХ ялгаралтын бууралтын тооцоот хугацаа (цаашид “тооцоот хугацаа” гэнэ. орч)

- ◆ ЯББ-г ЦХМ төслийн үйл ажиллагаа бүртгэгдсэний дараа эхлэх тооцоот хугацаанд олгоно. [ТБХ/2001/13/Н2, ху23 хэ12]
- ◆ ТО нь тухайн санал болгож буй төслийн үйл ажиллагааны тооцоот хугацааг дараах аргын аль нэгийг ашиглаж сонгоно. [ТХ/2005/8/Н1, ху17 хэ49] Үүнд:
  - ☞ Хамгийн ихдээ дахин 2 удаа сунгаж болох 7 жилийн дээд хугацаа.
    - ⇒ Сунгалт хийгдэх бүрт, төслийн анхны суурь өгөгдөл хэвээр байгаа, эсвэл шинэ мэдээлэлд үндэслэн шинэчлэгдсэн болохыг ТМБ тогтоож, ГЗ-д энэ тухай мэдээлнэ.
  - ☞ Дахин сунгахгүй 10 жилийн дээд хугацаа.
- ◆ 2000 оноос хойшхи ХүХ-н ялгаралтын бууралтанд ЯББ олгогдож болно. [ТХ/2001/13/Нэ2, ху23 хэ13]

Тооцоот хугацааг сунгахад мөрдөх журам, бүрдүүлэх баримтын хувьд, төслийн үйл ажиллагааны 2 болон 3-р тооцоот хугацааны эхэнд суурь өгөгдлийн хүчин төгөлдөр байдал хэвээр үргэлжилж буй эсэх болон суурь өгөгдлийг сунгах шаардлагатай эсэхийг үнэлэн үзсэний үндсэн дээр шийдвэрлэнэ гэж ГЗ-өөс тохиров. [Г320 X7, хэ1] (Бүлэг 16)

- Тооцоот хугацааны эхлэлийг тогтоох нь** [Г324 X31, хэ4-5]
- ◆ ТО нь тооцоот хугацааны эхний өдрийг ТББ-д өдөр/сар/он хэлбэрээр тодорхой заах болон “ойролцоогоор” гэх мэт нөхцөл нэмэхгүй.
  - ◆ ТО нь төсөл үе шаттайгаар хэрэгжих тохиолдолд ч тооцоот хугацаанд нэг л эхлэх өдөр заана.

- ☞ ЦХМ төслийн үйл ажиллагааны эхлэл нь уг төслийн тооцоот хугацааны эхлэлтэй давхцсан байх албагүй. Тиймээс, 2000.01.01-нд эхэлсэн төслийн үйл ажиллагаа 2005.12.31-ээс хойш ЦХМ төслийн үйл ажиллагаагаар магадлагдан, бүртгэгдэж болно. [Г321 Тай, x10 хэ63]
- ☞ ЦХМ төслийн үйл ажиллагааны эхлэл нь тухайн төслийн хэрэгжилт, барилгын ажил, эсвэл бодит үйл ажиллагаа эхэлсэн өдөр байна. [Нэр Т хув3, x28]



**Тооцоот хугацаа эхлэх өдрийг өөрчлөх хүсэлт гаргах нь** [ГЗ24 Х31, хэ6-9]

- ◆ Тооцоот хугацаа нь бүртгүүлсэн өдрөөс өмнө эхэлсэн (ө.х. ретроактив кредит хүсэх) төслүүдийн хувьд тооцоот хугацааны эхлэлийг өөрчлөх боломжгүй.
- ◆ Тооцоот хугацаа нь бүртгүүлсэн өдрөөс хойш эхэлсэн төслүүдийн хувьд ТО нь:
  - ☞ (а) Тооцоот хугацаа эхлэх өдөр нь ТББ-д анх зааснаас 1 жил хүртэлх хугацаагаар урагшлуулах тухай НБДН газарт мэдэгдэж болох боловч энэ нь уг төслийг бүртгүүлсэн өдрөөс өмнө байх ёсгүй;
  - ☞ (б) Тооцоот хугацааны эхлэлийг 1 жил хүртэлх хугацаагаар хойшлуулах тухай НБДН газарт мэдэгдэж болно;
  - ☞ (в) ТМБ-аар дамжуулан, тооцоот хугацааны эхлэлийг 1-ээс их гэхдээ 2-оос илүүгүй жилээр хойшлуулах хүсэлтийг НБДН газарт тавьж болох агаад ингэхдээ дараах баримтыг хавсаргана. Үүнд:
    - ⇒ Суурь өгөгдөлд сөргөөр нөлөөлөх өөрчлөлт ороогүйн зэрэгцээ төслийн үйл ажиллагааг эхлүүлэхэд ТО-ын зүгээс ихээхэн ажил хийгдсэнийг баталсан ТМБ-ын баталгаа;
    - ⇒ Тооцоот хугацааг өөрчилснөөр тухайн төслийн зүгээс тогтвортой хөгжилд оруулах хувь нэмэр өөрчлөгдөхгүйг баталсан Хүлээн авагч Талын баталгаа.
- ◆ НБДН газар нь (в)-д заасан хүсэлтийг ГЗ-ийн Даргатай хэлэлцсэний дараа тооцоот хугацаанд өөрчлөлт оруулах эсэхийг шийднэ.
- ◆ ТО нь (а), (б) эсвэл (в)-д заагдсан хүсэлтийг тухайн бүртгэгдсэн төслийн ажиллагааны хувьд зөвхөн нэг удаа л гаргаж болно.
- ◆ ЯББ хэдийнэ олгогдсон төслийн үйл ажиллагааны тооцоот хугацааг өөрчлөх хүсэлтийн хувьд, дээрх журам ижил үйлчлэх бөгөөд НБДН хүсэлтийн дагуу холбогдох өөрчлөлт хийж болно. [ГЗ25 Тай, хэ105]

**Санал болгох шинэ аргачлалд үйлдвэр, тоног төхөөрөмжийн ашиглалтын хугацааг тооцох нь** [ГЗ22 Х2, хэ4-9]

- ☞ Хэрэв төслийн үйл ажиллагаагаар одоо ажиллаж буй тоног төхөөрөмж, байгууламжийг солих, сайжруулах бол ялгаралтын бууралтын хэмжээг тооцоходоо уг солисон өдрөөс эхлэн тухайн төсөл хэрэгжээгүй байсан тохиолдолд өмнө ашиглаж байсан тоног төхөөрөмжийг солих хүртэлх, эсвэл төслийн тооцоот хугацаа дуусах өдрийн аль эрт хугацаа хүртэл тооцох нь зохистой.
- ☞ ЦХМ төсөл хэрэгжээгүй байсан тохиолдолд одоо ашиглаж буй тоног төхөөрөмжийг солих цаг хугацааг тооцоходоо шинэ аргачлал нь дараахь зүйлүүдийг харгалзан үзэж болно. Үүнд:
  - ⇒ ЦХМ хэрэгжээгүй байсан тохиолдолд тоног төхөөрөмжийг солих тухайн салбарын болон үйл ажиллагааны онцлогт тохирсон арга, шалгуур;
  - ⇒ Тухайн орон, эсвэл салбарт өргөн хэрэглэгдэх нийтлэг дадлагыг харгалзан боловсруулж, баримтжуулсан, тус төрлийн тоног төхөөрөмжийн техникийн ашиглалтын хугацаа. Ө.х., аж үйлдвэрийн судалгаа, статистик, техникийн ном зохиол зэрэгт тулгуурлах;
  - ⇒ Тухайн хариуцагч ТО-ын тоног төхөөрөмжөө солих хуваарьт үнэлгээ хийж, баримтжуулах боломж. Ө.х., ижил төрлийн тоног төхөөрөмж сольж байсан түүхэн баримтад тулгуурлах.

## 9. Оролцогч Талуудын зөвшөөрөл

### Оролцогч Талуудын зөвшөөрөл [НэрТ, хув3, ху6-7]

- ◆ Санал болгож буй ЦХМ төслийн үйл ажиллагаанд оролцох Талын ТҮТ нь дараах агуулгатай албан мэдэгдэл гаргана. Үүнд:
  - ☞ Тухайн Тал Киотогийн протоколд нэгдсэн.
  - ☞ Санал болгож буй ЦХМ төслийн үйл ажиллагаанд сайн дураар оролцож буйгаа зөвшөөрсөн.
  - ☞ Хүлээн авагч Талын хувьд: санал болгож буй ЦХМ төслийн үйл ажиллагаа нь Хүлээн авагч Талын тогтвортой хөгжлийг хангахад хувь нэмэр оруулах тухай мэдэгдсэн байна.
- ◆ Бичгэн мэдэгдэлд дээрх заалтууд заавал байхын зэрэгцээ эдгээрт аливаа өөрчлөлт оруулах ёсгүй.
- ◆ Тухайн Талаас гаргах зөвшөөрлийн бичиг нь нэгээс олон төслийг хамруулж болох болон энэ тохиолдолд төсөл бүрийг тодорхой заасан байна.
- ◆ Зөвшөөрлийн бичгийг ТМБ хүлээж авна.

- ☞ Бүртгэлийн шатанд Х.1-д орсон Талын оролцоо байхгүй байсан ч тухайн төслийн үйл ажиллагааг бүртгэж болно.
- ☞ Х.1-д орсон Тал ийм төслөөс ЦХМ-ын регистрийн дансанд буй ЯББ-г шилжүүлж авахаар болбол ЦХМ-ын регистрийн эрхлэгч тухайн ЯББ-г ЦХМ регистрээс Х.1-д орсон Талын үндэсний регистр рүү шилжүүлэхээс өмнө тухайн Тал зөвшөөрлийн бичгээ ГЗ-д хүргүүлсэн байна. [ГЗ18 Тай, хэ57]  
⇒ Үүнийг “нэг талын ЦХМ төсөл” гэнэ.

### НЭМЭЛТ: Зөвшөөрлийн бичгийн агуулга

- ◆ Зөвшөөрлийн бичгийг ТО-д хаяглаж илгээнэ.
- ◆ Ихэнх тохиолдолд, зөвшөөрлийн бичиг нь батламжлалын бичигтэй нэг байна. (Бүлэг 4-6)
  - ☞ Зарим тохиолдолд, ТҮТ өөр улсад орших байгууллагад батламж олгож болно.
- ◆ Зарим тохиолдолд, заавал байх нөхцөлүүдээс бусад асуудалд ТҮТ-оос тодорхой нөхцөл зааж болно.
  - ☞ Жишээ нь, шилжүүлж болох ЯББ-н хэмжээ, зөвшөөрлийн хүчин төгөлдөр байдал, нэг талын ЦХМ төслийг үл зөвшөөрөх, ТҮТ-д өгөх тайлангийн агуулга зэрэгт нөхцөл зааж болно.
- ◆ Зарим тохиолдолд, албан зөвшөөрлийн бичгийг тухайн улсын хэлээр үйлдэж, тамгаар баталгаажуулан, түүний албан бус Англи орчуулгыг хавсаргасан байж болно.

# 10. Магадлагаа

<http://ЦХМ.unfccc.int/Reference/Procedures/public\_availТББ\_хув04.pdf>[Хувилбар 4 / June 2005]

## 10-1. Магадлагаа хийх журам

### ЦХМ төслийн оролцогчид (ТО)

(1)ТМБ-ын жагсаалтаас магадлагаа хийх ТМБ-ыг сонгож, гэрээ байгуулна. [ТХ/2005/8/Н1, ху14 хэ37]

(2)ТМБ-д ТББ болон бусад холбогдох бичиг баримтуудыг хүргүүлнэ.

### Томилогдсон магадлах байгууллага (ТМБ)

(3)ТББ-г ЦХМ-ын нөхцөл шаардлагад нийцсэн эсэхийг нягталж үзнэ. [ТХ/2005/8/Н1, ху14 хэ37]

(4)НҮБҮӨСК-ийн ЦХМ-ын вэб хуудастай холбоостой вэб хуудас байгуулж түүнд ЦХМ-ТББ-г PDF хэлбэрээр нийтэд хүртээмжтэй байхаар байрлуулна; эсвэл шууд НҮБҮӨСК-ийн ЦХМ-ын вэб хуудсаас холбогдох боломжтойгоор байрлуулна.

(5)Дараах мэдээллийг олон нийтэд танилцуулна:  
(а)Санал болгох ЦХМ төслийн үйл ажиллагааны нэр  
(б)ЦХМ-ТББ-г байрлуулсан вэб хаяг эсвэл НҮБҮӨСК-ийн ЦХМ-ын вэб хуудсанд байрлуулсан ЦХМ-ТББ-н нэр.

(6)**30 хоногийн** хугацаанд Талууд, сонирхлын бүлэг болон итгэмжлэгдсэн Төрийн бус байгууллагуудаас санал авна. [ТХ/2005/8/Н1, ху15 хэ40(в)] ТҮТ нь санал хүлээн авмагцаа энэ тухай илгээгчид нь даруй мэдэгдэж байна. ТББ-ын талаарх ирүүлсэн саналуудыг хэрхэн тусгасныг тодорхой тайлбарлаж, холбогдох цахим шуудан, факсын утгыг тодорхой дурьдсан байна. **30 хоногийн** хугацаа дуусмагц хүлээн авсан бүх саналыг нийтэд мэдээлнэ.  
Хэрэв ТББ нь хэдийнэ нийтлэгдсэн төслийн үйл ажиллагаанд магадлагаа хийх үед ТО нь (а) ашигласан БАр-г өөрөөр солих ба/эсвэл (б) анх ашигласан аргачлалын хувилбар хүчингүй болсноос уг хувилбарыг сунгахээр бол ТМБ нь тус ЦХМ-ТББ-г дахин **30 хоногийн** хугацаагаар нийтэд танилцуулна. [Г325 Тай, хэ92-93]

(7)Төслийн үйл ажиллагаанд магадлагаа өгөх эсэхийг шийднэ. [ТХ/2005/8/Н1, ху15 хэ40(г)]

Өгөхгүй

Өгнө

Зохих засвар өөрчлөлт хийгдсэний дараа дахин магадлуулан, бүртгүүлж болно. [ТХ/2005/8/Н1, ху16 хэ42]

Буцаасан шалтгааныг ТО-д мэдэгдэнэ.

(8)Магадлагааг баталгаажуулсныг ТО-д мэдэгдэнэ. [ТХ/2005/8/Н1, ху15 хэ40(д)]

**Бүртгэх ажиллагаа**

### НҮБҮӨСК-ийн НБДН газар

(5 а) Хэрэв ТМБ нь бүх салбарын хүрээнд итгэмжлэгдсэн бол НБДН газар нь ЦХМ мэдээллийн системээр дамжуулан ТМБ-ын вэб хуудас эсвэл НҮБҮӨСК-ийн ЦХМ-ын вэб хуудсанд байрлуулсан ЦХМ-ТББ-г харах холбоосыг бий болгож, энэ тухай мэдэгдлийг ТМБ-д тус системээр дамжуулж хүргүүлнэ.

(5 б) Хэрэв ТМБ нь бүх салбарын хүрээнд итгэмжлэгдээгүй бол НБДН газар нь тухайн санал болгох төслийн үйл ажиллагааг магадлах ажил гүйцэтгэх боломжтой эсэхийг **3 хоногийн** дотор шийднэ. Хүлээж авах бол (5 а) алхам хэрэгжинэ. Хүлээж авахгүй бол итгэмжлэл олгох журамд заасны дагуу арга хэмжээ авна.

## 10-2. Магадлагаанд тавигдах нөхцөл шаардлага

Төслийн үйл ажиллагааг магадлуулах зорилгоор ТО-дын сонгосон ТМБ нь тэдгээртэй гэрээ байгуулсны үндсэн дээр дараах нөхцөл шаардлага биелэгдсэн эсэхийг тодорхойлох зорилгоор ТББ болон холбогдох бусад баримтыг нягтлан үзнэ. [ТХ/2005/8/Н1, ху14 хэ37]

- ☞ Төсөлд оролцохтой холбогдсон доорх нөхцөл шаардлагад нийцсэн эсэх;
  - ⇒ ЦХМ төслийн үйл ажиллагаанд сайн дураар оролцоно. ЦХМ-д оролцогч Талууд ЦХМ-ын үндэсний товчоог томилно (ТҮТ). Х.1-д ороогүй Тал Киотогийн протоколд нэгдсэн бол ЦХМ төслийн үйл ажиллагаанд оролцож болно.
- ☞ Дотоодын сонирхлын бүлгүүдээс санал, зөвлөмж авч тэдгээрийн тоймлон баримтжуулан, хүлээн авсан санал зөвлөмжийг зохих хэмжээнд хэрхэн тусгасан тухай тайланг ТМБ-д хүргүүлсэн эсэх;
- ☞ ТО нь төслийн үйл ажиллагааны байгаль орчинд үзүүлэх нөлөөний дүн шинжилгээ, эсвэл хүлээн авагч Талын дүрэм журмын дагуу гүйцэтгэсэн байгаль орчинд үзүүлэх нөлөөний үнэлгээний баримтыг ТМБ-д хүргүүлсэн эсэх;
- ☞ Төслийн үйл ажиллагааны үр дүнд бий болох ХүХ-н ялгаралтын бууралт нь төсөл хэрэгжээгүй үед байх ялгаралтанд нэмэгдэл болох эсэх;
- ☞ Суурь өгөгдөл болон хяналт шинжилгээний аргачлалууд нь ГЗ-өөс өмнө баталсан аргачлалын нөхцөл шаардлага эсвэл шинэ аргачлалыг боловсруулах дэг журамд нийцэж буй эсэх;
- ☞ Хяналт шинжилгээ, магадлагаа, мэдээлэл нь ЦХМ-ын дэг, журам ТБХ/ТХ-ын холбогдох шийдвэрийн заалтуудад нийцэж буй эсэх;
- ☞ Төслийн үйл ажиллагаа нь ЦХМ-ын дэг журмын дагуу ЦХМ төслийн үйл ажиллагаанд тавигдах бусад нөхцөл шаардлага болон ТБХ/ТХ, ГЗ-ийн холбогдох шийдвэрийн заалтуудад нийцсэн эсэх.

### Магадлагааны тайлан [ТХ/2005/8/Н1, ху15 хэ40]

ТМБ нь:

- ☞ Магадлагааны тайланг ГЗ-д хүргүүлэхийн өмнө, оролцогч Тал тус бүрийн ТҮТ-ээс төсөлд сайн дураар оролцож буйг баталсан зөвшөөрлийн бичиг болон хүлээн авагч Талаас тухайн төслийн үйл ажиллагаа нь тус орны тогтвортой хөгжлийг хангахад хувь нэмэр оруулж буйн баталсан бичгийг ТО-оос хүлээн авсан байна;
- ☞ Нууц хадгалах тухай дээр дурьдсан заалтуудыг харгалзан, ТББ-ийг нийтэд танилцуулна;
- ☞ Төслийн үйл ажиллагааг магадлан дэмжсэн бол ГЗ-д магадлагааны тайланг ТББ, хүлээн авагч Талын зөвшөөрлийн бичиг болон хүлээн авсан санал, зөвлөмжүүдийг хэрхэн зохих хэмжээнд тусгасан тухай тайлбарын хамт хүргүүлэн, тухайн төслийг бүртгүүлэх хүсэлт гаргана;
- ☞ Магадлагааны тайланг ГЗ-д хүргүүлсэн даруйд нийтэд танилцуулна.

### НЭМЭЛТ: БАр-д засвар өөрчлөлт оруулах, магадлах [Г327 Тай, хэ29]

- ◆ Хэрэв ТББ нь хэдийнэ нийтлэгдсэн (ТББ-г ТО-оос хүлээн авмагц нийтэлнэ) төслийн үйл ажиллагаанд магадлагаа хийх явцад тус төсөлд анх ашигласан аргачлалын хувилбар хүчингүй болсны улмаас ТО ашигласан аргачлалыг шинэчлэн, өөрчлөлтийг заасан хугацаанд хийсэн тохиолдолд, шинэчилсэн аргачлалд өөрөөр заагаагүй бол ТМБ нь тус ЦХМ-ТББ-г дахин **30 хоногийн** хугацаанд нийтэд танилцуулна.

# 11. Бүртгэл

## 11-1. Бүртгэлийн журам

[ГЗ14 Х7] [ТХ/2005/8/Н1, ху54]

### Томилогдсон магадлах байгууллага (ТМБ)

(1) "ЦХМ төслийн үйл ажиллагааны бүртгэл, магадлагааны тайлангийн маягт (М-ЦХМ-БҮРТ)"-г ашиглан магадлагааны тайлан боловсруулж, ТББ, хүлээн авагч Талын зөвшөөрлийн бичиг болон ТББ-н талаар хүлээн авсан санал зөвлөмжийг хэрхэн зохих хэмжээнд тусгасан тухай тайлбарыг хавсаргана.

(2) НБДН газраас ТМБ тус бүрт олгосон интернетээр дамжих цахим сувгаар дамжуулан, бүртгүүлэх тухай хүсэлт гаргахад шаардагдах бүртгэлийн хураамж төлсөн баримтаас бусад бүх бичиг баримтыг өргөн мэдүүлнэ.

(3) Шаардлах мэдээллийг хүргүүлсэн даруйд ТМБ хувийн лавлагааны дугаар автоматаар хүлээж авах бөгөөд түүнийг бүртгэлийн хураамж төлсөн тухай банкны шилжүүлгийг шалгахад ашиглана. ТМБ нь тус хувийн лавлагааны дугаарыг заасан төлбөрийн баримтыг дээр дурдсан цахим аргаар хүргүүлнэ.

### НҮБУӨСК-ийн НБДН газар

(4) ТМБ-ын бүрдүүлсэн баримт бичиг бүрэн гүйцэд эсэхийг шалгана.

(5) Бүртгэлийн хураамжийг хүлээн авч, НБДН газар ТМБ-ын хүргүүлсэн баримт бичиг бүрэн гүйцэд болохыг тодорхойлсон даруйд "бүртгүүлэх тухай хүсэлт"-ийг хүлээн авсанд тооцож, тэр өдөртөө багтаан нийтэд танилцуулах болон НҮБУӨСК-ийн ЦХМ-ын төслийн вэб хуудсанд **8 долоо хоногийн** хугацаанд байрлуулна. НБДН газар нь энэ нийтлэлийг зарлахдаа тухайн ЦХМ төслийн нэр, 8 долоо хоногийн хугацааны эхлэл, төгсгөлийн өдөр болон НҮБУӨСК вэб хуудсанд байршуулсан уг ЦХМ-ын төслийн хаягийг мэдээлнэ.

(6) НБДН газар нь бүртгүүлэх тухай хүсэлт тус бүрт Бүртгэл, олголтын баг (БОБ)-ын гишүүнийг томилно. ⇒ Томилогдсон гишүүн нь уг мэдэгдэл хүлээн авснаас **2 хоногийн** дотор ашиг сонирхлын зөрчилтэй эсэхээ мэдэгдэнэ. Үнэлгээгээр магадлагааны нөхцөл шаардлага биелэгдсэн эсэх болон тэдгээрийг ТМБ зүй зохистой тодорхойлсон эсэхийг тогтооно. Гишүүн нь "М-ЦХМ-БҮРТүнэл" маягыг ашиглан үнэлгээ хийж, **хуанлийн 20 (жижиг төслийн хувьд 15) хоногийн** дотор НБДН газарт хүргүүлнэ. НБДН газар нь тухайн гишүүний хийсэн үнэлгээг хүлээн авснаас хойш **хуанлийн 10 (жижиг төслийн хувьд 5) хоногийн дотор** бүртгүүлэх тухай хүсэлтийн хураангуйг боловсруулж, хийсэн үнэлгээний хамт ГЗ-д хүргүүлнэ. [ГЗ29 Х14, хэ21-25]

(9) НҮБУӨСК-ийн ЦХМ-ын вэб хуудсанд "бүртгэл хийгдсэн" хэмээн тэмдэглэгдэнэ. ЦХМ төслийн үйл ажиллагаа болон холбогдох баримтуудыг бүртгэгдсэн хэмээн тэмдэглэх болон нууцыг хадгалах заалтуудыг харгалзан нийтэлнэ.

### ЦХМ-ын Гүйцэтгэх зөвлөл (ГЗ)

(7) Бүртгүүлэх тухай хүсэлтийг хүлээн авснаас хойш **8 (ЦЖТ-ийн хувьд 4) долоо хоногийн** дотор төсөлд оролцогч Тал эсвэл ГЗ-ийн 3-аас цөөнгүй гишүүнээс энэхүү хүсэлтийг дахин нягтлах тухай санал оруулсан эсэх ТХ/2005/8/Н1, ху15 хэ41]

Үгүй

Тийм

(8) ЦХМ төслийн үйл ажиллагаа бүртгэгдэнэ

ГЗ-ийн дахин нягтлалын үр дүнг ийм санал дараах **2 дахь хурлаас хойшгүйгээр** эцэслэнэ. Гарсан шийдвэрийг үндэслэлийн хамт ТО болон олон нийтэд танилцуулна.

Бүртгэж болно

Буцаана

Зохих засвар өөрчлөлт оруулсны дараа дахин магадлагаа хийлгэн, бүртгүүлж болно. [ТХ/2005/8/Н1, ху16 хэ42]



## 11-2. Бүртгэлийг дахин нягтлах журам

[ГЗ29 X15]

## (1) Дахин нягтлах тухай санал оруулах

## ЦХМ төслийн үйл ажиллагаанд оролцогч Тал санал оруулах

Дахин нягтлах тухай саналыг холбогдох Талын ТҮТ-оос нарийн бичгийн дарга нарын (НБДН) газраар дамжуулан, албан ёсны харилцааны сувгаар (хүлээн зөвшөөрөгдсөн нэр хаяг, гарын үсэг бүхий албан тоот эсвэл албаны цахим шуудан гэх мэт) ГЗ-д хүргүүлнэ.

## ГЗ-ийн гишүүн санал оруулах

Дахин нягтлах тухай саналыг ГЗ-д мэдэгдсэнээр гаргана.

НБДН газар дахин нягтлах тухай санал хүлээж авснаа нотлон хариу мэдэгдэж, цахим сүлжээгээр ГЗ-д шуурхай дамжуулна.

- ☞ Дахин нягтлал нь магадлагааны нөхцөл шаардлагатай холбоотой асуудлуудыг хамрах болон энэ талаар тухайн саналд тодорхой заасан байх ёстой.
- ☞ Дахин нягтлах тухай саналд ЦХМ төслийн үйл ажиллагааны бүртгэлийн үнэлгээний маягт (М-ЦХМ-БҮ)-г хавсарган, дахин нягтлах болсон шалтгааныг зааж, холбогдох баримтуудыг хүргүүлсэн байна.
- ☞ Дахин нягтлах тухай саналыг НБДН газар хүлээн авсан өдрийг ГЗ түүнийг хүлээн авсан өдрөөр тооцно. Харин бүртгүүлэх тухай хүсэлт хүлээн авсны дараах **8 долоо хоногийн** эцсийн өдрийн **Гринвичийн цагаар 17:00-аас** хойш хүргүүлсэн бол хүлээн авахгүй.

Оролцогч Тал эсвэл ГЗ-ийн 3 гишүүн тухайн санал болгож буй төслийн үйл ажиллагааг дахин нягтлах санал оруулмагц дараах алхам хэрэгжинэ. Үүнд:

- (а) ГЗ-ийн дараагийн уулзалтаар хэлэлцэх асуудалд тухайн санал болгож буй төслийн үйл ажиллагааг дахин нягтлах асуудлын хэлэлцүүлгийг оруулна;
- (б) ГЗ нь ТО, ТМБ-д дахин нягтлах санал ирснийг мэдэгдэж, тус саналыг хэлэлцэх ГЗ-ийн дараагийн болон удаах хурал зохион байгуулах өдөр, байршлыг мэдээлнэ. Дахин нягтлалын үйл явцыг сонирхох сонирхлын бүлгүүдийн төлөөлөгчид ГЗ-ийн хуралд оролцох боломжтой байна;
  - ⇒ ТО, ТМБ-д дахин нягтлалын саналын талаар мэдэгдэл хүлээн авснаас **хойш 2 долоо хоногийн дотор, гэхдээ хурлаас өмнө 2-оос доошгүй долоо хоногийн өмнө** тавигдсан асуудлуудын талаарх өөрийн байр сууриа ГЗ-д илэрхийлэх боломжтой. Эдгээр мэдээллийг олон нийтэд танилцуулна.
  - ⇒ БОБ-ын гишүүн нь дахин нягтлах тухай саналд тавигдсан асуудлуудад үндэслэн эдгээр мэдээлэлд үнэлгээ гаргана.
  - ⇒ НБДН газар нь ГЗ-ийн даргын зааврын дагуу ГЗ-өөр хэлэлцүүлэх шийдвэрийн төслийг боловсруулна.
- (в) ТО, ТМБ нь дахин нягтлалын явцад харилцан холбоо барих хүн томилно;
- (г) Тухайн санал болгож буй төслийн үйл ажиллагааг НҮБҮӨСК/ЦХМ-ын вэб хуудсанд “дахин нягтлагдаж буй” хэмээн тэмдэглэн, мэдээллийн сүлжээгээр энэ тухай мэдэгдэл түгээнэ.

## (2) Дахин нягтлалын хамрах цар хүрээ, дэг журам

- ☞ ГЗ нь **өөрийн дараагийн хурлаар** тухайн ЦХМ төслийн үйл ажиллагааг дахин нягтлах эсвэл бүртгэлд авахыг шийднэ.
- ☞ Хэрэв ГЗ дахин нягтлал хийхээр болбол, түүгээр хамрах цар хүрээ болон дахин нягтлалын багийн бүрэлдэхүүнийг тус хурлаар тодорхойлно. Дахин нягтлалын баг нь ГЗ-ийн 2 гишүүн болон шаардлагатай бусад мэргэжилтнээс бүрдэнэ.
- ☞ Дахин нягтлалын баг нь ТМБ, ТО-оос нэмэлт мэдээлэл авч, дүн шинжилгээ хийнэ.

## (3) Дахин нягтлалын явц

- ☞ Дахин нягтлалаар хамрах цар хүрээний талаарх ГЗ-ийн шийдвэрийг хурлын тайланд багтаан нийтэд танилцуулна.
- ☞ Нэмэлт мэдээлэл авах хүсэлтийг ТМБ, ТО-д явуулна. Хариултыг ийм хүсэлт хүлээн авснаас хойш **ажлын 5 өдрийн** дотор НБДН газраар дамжуулан дахин нягтлалын багт хүргүүлнэ.
- ☞ ГЗ-ийн 2 гишүүн ГЗ-ийн удаах хурлаас **2-оос доошгүй долоо хоногийн** өмнө зөвлөмж боловсруулж, дотоод сүлжээгээр түгээнэ.

## (4) Дахин нягтлалын дүгнэлт

- ☞ ГЗ-ийн дахин нягтлалын дүгнэлтийг дахин нягтлах тухай санал хүлээн авснаас хойшхи **2 дахь уулзалтаас хойшгүйгээр** эцэслэн шийднэ.
- ☞ ГЗ нь санал болгож буй төслийн үйл ажиллагааг бүртгэлд авах, бүртгүүлэхийн өмнө зохих засвар өөрчлөлт оруулахыг ТМБ, ТО-оос хүсэх, эсвэл төслийг буцаах шийдвэр гаргана.
- ☞ ГЗ-ийн шийдвэрийг олон нийтэд танилцуулна.
- ☞ Хэрэв дахин нягтлалаар ТМБ-ын үйл ажиллагаатай холбоотой асуудлыг илрүүлбэл, ТМБ-д гэнэтийн шалгалт хийх эсэхийг ГЗ авч үзнэ.

## НЭМЭЛТ: Дахин нягтлалын зардлыг хариуцах

Дахин нягтлалын зардлыг ГЗ хариуцана. Хэрэв ГЗ нь бүртгэлд авахгүй байх шийдвэр гаргаж, ТМБ-г зохисгүй ажилласан эсвэл чадвар дутсан хэмээн дүгнэвэл ТМБ бүх зардлыг ГЗ-д нөхөн төлнө. Туршлага хуримтлагдахын хэрээр энэ заалтыг эргэн хэлэлцэж байна. [ГЗ29 X15, хэ21]

11-3. Бүртгэлийн хураамж

ЦХМ төслийн үйл ажиллагааны бүртгэлийн хураамж [ГЗ 37 Х20]

- ◆ ТО нь бүртгэлийн шатанд бүртгэлийн хураамж төлнө.
- ◆ Төлбөрийн хураамжийг захиргааны зардлыг нөхөх орлогын шимтгэл (ОШ-Админ) болон тухайн төслийн тооцоот хугацаанд бий болохоор тооцож буй ХүХ ялгаралтын бууралтын нэг жилийн дундаж хэмжээг харгалзан дахин тогтооно.
  - ☞ ОШ-Админ нь тухайн хуанлийн жилд олгосон ЯББ-н эхний 15,000 тонн-СО<sub>2</sub>-д тонн тутамд **0.10 ам.доллар**, 15,000 тонн-СО<sub>2</sub>-оос давсан хэмжээний тонн тутамд **0.20 ам.доллар** байна.
  - ☞ Бүртгэлийн хураамжийн дээд хэмжээ **350,000 ам.доллар** байна.
  - ☞ Тооцоот хугацаанд нэг жилд дунджаар 15,000 тонн-СО<sub>2</sub>-оос доош хэмжээний ялгаралтын бууралтыг бий болгох ЦХМ төслөөс **бүртгэлийн хураамж авахгүй**.
  - ☞ Нэн буурай хөгжилтэй улсуудад хэрэгжүүлэх ЦХМ-ийн төслүүдийг ямарваа бүртгэлийн хураамж болон захиргааны зардлаас чөлөөлнө.

Төлбөрийн хураамжийн жишээ

Нэг жилийн ялгаралтын дундаж бууралт	Бүртгэлийн хураамж
10,000 тонн	-
15,000 тонн	\$ 1,500
30,000 тонн	\$ 4,500
100,000 тонн	\$ 18,500
1,000,000 тонн	\$ 198,500
1,757,500 тонн	\$ 350,000
3,000,000 тонн	\$ 350,000

- ◆ ТМБ нь тухайн төслийн үйл ажиллагааны дүнд ХүХ ялгаралтын бууралт нь ТББ-д заасан хэмжээнд байх магадлалын хувийн талаар байр сууриа илэрхийлсэн мэдэгдлийг хавсаргана. Бүртгэлийн хураамжийн хэмжээг энэхүү мэдэгдэлд үндэслэн тогтооно. [ГЗ11 Х6, хэ2]
- ◆ О/НС ЦХМ төслийн хувьд “О/НС ЦХМ-ын санал болгож буй төслийн үйл ажиллагааны бүртгэлийн хураамжтай холбоотой зааварчилгаа” гэсэн журам бий. [ГЗ 36 Х21]

- ☞ Бүртгэлийн хураамжийг ОШ-Админ-аас хасна.
  - ⇒ ОШ-Админ гэдэг нь ЯББ-г олгох үед ТО-ын төлөх төлбөр юм. (Бүлэг 15)
- ☞ Бүртгэлийн хураамж гэдэг нь үндсэндээ, бий болсон ялгаралтын бууралтад ногдох ОШ-Админ-д төлж буй урьдчилгаа төлбөр юм.
- ☞ Хэрэв үйл ажиллагааг бүртгэхгүй бол бүртгэлийн хураамжийн **30,000 ам.доллараас** давсан хэсгийг буцаан олгоно.

**НЭМЭЛТ: ТББ нь нийтлэгдсэн төслөөс гарах**

- ◆ Магадлагааны үеэр нийтлэгдсэн ТББ-д заагдсан ТО нь бүртгүүлэхэд өргөн мэдүүлсэн ТББ-д ороогүй бол, төслөөс сайн дураар гарсан болохоо баталсан ТО-ын албан бичгийг гаргуулж, магадлагааны тайландаа энэ асуудлын тайлбар оруулна гэж ГЗ-өөр шийдвэрлэсэн. [ГЗ30 Тай, хэ41]

## 12. Хяналт шинжилгээний төлөвлөгөөнд засвар өөрчлөлт оруулах нь

- ◆ ЦХМ-ын дэг журмаар ТО нь цуглуулах мэдээллийн үнэн зөв, бүрэн гүйцэд байдлыг сайжруулах зорилгоор хяналт шинжилгээний төлөвлөгөөнд ТМБ-аар магадлуулах нөхцөлтэйгээр засвар өөрчлөлт оруулахыг зөвшөөрнө. [ГХ/2005/8/Н1, ху18 хэ57]
- ◆ Хяналт шинжилгээний төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах тухай хүсэлтийг ЯББ олгох хүсэлт тавихаас өмнө ТМБ-аас гаргана.
- ◆ Дараах тохиолдолд ийм хүсэлт гаргана. Үүнд:
  - ☞ Бүртгэгдсэн ЦХМ төслийн үйл ажиллагааны баримтанд заагдсан хяналт шинжилгээний төлөвлөгөө нь тус төсөлд ашигласан хяналт шинжилгээний батлагдсан аргачлалтай нийцэхгүй байгаа нь тодорхой болох; эсвэл
  - ☞ Хяналт шинжилгээний төлөвлөгөөнд тухайн засвар өөрчлөлтийг оруулах нь хяналт шинжилгээ хийх, магадлах явцын үр дүнгийн үнэн зөвд сөргөөр нөлөөлөхгүй нь баталгаатай байх. [ГЗ31 Х14 хэ14-15]

### Хяналт шинжилгээний өөрчилсөн төлөвлөгөөг ашиглах нь [ГЗ26 Х34 хэ4]

ТО нь бүртгэгдсэн ТББ-д заагдсан хяналт шинжилгээний төлөвлөгөөг хэрэгжүүлнэ. Хяналт шинжилгээний өөрчилсөн төлөвлөгөөг Аргачлалын Комисс (АК)-ын Дарга ГЗ-ийн Даргатай зөвшилцөн энэхүү журмын дагуу хүлээн зөвшөөрсний дараа ТО түүнийг ашиглах эрхтэй болно.

### Гүйцэтгэлийг магадлах нь [ГЗ26 Х34 хэ5]

ТМБ нь ЦХМ-ын вэб хуудас дахь зориулалтын холбооны сувгаар НБДН газарт дараах асуудлаарх өөрийн байр сууриа танилцуулсан магадлагааны тайлан хүргүүлнэ. Үүнд:

- ☞ Хяналт шинжилгээний төлөвлөгөөнд оруулахаар санал болгож буй засвар өөрчлөлт нь хяналт шинжилгээ хийх, магадлах ажлын үр дүнгийн үнэн зөвд сөргөөр нөлөөлөхгүй;
- ☞ Хяналт шинжилгээний төлөвлөгөөнд оруулахаар санал болгож буй засвар өөрчлөлт нь тухайн төсөлд ашиглагдсан хяналт шинжилгээний батлагдсан аргачлалд нийцсэн;
- ☞ Өмнө хийсэн нотолгооны ажлын үр дүнг (хэрэв байсан бол) харгалзаж үзсэн.


### Хүсэлтийг шийдвэрлэх нь [ГЗ26 Х34 хэ6-9]

- ☞ НБДН газар нь баримт бичгийн бүрэн гүйцэд эсэхийг шалгаж, хангалттай гэж үзвэл БОБ-ын гишүүнийг томилж, санал болгож буй өөрчлөлтийн талаар үнэлгээ гаргах даалгавар өгнө.
- ☞ Үнэлгээг **10 хоногийн** дотор НБДН газарт хүргүүлж, **ажлын 1 хоногт багтаан** ГЗ-д дамжуулна.
- ☞ Хяналт шинжилгээний төлөвлөгөөнд оруулахаар санал болгож буй засвар өөрчлөлтийг НБДН газраас АК-ийн Дарга, ГЗ-ийн Дарга нартай зөвшилцөж шийдвэрлэнэ.
- ☞ Зөвшөөрсөн тохиолдолд, тухайн төслийн ЦХМ-ын вэб хуудаст хяналт шинжилгээний өөрчилсөн төлөвлөгөөг байрлуулна.

## 13. ЯББ-н нотлогоо, баталгаажуулалт, олголт

### 13-1. ЯББ-г нотлох, баталгаажуулах, олгох журам

[ЦХМ-ын дэг журмын 01 хувилбарын 62-р хэсэгт зааснаар хяналт шинжилгээний тайланг олон нийтэд танилцуулах журам/2005 оны 4-р сарын 5][Нотолгоо, баталгаажуулалтын тайлан/ЯББ-г олгох тухай хүсэлтийн холбогдох журмын 01.1 хувилбар / 2006 оны 12-р сарын 20] <<http://ЦХМ.unfccc.int/Reference/Procedures>>




дараагийн хуудсанд

### 13. ЯББ-г нотлох, баталгаажуулах, олгох нь

#### 13-1. ЯББ-г нотлох, баталгаажуулах, олгох журам

[Нотолгоо, баталгаажуулалтын тайлан/ЯББ-г олгох тухай хүсэлтийн холбогдох журамын 01.1 хувилбар / 2006 оны 12-р сарын 20] <<http://CDM.unfccc.int/Reference/Procedures>>



13-2. Олголтыг дахин нягтлах журам

[Г329 Х16]

(1) Дахин нягтлах тухай санал

ЦХМ төсөлд оролцогч Тал санал оруулах

Дахин нягтлах тухай саналыг холбогдох ТҮТ-оос НБДН газраар дамжуулан, харилцааны албан ёсны сувгаар (хүлээн зөвшөөрөгдсөн нэр хаяг, гарын үсэг бүхий албан тоот эсвэл албан ёсны зориулалтын цахим шуудан гэх мэт) ГЗ-д хүргүүлнэ.

ГЗ-ийн гишүүн санал оруулах  
Дахин нягтлах тухай саналыг ГЗ-д хүргүүлнэ.

НБДН газар дахин нягтлах тухай санал хүлээж авснаа даруй хариу мэдэгдэж, дотоод сүлжээгээр ГЗ-д дамжуулна.

- ☞ Дахин нягтлал ТМБ-ын зүгээс залилан, эсвэл хууль бус үйлдэл хийх болон чадвар дутах зэрэг асуудлуудыг хамрах болон энэ талаар тухайн саналд тодорхой заасан байна.
- ☞ Дахин нягтлах тухай саналыг НБДН газар хүлээн авсан өдрийг ГЗ түүнийг хүлээн авсан өдрөөр тооцох болон харин ЯББ олгох тухай хүсэлт хүлээн авсны дараах **15 хоногийн** сүүлчийн өдрийн **Гринвичийн цагаар 17:00-аас** хойш хүргүүлсэн бол хүлээн авахгүй.

Оролцогч Тал эсвэл ГЗ-ийн 3 гишүүн тухайн санал болгож буй төслийн үйл ажиллагааг дахин нягтлах санал оруулмагц дараах алхам хэрэгжинэ. Үүнд:

- (а) ГЗ-ийн дараагийн уулзалтаар хэлэлцэх асуудалд ЯББ-г олгох тухай хүсэлтийг дахин нягтлах асуудлын хэлэлцүүлгийг оруулна;
- (б) ГЗ нь ТО, ТМБ-д дахин нягтлах санал ирснийг мэдэгдэх болон энэхүү саналыг хэлэлцэх ГЗ-ийн хурлыг зохион байгуулах өдөр болон байршлыг мэдээлнэ. Дахин нягтлалын үйл явцыг сонирхох сонирхлын бүлгүүдийн төлөөлөгчид ГЗ-ийн хуралд оролцох боломжтой байна;
  - ⇒ ГЗ нь ТО, ТМБ-д дахин нягтлалын саналын талаар мэдэгдэхийн зэрэгцээ тухайн мэдэгдэл хүлээн авснаас **хойш 2 долоо хоногийн дотор, гэхдээ хурлаас өмнө 2-оос доошгүй долоо хоногийн өмнө** тавигдсан асуудлуудын талаарх өөрийн байр сууриа ГЗ-д илэрхийлэхийг зөвшөөрнө. Эдгээр мэдээллийг олон нийтэд танилцуулна.
  - ⇒ БОБ-ын гишүүн нь дахин нягтлах тухай саналд тавигдсан асуудлуудад үндэслэн эдгээр мэдээлэлд үнэлгээ гаргана.
  - ⇒ НБДН газар нь ГЗ-ийн Даргын заавраар ГЗ-өөр хэлэлцүүлэх шийдвэрийн төслийг боловсруулна.
- (в) ТО, ТМБ нь тус тус дахин нягтлалын явцыг хариуцах хүн томилно;
- (г) Тухайн ЯББ-г олгох тухай хүсэлтийг НҮБУӨСК/ЦХМ-ын вэб хуудсанд “нягтлагдаж буй” хэмээн тэмдэглэх болон НҮБУӨСК/ЦХМ-ын мэдээллийн сүлжээгээр энэ тухай мэдэгдэл түгээнэ.

(2) Дахин нягтлалын хамрах цар хүрээ, дэг

- ☞ ГЗ нь өөрийн дараагийн хурлаар ЯББ-г олгох тухай хүсэлтийг дахин нягтлах эсвэл олгохыг зөвшөөрөх шийдвэр гаргана.
- ☞ Хэрэв ГЗ дахин нягтлал хийхээр болбол, түүгээр хамрах ТМБ-ын зүгээс залилан, хууль бус үйлдэл хийх болон чадвар дутах асуудлуудын цар хүрээ болон дахин нягтлалын багийн бүрэлдэхүүнийг тус хурлаар тодорхойлно. Дахин нягтлалын баг нь ГЗ-ийн 2 гишүүн болон шаардлагатай бусад мэргэжилтнээс бүрдэнэ.
- ☞ Дахин нягтлалын баг нь ТМБ, ТО-оос нэмэлт мэдээлэл авч, дүн шинжилгээ хийнэ.

(3) Дахин нягтлалын явц

- ☞ Дахин нягтлалын хамрах цар хүрээний талаарх ГЗ-ийн шийдвэрийг хурлын тайланд багтаан нийтэд танилцуулна.
- ☞ Нэмэлт мэдээлэл авах хүсэлтийг ТМБ, ТО-д явуулна. Хариултыг ийм хүсэлт хүлээн авснаас хойш **ажлын 5 өдрийн** дотор НБДН газраар дамжуулан дахин нягтлалын багт хүргүүлнэ.
- ☞ Санал, мэдээлэл цуглуулах үүрэг бүхий ГЗ-ийн 2 гишүүн ГЗ-ийн удаах хурлаас **2-оос доошгүй долоо хоногийн** өмнө зөвлөмж боловсруулж, дотоод сүлжээгээр түгээнэ.

(4) Дахин нягтлалын дүгнэлт

- ☞ ГЗ-ийн дахин нягтлал хийх шийдвэр гаргаснаас хойш **30 хоногийн** дотор дахин нягтлалыг хийнэ.
- ☞ ГЗ нь ЯББ олгох тухайн хүсэлтийг зөвшөөрөх, ЯББ олгохыг зөвшөөрөхийн өмнө дахин нягтлалын үр дүнд үндэслэн засвар өөрчлөлт хийхийг ТМБ-аас хүсэх, эсвэл ЯББ олгохыг үл зөвшөөрөх шийдвэр гаргана.
- ☞ ГЗ нь дахин нягтлалын үр дүнг ТМБ, ТО-д мэдээлж, ЯББ олгох тухай хүсэлтийн талаарх шийдвэр болон үндэслэлийг олон нийтэд танилцуулна.
- ☞ Хэрэв дахин нягтлалаар ТМБ-ын үйл ажиллагаатай холбоотой асуудлыг илрүүлбэл, ТМБ-д гэнэтийн шалгалт хийх эсэхийг ГЗ авч үзэх болно.

НЭМЭЛТ: Дахин нягтлалын зардлыг хариуцах

Дахин нягтлалын зардлыг ГЗ хариуцана. Хэрэв ГЗ нь ЯББ олгохгүй байх шийдвэр гаргаж, ТМБ-г зохисгүй ажилласан эсвэл чадвар дутсан хэмээн дүгнэвэл ТМБ бүх зардлыг ГЗ-д нөхөн төлнө. Туршлага хуримтлагдах хэрээр энэ заалтыг эргэн хэлэлцэнэ. [Г329 Х16, хэ21]

## 14. Гажилт

- ◆ТМБ нь төслийн үйл ажиллагааг бүртгүүлэх эсвэл ЯББ-г олгох тухай хүсэлт гаргахын өмнө БАр ба/эсвэл бүртгэгдсэн төслийн баримт бичгийн заалтуудаас гажсан тохиолдлуудын талаар ГЗ-д мэдэгдэж, эдгээийг хэрхэн авч үзэхээр төлөвлөж буйгаа тайлбарлана. [Г324 Х30, хэ1]
- ◆Бүртгэгдсэн төслийн үйл ажиллагааны мөн чанар, нөхцөл байдал, орчин өөрчлөгдсөний улмаас ялгаралтын бууралтыг тооцох, дагаж мөрдөх журмыг өөрчлөх шаардлага гарах тохиолдолд гажилт гаргах тухай хүсэлт тавьж болно. Гажилт нь төсөл тус бүрээр тусгайлан заагдана.
- ◆Харин (i) хяналт шинжилгээний төлөвлөгөө нь бүртгэгдсэн төслийн үйл ажиллагаанд ашигласан хяналт шинжилгээний аргачлалд нийцэхгүй байх, (ii) батлагдсан аргачлалыг төслийн үйл ажиллагаанд ашиглах боломжгүй болсон, (iii) Бүлэг 7-6-д заасан өөрчлөлтийг бий болгох, эсвэл (iv) батлагдсан аргачлалд заасан үндсэн өгөгдөхүүн утга өөрчлөгдөхөөр байх зэрэг тохиолдолд гажилт гаргах тухай хүсэлт тавих нь зохисгүй. [Г330 Х1, хэ12-13]

### (1) Гажилт хийх тухай хүсэлт гаргах нь [Г324 Х30, хэ4-9]

#### (а) Бүртгэл: БАр-аас гажих тухай хүсэлт

Хэрэв ТМБ нь магадлагаа хийх явцдаа ТО БАр-аас гажсаныг тодорхойлбол, тухайн төслийг бүртгүүлэх хүсэлт гаргахын өмнө гажилтыг хүлээн авах эсэх талаар ГЗ-аас заавар авч болно. Хэрэв ТМБ нь БАр-аас гажих нь тус аргачлалд засвар өөрчлөлт оруулах шаардлагыг харуулсан хэмээн үзвэл, БАр-д засвар өөрчлөлт оруулах журмыг даган мөрдөнө.

#### (б) Олголт: Бүртгэгдсэн төслийн үйл ажиллагааны заалтаас гажих тухай хүсэлт

Хэрэв ТМБ нь нотолгоо хийх явцдаа ТО бүртгэгдсэн ЦХМ төслийн үйл ажиллагааны хяналт шинжилгээний төлөвлөгөөнөөс гажсаныг тодорхойлбол, баталгаажуулалт хийхээс татгалзаж энэ тухай ГЗ-д мэдэгдэх эсвэл нотолгоо/баталгаажуулалтын шийдвэрээ гаргахын өмнө энэ асуудлаар ГЗ-өөс заавар авч болно.

Хэрэв заавар авах бол, ТМБ нь интернетын зориулалтын сувгаар “М-ЦХМ-ГАЖ” маягыг бөглөж, гажилт гаргах тухай хүсэлт тавина.

НБДН газар маягыг хүлээн авмагцаа баримт бичгийг ГЗ-д хүргүүлнэ ((а) тохиолдолд, АК-д мөн адил хүргүүлнэ).

☞ Хэрэв НБДН газар АК-ийн даргатай зөвшилцөж ((б) тохиолдолд ГЗ-ийн даргатай зөвшилцөж), гажилт гаргах тухай хүсэлт нь холбогдох нөхцөлд шаардлагад нийцээгүй хэмээн үзвэл, ТМБ-г БАр-д засвар өөрчлөлт оруулах хүсэлт тавих ((б) тохиолдолд гажилт гаргах тухай хүсэлтийг дахин тавих)-ыг зөвлөх болно. НБДН газар тухайн хүсэлтийг ГЗ-д дамжуулсан өдрийг хүсэлт хүлээн авсан өдөр хэмээн үзнэ. ТМБ-аас өөрөөр заагаагүй бол, гажилт гаргах тухай хүсэлтийн талаарх мэдээллийг олон нийтэд танилцуулна.

### (2) Гажилт хийх тухай хүсэлтийг шийдвэрлэх нь [Г324 Х30, хэ10-12]

ГЗ-ийн Дарга нь холбогдох комисс ба/эсвэл АХ-ын ахлагчтай зөвшилцөн **ажлын 5 хоногт** багтаан шийдвэр гаргана.

☞ Хүсэлтийн талаар холбогдох комисс, АХ-үүд техникийн дүгнэлт гаргана.  
☞ Хэрэв нэмэлт мэдээлэл шаардлагатай бол, НБДН газар энэ тухай ТМБ-д мэдэгдэх болон тэрээр энэ мэдээллийг даруй хүргүүлнэ. Хүлээж авсан мэдээллийг ГЗ, комисс, АХ-ын гишүүдэд дамжуулна.

Хэрэв комисс ба/эсвэл АХ-т техникийн тайлбар шаардлагагүй, эсвэл комисс ба/эсвэл АХ ийм техникийн тайлбарыг хийсэн бол, ГЗ нь Даргын бэлтгэсэн шийдвэрийн төсөлд үндэслэн цахим сувгаар санал хураах аргаар дараах шийдвэр гаргана. Үүнд:

- ☞ Гажилт гаргах тухай хүсэлтийг хүлээн авах эсэх;
- ☞ ТМБ-д нэмэлт заавар өгөх эсэх; болон
- ☞ Шаардлагатай бол, ерөнхий тайлбарыг бүх ТМБ болон ТО-д хүргүүлэх эсэх.

ГЗ-ийн шийдвэр гарсан даруйд НБДН газар энэ тухай ТМБ-д мэдэгдэнэ. Хэрэв ерөнхий талбарыг бүх ТМБ болон ТО-д хүргүүлэхээр шийдсэн бол НБДН газар тус зааврыг олон нийтэд нээлттэй болгоно.


### (3) Гажилт хийх тухай хүсэлтийг комисс/АХ хэлэлцэх нь [Г324 Х30, хэ13-14]

Хэрэв гажилт гаргах тухай хүсэлтийг комисс ба/эсвэл АХ хэлэлцэх бол комисс/АХ-н ахлагч нь:

☞ Комисс/АХ-ын дараагийн уулзалтаар хэлэлцэх эсэх;  
☞ Эсвэл, цахим суваг ашиглан хэлэлцэх эсэхийг шийднэ.

Комисс/ажлын хэсэг нь санал болгож буй гажилтыг боломжтой бол дараагийн хурлаараа хэлэлцэж, түүнийг хүлээн авах эсэх ба/эсвэл шаардлагатай тайлбарыг өгөх эсэх талаар ГЗ-д зөвлөмж гаргана. Комисс/АХ-д зөвлөмжийн төсөл боловсруулах 2 хүртэлх гишүүнийг томилно.

## 15. ЯББ-н хуваарилалт



- ◆ ГЗ-өөс ЦХМ төслийн үйл ажиллагаанд ЯББ олгох зааврыг авсны дараагаар ЦХМ-ын регистр эрхлэгч нь ЯББ-н заасан хэмжээг ЦХМ-ын регистр дэх ГЗ-ийн Дамжих Данс руу шилжүүлнэ. [ТХ/2005/8/Н1, ху19 хэ66]
- ◆ Хуваарийн дагуу ЯББ-г олгох ажлыг ЦХМ-ын захиргааны зардлыг нөхөх орлогын шимтгэл (ОШ-Админ) төлөгдсөний дараа хийнэ. [ТХ/2005/8/Н1, ху98 хэ37]
  - ☞ ОШ-Админ-ы хэмжээг дараах байдлаар тогтооно. Үүнд:
    - ⇒ Тухайн жилд олгогдсон эхний 15,000 тонн-СО<sub>2</sub>-д ЯББ бүрт **0.10 ам.доллар**;
    - ⇒ Тухайн жилд, 15,000 тонн-СО<sub>2</sub>-оос давсан хэмжээнд олгогдсон ЯББ бүрт **0.20 ам.доллар**. [ГЗ23 Х35, хэ1]
  - ☞ ОШ-Админ-ы хэмжээнээс регистрийн хураамжийг хасна. (Бүлэг 11-3)
  - ☞ Буурай хөгжилтэй улсуудад хэрэгжүүлэх ЦХМ-ийн төслүүдийг ямарваа бүртгэлийн хураамж болон ЯББ олгогдох үеийн орлогын шимтгэлээс –аас чөлөөлнө.

Олгогдсон ЯББ-н хэмжээнээс, уур амьсгалын өөрчлөлтийн таагүй нөлөөнд ихээхэн өртөх магадлалтай хөгжиж буй Талуудад эдгээр өөрчлөлтөнд дасан зохицох зардлыг нь нөхөх зорилгоор 2 хувийг орлогын шимтгэл (ОШ-Зохиц) болгон авна. [ТБХ/2001/13/Н2, ху23 хэ15(а)]

- ☞ Нэн буурай хөгжилтэй Талуудад хэрэгжих ЦХМ төслийн үйл ажиллагааг бүртгэлийн хураамж болон орлогын шимтгэлээс чөлөөлнө. [ТБХ/2001/13/Н2, ху23 хэ15(б)]

- ◆ ЯББ-г ТО-н хүсэлтийн дагуу тэдгээрийн регистр дэх данс руу шилжүүлнэ. [ТХ/2005/8/Н1, ху20 хэ66(б)]
- ◆ ЯББ-н хуваарилалтыг ТО бие даан шийдвэрлэнэ. [НэрТ, хув3, ху26]
  - ☞ ТО нь бүртгэлийн үед тогтоосон эсвэл улмаар засан өөрчилсөн “харилцаа холбооны дэг журам”-ыг мөрдөж, НБДН газраар дамжуулан ГЗ-тэй бичгээр харилцана.
  - ☞ Хэрэв ТО нь ЯББ-н хуваарилалтыг шийдэхэд оролцохыг хүсэхгүй бол ЯББ-г хуваарилах тухай хүсэлт тавигдах үеэс хойшгүйгээр энэ тухай НБДН газраар дамжуулан ГЗ-д мэдэгдэнэ.
  - ☞ ЯББ-г хуваарилах тухай хүсэлтийг түүнд гарын үсэг зурсан талууд бүгд зөвшөөрч, зохих баримтанд гарын үсэг зурж баталгажуулсан тохиолдолд өөрчилж болно. [НэрТ, хув3, ху27]
- ◆ Нэг удаа олгогдсон ЯББ-г хэсэгчлэн хуваарилах хүсэлт тавьж болно. [ГЗ21 Тай, хэ70]

### НЭМЭЛТ: Х.1-д орсон Талын ТО-ын Түр данс (Бүлэг 20-1)

Х.1-д орсон Талууд болон тэдгээрийн ТО-н үндэсний регистр ажиллагаанд орох хүртэл дамжих данснаас ЯББ-г хүлээн авч үндэсний регистр дэх данс руу нь шилжүүлэх ажлыг гүйцэтгэх зорилгоор ЦХМ-ын регистрд Х.1-д орсон Талуудад түр данс нээнэ. [ТБХ/2004/2/, ху15 хэ57]

### НЭМЭЛТ: ЯББ-г ЦХМ-ын регистрээс шилжүүлэх

ЦХМ-ын регистр нь Х.1-д ороогүй Талууд болон тэдгээрийн байгууллагуудад ЦХМ-ын регистр дэх данснаасаа үндэсний данс руугаа ЯББ-г шилжүүлэх боломж олгоно. [ТБХ/2004/2/, ху15 хэ58]



## 16. ХүХ ялгаралтын бууралтын тооцоот хугацааг сунгах нь

[ГЗ36 Х43]

Хэрэв ТМБ-аас төслийн анхны суурь өгөгдөл хүчин төгөлдөр хэвээр, эсвэл шинэ мэдээлэлд тулгуурлан шинэчлэгдсэн болохыг тодорхойлж, энэ тухай ГЗ-д мэдэгдсэн бол тухайн бүртгэгдсэн ЦХМ төслийн үйл ажиллагааны тооцоот хугацааг сунгаж болно.

### (1) ТББ-г шинэчлэн боловсруулах нь

ТО нь суурь өгөгдөл, ялгаралтын бууралтын тооцоо болон хяналт шинжилгээнд хамаарах ТББ-ийн хэсгүүдийг БАр-д тулгуурлан дараах байдлаар шинэчилнэ. Үүнд:

- ☞ а) Хэрэв тохирох бол, бүртгэгдсэн ЦХМ төслийн үйл ажиллагааны анхны ТББ-д ашигласан БАр-н хамгийн шинэ хувилбарыг ашиглах,
- ☞ б) Хэрэв анхны ТББ-д ашигласан суурь болон хяналт шинжилгээний аргачлал нь ЦХМ төслийн үйл ажиллагааг бүртгүүлсний дараа эргэн татагдаж нэгдмэл аргачлалаар солигдсон бол тухайн нэгдмэл аргачлалын хамгийн шинэ хувилбарыг ашиглана;
- ☞ в) Хэрэв бүртгэгдсэн ЦХМ төсөлд орсон засвар өөрчлөлт, эсвэл суурь өгөгдлүүд шинэчлэгдсэний улмаас дээрх а) эсвэл б)-д заасан хувилбарууд нийцэхгүй бол ТО нь нэг бол өөр ашиглаж болох БАр-г сонгож, эсвэл тооцоот хугацааг сунгах зорилгоор БАр-аас гажих тухай хүсэлтийг ТМБ-аар дамжуулан гаргана.

### (2) Тооцоот хугацааг сунгуулах хүсэлт гаргах нь

ТО нь бүртгэгдсэн ЦХМ төслийн үйл ажиллагааны тооцоот хугацаагаа сунгуулах тухайгаа шинэчилсэн ТББ болон ТМБ-аа сонгосон тухай мэдээллийн хамт тухайн **тооцоот хугацаа дуусахаас 6-9 сарын өмнө** НБДН газарт мэдэгдэнэ.

- ☞ Тооцоот хугацааг сунгахад оролцогч Талуудаас шинээр зөвшөөрөл авах шаардлагагүй.
- ☞ Тооцоот хугацааг сунгах хүсэлт гаргахад хураамж төлөхгүй.

ТМБ-ын магадлагаа дараах асуудлыг авч үзнэ. Үүнд:

- а) анхны суурь хувилбар, эсвэл шинэчлэгдсэн хувилбарын хүчин төгөлдөр байдал;
- б) холбогдох ГЗ-өөс гаргасан зааварчилгаанд үндэслэсэн үндэсний болон салбарын холбогдох шинэ бодлого, нөхцөл байдал суурь хувилбарт үзүүлэх нөлөө;
- в) суурь хувилбар, эсвэл шинэчлэгдсэн хувилбар хүчин төгөлдөр хэвээр байгааг тодорхойлоход ашигласан БАр оновчтой эсэх болон тухайн тооцоот хугацаан дахь ялгаралтын бууралтын тооцоо

ТМБ нь “ЦХМ төслийн үйл ажиллагааны тооцоот хугацааг сунгах маягт” (М-ЦХМ-СУН)-г ашиглан тухайн бүртгэгдсэн ЦХМ төслийн үйл ажиллагааны тооцоот хугацааг сунгах тухай хүсэлтийг шинэчилсэн ТББ болон магадлагааны тайлангийн хамт мэдүүлнэ.

НБДН газар тооцоот хугацааг сунгах тухай мэдэгдлийг тухайн тооцоот хугацаа дуусахаас 6 сарын өмнө хүлээж аваагүй тохиолдолд, тооцоот хугацаа дууссанаас эхлэн тухайн тооцоот хугацаа дахин сэргээгдэх хүртэл хугацаанд ТО-д ямарваа ЯББ олгогдохгүй болно.

### (3) Хүсэлтийг шийдвэрлэх нь

НБДН газар нь бүртгэгдсэн ЦХМ төслийн үйл ажиллагааны тооцоот хугацааг сунгах хүсэлт хүлээн авмагцаа М-ЦХМ-СУН-д заасан бүх мэдээ, баримтыг ТМБ хүргүүлсэн эсэхийг тогтооно.

НБДН газар нь хүсэлт бүрэн гүйцэд болохыг тогтоосон бол түүнийг НҮБҮӨСК/ЦХМ-ыг вэб хуудсанд олон нийтэд нээлттэйгээр **4 долоо хоногийн хугацаагаар** байрлуулна. НБДН газар нь бүртгэгдсэн ЦХМ төслийн үйл ажиллагааны тооцоот хугацааг сунгах тухай хүсэлт тавигдсаныг НҮБҮӨСК/ЦХМ-ын вэб хуудсаар зарлан, энэ тухай хүсэлт гаргасан ТМБ, ТО болон ТҮТ-д мэдэгдэнэ.

Сунгах тухай хүсэлт нийтлэгдсэнээс хойш 4 долоо хоногийн дотор дахин нягтлах тухай санал гарахгүй бол тухайн бүртгэгдсэн ЦХМ төслийн үйл ажиллагааны тооцоот хугацааг сунгагдсанд тооцно.

- ☞ Тооцоот хугацааг сунгах тухай хүсэлтийг дахин нягтлахад мөрдөх журам нь бүртгэлийг дахин нягтлах журамтай адил байна. (Бүлэг 11-2)
- ☞ Анхны тооцоот хугацаа дууссаны дараахь өдөр нь сунгагдсан хугацаа эхлэх өдөр байна.

## 17. ЦХМ-ын жижиг төсөл (ЦЖТ)

### 17-1. ЦХМ-ын жижиг төслийн тодорхойлолт (ЦЖТ)

Дараах ЦХМ-ын жижиг төслийн үйл ажиллагаанд хялбарчилсан дэг журмыг мөрдөнө. [ТХ/2005/8/Н1, ху43-45]

☞ Дахин сунгагдах тооцоот хугацаатай төслийн хувьд ийнхүү хүсэлт гаргахдаа холбогдох нөхцөл шаардлагад нийцсэн хэвээр эсэхээ дахин үнэлнэ. [НэрТ, хув3, ху31]

1-р төрлийн буюу 15 МВт (эсвэл зохих эквивалент)-аас дээшгүй хүчин чадал бүхий сэргээх эрчим хүчний төслүүд хэвээр байна

[ТХ/2006/10/Н1, ху8 хэ28(а)]

☞ Дээд “хүчин чадал” гэдэг нь тоног төхөөрөмж эсвэл үйлдвэрлэлийн ашиглалтын бодит ачааллыг харгалзаагүй, суурилагдсан/ заагдсан хүчин чадал байна;

☞ Эрчим хүчний МВт (MW(e))-ыг хамгийн түгээмэл ашиглаж, дулааны МВт (MW(th))-ийг 9ТМ мөн эрчим хүчнийхээс гарган илэрхийлж болох тул МВт-ыг эрчим хүчний МВт хэмээн тодорхойлж, бусад тохиолдолд зохих хөрвөлтийн коэффициент ашиглаж байхыг ГЗ-өөр шийэрлэсэн болно. [НэрТ, хув3, ху31]

#### НЭМЭЛТ: Тоног төхөөрөмжийн үзүүлэлт


[НэрТ, хув3, ху19]

◆ Тоног төхөөрөмжийн үзүүлэлтийг тодорхойлохдоо ТО нь дараахийг ашиглана. Үүнд:

- ☞ (а) ТХ/2006/10/Н1 ху9 хэ28-д заасан зохих утга;
- ☞ (б) Хэрэв (а)-д заасан утга байхгүй бол, тухайн төхөөрөмжийн үзүүлэлтийн үндэсний стандарт;
- ☞ (в) Хэрэв (б)-д заасан утга байхгүй бол, ISO болон IEC зэрэг уг төхөөрөмжийн үзүүлэлтийн олон улсын стандарт;
- ☞ (г) Хэрэв (в)-д заасан утга байхгүй бол үндэсний болон олон улсын итгэмжлэгдсэн байгууллагаар магадлуулсан, үйлдвэрлэгчийн заасан үзүүлэлт.

◆ ТО нь төслийн үйл ажиллагааны хүрээнд суурилуулсан төхөөрөмжинд бие даасан байгууллагын хийсэн туршилтын үр дүнг ашиглах эрхтэй байна.


2-р төрлийн буюу эрчим хүчний ашиглалтыг сайжруулах замаар эрчим хүчний хэрэглээ ба/буюу хангамжийг багасгах төслүүдийн хувьд жилд 60 ГВтцаг (эсвэл зохих эквивалент)-ын хүчин чадал бүхий төслүүдээр хязгаарлана. [ТХ/2006/10/Н1, ху8 хэ28(б)]



☞ Хэрэглээ болон хангамжийн талын төслүүдийг хамрах бөгөөд төслийн үр дүнд бий болох хэмнэлт нь хамгийн ихдээ 60 ГВтцаг байна. 60 ГВтцаг-н хэмнэлт гэдэг нь 15 МВт хүчин чадал бүхий үйлдвэрийн 4000 цагийн хэрэглээ буюу  $60 \times 3.6 \text{ ТЖ} = 216 \text{ ТЖ}$  (үүнд ТЖ гэдэг нь тера жоуль)-тай тэнцүү байна. [НэрТ, хув3, ху31]

3-р төрлийн эсвэл бусад төсөл гэдэг нь нэг жилийн ялгаралтын дундаж бууралт нь 60 Ктонн-СО<sub>2</sub>-оос хэтрэхгүй байх төслөөр хязгаарлагдана

[ТХ/2006/10/Н1, ху8 хэ28(в)]



**Нэгээс олон бүрэлдэхүүн хэсэг бүхий төслийн үйл ажиллагаа**

- ◆ Нэг ТО хэрэгжүүлж буй, тус бүр харилцан хамааралгүй батлагдсан төрөл/аргачлалыг ашигласан 2-3 харилцан адилгүй үйл ажиллагаанаас бүрдэх төслийн үйл ажиллагааг хэлнэ. [НэрТ, хув3, ху25]
- ◆ Төслийн үйл ажиллагааны бүрэлдэхүүн хэсэг бүр тухайн төслийн бусад үйл ажиллагаанаас өгөгдөл авах буюу түүнд өгөгдөл өгөх учиртай. [НэрТ, хув3, ху25]
- ◆ Нэг төрөлд хамрагдах төслийн үйл ажиллагааны бүрэлдэхүүн хэсгүүдийн нийлбэр нь ЦЖТ төслийн үйл ажиллагаанд тавигдах хязгаараас хэтрэхгүй байна хэмээн ГЗ заасан болно. [Г328 Тай, ху56]
- ◆ Нэгээс олон бүрэлдэхүүн хэсэгтэй төслийн үйл ажиллагааны хувьд хэрэв бүрэлдэхүүн хэсэг тус бүрийн төрөл/ангилал, ЦЖТ төслийн үйл ажиллагааны технологи/арга болон ашигласан суурь өгөгдөл, хяналт шинжилгээний аргачлалыг тус тусад нь хийсэн бол нэгдсэн нэг ТББ өргөн мэдүүлэхийг ГЗ зөвшөөрсөн болно. [Г328 Тай, хэ57]
  - ☞ Хэрэв төслийн хоёр өөр үйл ажиллагааны хувьд ижил төрлийн төхөөрөмж ашиглан, ижил төрлийн бүтээгдэхүүнийг ижил аргаар үйлдвэрлэх бол тэдгээрийг ижил технологи ашиглаж буйд тооцно.
  - ☞ Хэрэв төслийн хоёр өөр үйл ажиллагааны хувьд ижил үйлдэл хийж, ижил үр дүнд хүрч байвал тэдгээрийг ижил арга ашиглаж буйд тооцно (ж. Хоёулаа түлшний төрөл солих гэх мэт менежментийн аргыг ашиглах). [НэрТ, хув3, ху28]

**НЭМЭЛТ: ЦЖТ төслийн үйл ажиллагаа тогтоогдсон хязгаараас хэтэрсэн бол**

Хэрэв төслийн үйл ажиллагаа нь тооцоот хугацааныхаа аль нэг жилд тус төрөлд тавигдсан хязгаараас хэтэрсэн бол, тухайн төслийн тухайн жилд олгогдох ялгаралтын бууралтын хэмжээг ТО-н зүгээс тухайн жилийн хувьд ЦХМ-ЦЖТ-ТББ-д заасан, ялгаралтын бууралтын тооцоолсон дээд хэмжээгээр хязгаарлана. [НэрТ, хув3, ху30]

## 17-2. Хялбарчилсан дэг, журам

- ◆ ЦЖТ төслийн үйл ажиллагаа нь ЦХМ Д/Ж-д заасан төслийн мөчлөгийг даган мөрдөнө. Гэхдээ, холбогдох зардлыг бууруулахын тулд ЦЖТ төслийн үйл ажиллагааны дэг, журмыг дараах байдлаар хялбарчилсан болно. Үүнд: [ТХ/2005/8/Н1, ху45 хэ9]
  - ☞ Төслийн үйл ажиллагааг төслийн мөчлөгийн дараах шатанд багцалж болно. Үүнд ТББ, магадлагаа, бүртгэл, хяналт шинжилгээ, нотолгоо болон баталгаажуулалт орно;
  - ☞ ТББ-д тавигдах нөхцөл шаардлагыг цөөлсөн (Х.1-2);
  - ☞ Төслийн суурь өгөгдлийг тогтоох зардлыг бууруулах зорилгоор суурь өгөгдлийн аргачлалыг төслийн төрлөөр нь хялбарчилсан;
  - ☞ Хяналт шинжилгээний зардлыг бууруулахын тулд хяналт шинжилгээний төлөвлөгөөг хялбарчилсан;
  - ☞ Магадлагаа, нотолгоо болон баталгаажуулалтыг нэг Магадлах байгууллага (МБ) гүйцэтгэхийг зөвшөөрсөн.
- ◆ ХүХ-ийн бууралтын тооцоог нэвчилтийг харгалзаж сунгахдээ тухайн төслийн төрөлд хамаарах Хавсралт Б (Суурь өгөгдөл, хяналт шинжилгээний хялбарчилсан аргачлалууд)-ын заалтыг дагаж мөрдөнө. ГЗ нь Хавсралт Б-д нэмэгдсэн төслийн бусад төрлийн нэвчилтийн тооцоог хялбарчлах асуудлыг шийдвэрлэнэ.
  - ☞ Нэвчилтийг харгалзах шаардлагатай тохиолдолд зөвхөн Х.1-д ороогүй Талууд дахь хил хязгаарт хамаарна. [НэрТ, хув3, ху21]
- ◆ ЦХМ-ын томоохон төслийн үйл ажиллагаанаас ялгарах бусад зүйлүүд:
  - ☞ ГЗ-БОБ-оор дүгнэлт гаргуулахад, гишүүн нь **хуанлийн 15 хоног** (томоохон төсөлд бол 20 хоног)-ийн дотор үнэлгээ хийж, НБДН газарт хүргүүлнэ. НБДН газар нь гишүүнээс тус үнэлгээг хүлээн авснаас хойш НБДН газарт **хуанлийн 5 хоног** (томоохон төсөлд бол 10 хоног)-ийн дотор тухайн бүртгүүлэх тухай хүсэлтийн хураангуйг боловсруулж, үнэлгээний хамт ГЗ-д хүргүүлнэ. [ГЗ29 Х14, хэ24-25]
  - ☞ ГЗ-ийн бүртгэх тухай шийдвэрийг хэрэв тухайн ЦХМ төслийн үйл ажиллагааг дахин нягтлах тухай санал ирээгүй бол 4 (томоохон төсөлд бол 8) долоо хоногийн дараа эцсийн шийдвэрт тооцно. [ТХ/2005/8/Н1, ху48 хэ24]

**НЭМЭЛТ: Суурь өгөгдөл, хяналт шинжилгээний хялбарчилсан аргачлал**

Дараахь баримт бичгүүдийг дагаж мөрдвөл зохино.

- ☞ ЦХМ-ийн жижиг төслийн (ЦЖТ) батлагдсан аргачлалууд (БАЗ). (Х.3)
- ☞ “ЦЖТ аргачлалд тайлбар хийх журам” [ГЗ 34 Х6]
- ☞ “ЦЖТ аргачлалыг дахин хянах журам” [ГЗ 34 Х7]
- ☞ “ЦЖТ аргачлалын санал өргөн мэдүүлэх болон хэлэлцэх журам” [ГЗ 37 Х8]

**ЦЖТ төслийн үйл ажиллагааны нэмэгдэл чанар** [[http://cdm.unfccc.int/methodologies/SSCmethodologies/AppB\\_SSC\\_AnxA.pdf](http://cdm.unfccc.int/methodologies/SSCmethodologies/AppB_SSC_AnxA.pdf)]

- ◆ Хавсралт Б-ийн нэмэлт А нь (=ТХ/2005/8/Н1 ху52) жижиг төслийн үйл ажиллагаа нь өөр нөхцөл байдалд хэрэгжихгүй байх байсан (өөрөөр хэлбэл, нэмэгдэл болох)-ыг нотлохын тулд ТО ашиглаж болох саад бэрхшээлийн жагсаалтыг заасан болно.
- ◆ ТО нь дараах саад бэрхшээлийн дор хаяж аль нэгийн улмаас тухайн төслийн үйл ажиллагаа хэрэгжихгүй байх байсныг нотлох тайлбар өгнө. Үүнд:

**Хөрөнгө оруулалтын саад:**

- ☞ Төслийн үйл ажиллагааны эдийн засгийн илүү үр ашигтай хувилбар нь ялгаралтыг ихэсгэх байсан;

**Тогтсон горимоос үүсэх саад:**

- ☞ Тогтсон горим, үйлчилж буй хууль дүрэм, бодлогын шаардлага нь илүү их ялгаралт бүхий технологи ашиглахад хүргэх байсан;

**Технологийн саад:**

- ☞ Шинэ технологийн ирээдүйн бүтээмжийн тодорхой бус байдал болон зах зээлд эзлэх байр суурь нь бага байх зэргийг улмаас эрсдэл нь харьцангуй бага, арай хоцронги технологийг төслийн үйл ажиллагаанд ашиглах нь ялгаралтыг ихэсгэх байсан;

**Бусад саад:**

- ☞ Төслийн үйл ажиллагаа хэрэгжихгүй байх тохиолдолд, бүтцийн саад, мэдээллийн хомсдол, удирдлага, зохион байгуулалтын чадавхи, байгууллагын хүчин чадал, санхүүгийн чадамж эсвэл шинэ технологийг хүлээж авах чадвар зэрэг ТО-н тогтоосон бусад шалтгааны улмаас ялгаралт илүү өндөр түвшинд байх байсан.

- ◆ Төслийн үйл ажиллагаа өөр нөхцөлд байдалд хэрэгжихгүй байх байсныг дээрхэд үндэслэсэн тайлбараас гадна тоон баримтаар нотолж болно.

**-Жижиг оврын төслийн үйл ажиллагааны нэмэгдэл чанарыг харуулах жишээ** [ГЗ 35 Х34]

- ☞ Хөрөнгө оруулалтын хүндрэлтэй асуудлуудад зохих санхүүгийн индикатор ашиглан хийсэн хөрөнгө оруулалтын харьцуулалтын шинжилгээ, зардлын бенчмарк болон энгийн шинжилгээ (эрчим хүчний эцсийн хэрэглээний үр ашгийн цорын ганц орлогын эх үүсвэр нь ЦХМ-ын орлого байх) г.м орно. Эдгээр шинжилгээнд өөрийн улсын, эсвэл олон улсын санхүүгийн бүртгэлийн журам, стандартыг ашиглах нь зүйтэй.
- ☞ Санхүүжилт олох хүндрэлд (төсөл нь ЦХМ –ын орлогын эх үүсвэргүйгээр санхүүжилт олох боломжгүй) ЦХМ –аас бусад орлогоор санхүүжилт авах боломж хязгаарлагдмал гэдгийг, тухайлбал зээл батлагдах эсэхэд ЦХМ-аас авах санхүүжилт чухал нөлөө үзүүлэх тухай тодорхойлолтыг санхүүжүүлэгч банкнаас авсан байх г.м. байдал орно.
- ☞ Технологийн хүндрэлтэй асуудалд тухайн технологийг ашиглах хүн хүчний боломж дутмаг, технологийг ашиглах дэд бүтэц байхгүй, нэвтрүүлэх технологи олдоц муутай болон технологийн эрсдэл хэт өндөр байх зэргүүд багтана.
- ☞ Өмнөх түршлага байхгүйн улмаас гарах хүндрэлүүдэд тухайн төсөл нь ашиглах технологи, хэрэгжих бүс нутаг, салбар, хөрөнгө оруулалтын төрөл, хөрөнгө оруулагч болон зах зээлийнхээ хувьд хамгийн анхдагч байх тохиолдлууд хамаарна.

## 17-3. ЦЖТ-г багцлах нь

**Багцлах нь** [НэрТ, хув3, ху12]

- ◆ Багцлах гэдэг нь хэд хэдэн ЦЖТ төслийг тус бүрийнх нь шинж чанарыг алдалгүйгээр ЦХМ-ын төслийн нэг үйл ажиллагаа болгон нэгтгэхийг хэлнэ.
- ◆ Тухайн багц дахь төслийн үйл ажиллагааг нэг буюу түүнээс олон дэд багц болгож болох бөгөөд төслийн үйл ажиллагаа бүр өөрийн шинж чанараа хадгална.
  - ☞ Эдгээр шинж чанар нь технологи/арга, байршил болон ашигласан суурь өгөгдлийн хялбарчилсан аргачлал зэрэг байж болно.
- ◆ Дэд багц дахь төслийн үйл ажиллагаа нь нэг төрөлд багтсан байна. Дэд багц дахь төслүүдийн хүчин чадлын нийлбэр нь тухайн төрөлд тавигдах хязгаараас хэтрэхгүй байна.

**Задлах нь** [ГЗ 36, X 27]

- ◆ Задлах гэдэг нь томоохон төслийн үйл ажиллагааг жижиг хэсгүүдэд хуваахыг хэлнэ.
- ◆ Томоохон төслийн үйл ажиллагааны хэсэг болох жижиг төслийн үйл ажиллагаанд ЦЖТ төслийн үйл ажиллагааны хялбарчилсан дэг, журмыг хэрэглэхгүй.
- ◆ Хэрэв дараах нөхцөл байдал бүхий ЦЖТ төслийн үйл ажиллагаа бүртгэгдсэн эсвэл бүртгүүлэхээр хүсэлт гаргасан байвал тухайн санал болгож буй жижиг төслийн үйл ажиллагааг томоохон төслийн үйл ажиллагааны задалсан хэсэгт тооцно. Үүнд:
  - ☞ Төслийн оролцогчид ижил;
  - ☞ Төслийн төрөл болон технологи/арга ижил;
  - ☞ Сүүлийн 2 жилийн хугацаанд бүртгэгдсэн;
  - ☞ Төслийн хил хязгаар нь санал болгож буй жижиг төслийн үйл ажиллагааны хил хязгаараас хамгийн ойр цэгтээ 1 км-ээс бага зайнд оршсон.
- ◆ Хэрэв санал болгож буй жижиг төслийн үйл ажиллагааг задалсан хэсэгт тооцсон хэдий ч, тухайн төсөл болон өмнө бүртгэгдсэн ЦЖТ төслийн үйл ажиллагааны цар хүрээний нийлбэр нь ЦЖТ төслийн үйл ажиллагаанд тавигдах хязгаараас хэтрээгүй бол тухайн төслийн үйл ажиллагаа нь ЦЖТ төслийн үйл ажиллагааны хялбарчилсан дэг, журмыг ашиглах эрхтэй байна.

**Ерөнхий шинж чанар** [ЦЖТ Е3 хув4, ху19 хэ1-8]

- ☞ Багцанд орох хүсэлтээ төслийн үйл ажиллагааг бүртгүүлэх хүсэлт гаргахдаа өгнө.
- ☞ Багцын бүтэц нь төслийн явцын туршид өөрчлөгдөхгүй. Бүртгэл хийгдсэний дараа тухайн багцаас төслийн үйл ажиллагааг хасахгүй бөгөөд түүнд үйл ажиллагаа нэмэхгүй.
- ☞ Багц дахь бүх төслийн үйл ажиллагаа нь нэг тооцоот хугацаатай байна.
- ☞ ТО нь бүртгүүлэх үед багцлах тухай хүсэлт хүргүүлэхдээ дараах агуулга бүхий мэдэгдлийг хавсаргана. Үүнд:
  - ⇒ Тус бүрийн төслийн үйл ажиллагааг багцлах тухай бүх ТО-ын зөвшөөрөл;
  - ⇒ ГЗ-тэй бүх ТО-г төлөөлөн харилцах нэг ТО томилох.
- ☞ Багцалсан төслийн үйл ажиллагааг ГЗ-д нэг дор өргөн мэдүүлнэ. Нийт багцын хувьд тооцолсон нэг жилийн ялгаралтын дундаж бууралтаар бүртгэлийн хураамжийг тогтооно.
- ☞ Хэрэв ГЗ-ийн 3 гишүүн эсвэл оролцогч Тал төслийн үйл ажиллагааг дахин нягтлах санал оруулбал, нийт багцыг дахин хянан үзнэ.
- ☞ Багцын талаарх мэдээллийг өгөх “М-ЦХМ-БАГЦ” маягыг бөглөсөн байна. (X.1-3)

**Зөвшөөрлийн бичиг** [ЦЖТ Е3 хув4, ху20 хэ12-14]

Хүлээн авагч Талуудын зөвшөөрлийн бичигт тухайн Тал өөрийн нутаг дэвсгэрт хэрэгжих төслийн үйл ажиллагаа нь багцанд орсон болохыг мэдэж байгааг илтгэсэн байна.

**Хяналт шинжилгээний нэгдсэн төлөвлөгөө** [НэрТ, хув3, ху24]

- ☞ Хэрэв төслийн үйл ажиллагааг багцалсан бол, тус бүр нь өөрийн хяналт шинжилгээний төлөвлөгөөтэй байх, эсвэл нийтэд нь нэгдсэн төлөвлөгөөгөөр хамрах боломжтой бөгөөд үүнийг ТМБ магадлагаа хийх үедээ тодорхойлно.
- ☞ Зөвхөн ижил төрөл болон технологи/арга бүхий төслүүд хяналт шинжилгээний нэгдсэн төлөвлөгөө ашиглаж болно.

**Магадлагаа болон нотолгоо** [ЦЖТ Е3 хув4, ху20 хэ15]

- ☞ Багцыг нэг ТМБ магадлаж болно.
- ☞ Нотолгооны нэг тайлан байхад хангалттай байхын зэрэгцээ тухайн хугацаанд нэг удаа ЯББ-ын олголт хийнэ. Мөн багц дахь бүх төсөлд нэг цуврал дугаар онооно.

## 18. ЦХМ-ын Ойжуулалт, ой нөхөн сэргээх төсөл (О/НС ЦХМ)

### 18-1. О/НС ЦХМ-ын тойм

О/НС ЦХМ-ын төслийн үйл ажиллагааны дүрэм журам буюу төслийн мөчлөг, ТББ-ын агуулга, магадлагаа болон нотолгооны журам нь ХүХ-н ялгаралтыг бууруулах ЦХМ-ын төслийн үйл ажиллагааныхтай ижил байна. О/НС ЦХМ-ын төслийн хувьд ялгаралтыг бууруулах ЦХМ-ын төслөөс ялгагдах гол ялгаа нь түүний байнгын бус байдал юм. Бусад төслийн хувьд ХүХ-ын ялгаралтын бууралтыг нэгэнт бий болгосон бол энэхүү бууралт байнгын байдаг бол, О/НС ЦХМ-ын төслийн хувьд ой модонд шингээгдсэн CO<sub>2</sub> нь ойн түймэр гарах, эсвэл хортон шавьжид өртөн ой сөнөх тохиолдолд эргэн ялгарах магадлалтай байдаг онцлогтой. Ийм байнгын бус байдлыг түр ЯББ (ТЯББ) болон урт хугацааны ЯББ (УЯББ) гэсэн өөр төрлийн ЯББ олгох замаар зохицуулна.

#### О/НС ЦХМ-ын төслийн үйл ажиллагаанд тухайн газар нутаг хамрагдах нь зохистой эсэхийг тодорхойлох журам [ГЗ 35 X18]

1. ТО нь тухайн газар нутаг О/НС ЦХМ-ын төсөлд хамрагдах нь зохистой эсэхийг дараах алхамуудыг мөрдөн нотолно.
  - ☞ (а) Төсөл хэрэгжиж эхлэх үед тухайн газар нутагт ой мод байхгүй гэдгийг дараахь мэдээллүүдийг тусган ил тодоор батлан харуулах:
    - Хүлээн авагч орны хувьд ой мод хэмээн тодорхойлох хүлээн зөвшөөрөгдсөн үзүүлэлтээс тухайн газар нутгийн ургамалжилт нь бага хэмжээнд байгаа;
    - Тухайн улсын хувьд ой мод хэмээн тодорхойлогдох хамгийн бага титэм бүрхэц, хамгийн нам өндөр зэрэг үзүүлэлтүүдэд тухайн газар нутагт ургаж буй байгалийн бүх залуу мод, бүх суулгац хүрэхгүй гэсэн тооцоолол гарах;
    - Мод огтлох зэрэг хүний үйл ажиллагаа эсвэл байгалийн бусад шалтгаанаас улбаалан ой модны нөөцөөс түр хугацаагаар хасагдсан бус байх.
  - ☞ (б) Тухайн үйл ажиллагаа нь ойжуулалт болон ой нөхөн сэргээх зорилготой гэдгийг харуулах
  - Ой нөхөн сэргээх төслийн үйл ажиллагааны хувьд (а) –д заасан нөхцлүүдийн улмаас ой мод биш гэдгийг батлахаас гадна 1989.12.31-ны байдлаар ой модоор бүрхэгдээгүй байсан гэдгийг харуулах ;
  - Ойжуулах төслийн үйл ажиллагааны хувьд тухайн газар нутгийн ургамалжилт нь хүлээн авагч талын хувьд ой мод хэмээн хүлээн зөвшөөрөгдсөн үзүүлэлтүүдээс дор хаяж 50 жилийн туршид бага байсан гэдгийг харуулах.
2. 1 (а), 1(б) алхамуудыг гүйцэтгэхийн тулд ТО нь ой мод болон ой модгүй газар нутгийн ялгаатай байдлыг тод харуулахуйц мэдээллийг хүлээн авагч улсад баримталж буй тодорхой үзүүлэлтэнд тулгуурлан дараах мэдээлэл зэргийг ашиглан үзүүлэх ёстой:
  - (а) Газар дээрх тандалтын мэдээллээр бататгагдсан агаарын болон хиймэл дагуулын зураг
  - (б) Газрын зураг, орон зайн тоон мэдээллийн багцаас авсан газар ашиглалт, газрын бүрхэцийн тухай мэдээлэл
  - (в) Газар дээр хийгдсэн судалгаа (газар ашиглалтын зөвшөөрөл, төлөвлөгөө, кадастр, эзэмшигчдийн бүртгэл, газар ашиглалт, менежментийн бүртгэл зэрэг орон нутгийн бүртгэлийн байгууллагаас эх сурвалжтай мэдээлэл);

Дээрх (а), (б), (в) мэдээлэл олдохгүй/хэрэглэх боломжгүй бол, ТО нь хүлээн авагч улсад ашиглагдаж буй хөдөө орон нутгийн оролцооны үнэлгээний эсвэл стандарт хөдөө орон нутгийн оролцооны үнэлгээний аргачлалын дагуу боловсруулсан баталгааг бичгээр өргөн мэдүүлнэ.

Х-1-д ороогүй тал нь өөрийн ТҮТ-оор дамжуулан ГЗ-д мэдүүлсэн тохиолдолд О/НС ЦХМ төслийг хэрэгжүүлж болно:

- ☞ Модны хамгийн бага титэм бүрхэц 10%-30% ;
- ☞ Газрын хамгийн бага хэмжээ 0.05 га–1.0 га;
- ☞ Модны хамгийн бага өндрийн хэмжээ 2–5 м [ЦХМ О/НС ДЖ, ху17 хэ7-8]

#### О/НС ЦХМ төслийн тооцоот

##### хугацаа [ТХ/2005/8/Н1, ху67 хэ23]

О/НС ЦХМ төсөл эхэлснээс хойш дараах хугацаанд үргэлжилнэ. Үүнд:

- ☞ Дахин 2 удаа сунгаж болох 20 жилийн дээд хугацаа (хамгийн ихдээ нийт 60 жил)
- ☞ 30 жилийн дээд хугацаа

☞ 2000 оны 1-р сарын 1-ээс хойш эхэлсэн О/НС ЦХМ төслийн үйл ажиллагааны хувьд төслийн анхны нотолгоо нь төсөл бүртгэгдсэн өдрөөс хойш хийгдэх нөхцөлд магадлагаа болон бүртгэлийг нь 2005 оны 12-р сарын 31-ээс хойш хийхийг зөвшөөрнө.

☞ Тооцоот хугацаа нь төслийн хэрэгжилттэй нэгэн зэрэг эхэлсэн төслүүдийн хувьд, 2000 оноос хойш хэрэгжсэн төслүүд эхний өдрөөсөө эхлэн ТЯББ/УЯББ-г хуримтлуулж болно. [ГЗ21 Тай, хэ64]

О/НС ЦХМ төслийн анхны нотолгоо болон баталгаажуулалтыг ТО-н сонгосон хугацаанд хийж болно. Үүнээс хойш, тооцоот хугацаа дуустал **5 жил тутам** нотолгоо, баталгаажуулалтыг хийж гүйцэтгэнэ. [ТХ/2005/8/Н1, ху69 хэ32]

## 18-2. О/НС ЦХМ-ын байнгын бус байдал (ТЯББ, уЯББ)

Түр ЯББ (ТЯББ) болон урт хугацааны ЯББ (уЯББ):

- ☛ ТО нь О/НС ЦХМ төслийн үйл ажиллагааны байнгын бус байдлыг зохицуулах дараах аргын нэгийг сонгоно [ТХ/2005/8/Н1, ху70 хэ38]:
  - (а) Төсөл эхэлсэн өдрөөс хойш төслийн үйл ажиллагаагаар бий болгосон ХүХ-н шингээлтийн цэвэр хэмжээнд **ТЯББ** олгох; эсвэл
  - (б) Нотолгоо хийгдэх хугацаа бүрт төслийн үйл ажиллагаагаар бий болгосон ХүХ-н шингээлтийн цэвэр хэмжээнд **уЯББ** олгох.
- ☛ Байнгын бус байдлыг зохицуулахаар сонгосон арга нь тооцоот хугацаа болон сунгагдсан тооцоот хугацаанд өөрчлөгдөхгүй хэвээр байна.


**ТЯББ болон уЯББ-н хүчинтэй хугацаа**

- ☛ **ТЯББ** нь олголт хийгдсэн үүрэгт хугацааны удаах үүрэгт хугацаа дуустал хүчин төгөлдөр байна. [ТХ/2005/8/Н1, ху71 хэ42]
- ☛ **уЯББ** нь тооцоот хугацаа дуусахад, хэрэв дахин сунгагдах тооцоот хугацааг сонгосон бол төслийн үйл ажиллагааны сүүлийн сунгагдсан хугацаа дуусах хүртэл хүчин төгөлдөр байна. [ТХ/2005/8/Н1, ху71 хэ46]

### Жишээ: О/НС төслийн үйл ажиллагааны үр дүнд бий болох ХүХ-н шингээлтийн цэвэр өөрчлөлт

Доорхи зургаар О/НС төслийн үйл ажиллагаагаар бий болсон ХүХ-н шингээлтийн өөрчлөлтийг харуулав. Доорхи зураг дахь өгөгдөлд үндэслэн **ТЯББ** болон **уЯББ**-г хэрхэн олгох, тэдгээрийн хүчинтэй хугацаа зэргийг дараагийн 2 хуудсанд тайлбарласан болно.


- ☛ Модыг 2007 онд суулгасан.
- ☛ **ТЯББ** эсвэл **уЯББ**-н эхний олголтыг 2011 онд хийнэ. 1 болон 2-р үүрэгт хугацаанд мод ургаж байх бөгөөд хоёр дахь удаагийн **ТЯББ** эсвэл **уЯББ**-г 2016 онд олгоно.
- ☛ Үүрэгт хугацаа (ҮХ) бүр 5 жил үргэлжилнэ хэмээн үзэв.
- ☛ 2-р үүрэгт хугацаа (ҮХ) дуусах үеэр буюу 2017 онд модыг огтлох болон 3 дахь удаагийн олголтыг 2021 онд хийнэ. Сүүлийн олголтыг 2036 онд хийнэ.
- ☛ Олгогдсон **ТЯББ** эсвэл **уЯББ**-г тухайн Талын ялгаралтыг бууруулах тоон үүргийг биелүүлэхэд ашиглана.
- ☛ Тооцоот хугацаа нь дахин сунгагдахгүй 30 жил байна.






18-2. О/НС ЦХМ-ын байнгын бус байдал (ТЯББ, уЯББ)

Жишээ: ТЯББ-г олгож, улмаар нөхөн солих нь



18-2. О/НС ЦХМ-ын байнгын бус байдал (ТЯББ, уЯББ)



## 18-3. О/НС ЦХМ-ын жижиг төсөл

## О/НС ЦХМ-ын жижиг төслийн үйл ажиллагааны тодорхойлолт

- ◆ Жилд 16,000т-аас бага CO<sub>2</sub>-г шингээх тооцоо бүхий төслийн үйл ажиллагааг хэлнэ; [ГЗ 37 Тай, Хэ 55]
  - ☞ Тухайн нотолгоо хийгдэх үеийн жилд ногдох ХүХ-н шингээлтийн цэвэр хэмжээ нь 16,000т CO<sub>2</sub>-оос хэтрэхгүй байна. [ТХ/2004/10/Н2, ху26 хэ1(6)]
- ◆ Хүлээн авагч Талын тодорхойлсноор бага орлоготой суурин газар, хувь хүмүүс боловсруулсан эсвэл хэрэгжүүлсэн байна. [ТХ/2005/8/Н1, ху62 хэ1(i)]
  - ☞ ТМБ нь ГЗ-д магадлагааны тайлан өргөн мэдүүлэхээсээ өмнө энэ тухай ТО-оос албан мэдэгдэл хүлээн авсан байна. [ТХ/2005/8/Н1, ху85 хэ15(6)]

Хэрэв О/НС ЦХМ-ын жижиг төслийн үйл ажиллагааны жилийн ХүХ-ын шингээлтийн цэвэр хэмжээ 8,000 тонн-CO<sub>2</sub> –оос хэтэрвэл, илүүдэл хэмжээнд нь **ТЯББ** болон **УЯББ**-г олгохгүй. [ТХ/2005/8/Н1, ху62 хэ1(i)]

О/НС ЦХМ-ын жижиг төслийн багцлалыг магадлагаа хийх зорилгоор хийсэн тохиолдолд “Багцлалтын ерөнхий зарчим” [ГЗ21, Х21] болон түүнд хийсэн өөрчлөлтүүд хамаарахгүй байх талтай. [ГЗ32 Тай, хэ42]

## О/НС ЦХМ-ын жижиг төслийн үйл ажиллагааны хялбарчилсан дэг, журам

- ◆ Холбогдох зардлыг бууруулах зорилгоор О/НС ЦХМ-ын жижиг төслийн үйл ажиллагааны дэг, журмыг дараах байдлаар хялбарчилсан болно. Үүнд: [ТХ/2005/8/Н1, ху82 хэ1]
  - ☞ Төслийн баримт бичигт тавигдах нөхцөл шаардлагыг цөөлсөн;
  - ☞ Төслийн суурь өгөгдөл боловсруулах өртгийг бууруулахын тулд суурь төслийн төрөл бүрээр суурь өгөгдлийн аргачлалыг хялбарчилсан;
  - ☞ Хяналт шинжилгээний өртгийг бууруулахын тулд хяналт шинжилгээний төлөвлөгөө болон гүйцэтгэлд тавигдах нөхцөл шаардлагыг хялбарчилсан;
  - ☞ Магадлагаа, нотолгоо болон баталгаажуулалтыг нэг магадлах байгууллага хийхийг зөвшөөрсөн.
- ◆ О/НС ЦХМ-ын жижиг төслийн үйл ажиллагаа нь:
  - ☞ Уур амьсгалын өөрчлөлтийн таагүй нөлөөнд онцгой өртөмтгий хөгжиж буй Талуудад тусламж болгох орлогын шимтгэлээс чөлөөлөгдөнө;
  - ☞ Эргэн буцаагдахгүй бүртгэлийн хураамж болон захиргааны зардлыг нөхөх орлогын шимтгэлийн хувьд хөнгөлөлт эдэлнэ. [ТХ/2005/8/Н1, ху83 хэ13]

- ◆ ГЗ нь О/НС ЦХМ-ын жижиг төслийн үйл ажиллагаанд хялбарчилсан суурь өгөгдлийн аргачлал боловсруулсныг ОНС-БАЖ0001 Хувилбар 04-т нийтэлсэн болно. [ГЗ28 Х18]
- ◆ Мөн түүнчлэн, “О/НС жижиг төслийн хялбарчилсан баримт бичгийг боловсруулах заавар (ЦХМ-ЦЖТОНС-ТББ) болон О/НС ЦХМ-ын жижиг төслийн үйл ажиллагааны аргачлалыг өргөн мэдүүлэх маягт (М-ЦХМ-ЦЖТ-ОНС-Мэд) Хувилбар 03” [ГЗ26 Х21] гэж бий.

## 19. ЦХМ Хөтөлбөрт үйл ажиллагаа

[Г332 Х38]]

### Хөтөлбөрт үйл ажиллагаа (ХҮа) болон ЦХМ хөтөлбөрт үйл ажиллагаа (ЦХҮа)

Хөтөлбөрт үйл ажиллагаа (ХҮа) гэдэг нь:

- ☞ хувийн эсвэл нийтийн өмчит байгууллагууд
- ☞ сайн дурын үндсэн дээр нь хамтарсан байдлаар
- ☞ тоон хязгаарлалтгүй ЦХМ-ийн хөтөлбөрт үйл ажиллагааг (ЦХҮа) хэрэгжүүлэх замаар
- ☞ тодорхой бодлого, арга хэмжээ эсвэл тогтоосон зорилтыг мөрдөн, баримталсны үндсэн дээр
  - ⇒ ө.х. урамшуулалын схем болон сайн дурын хөтөлбөрүүд
- ☞ ХүХ-ийн ялгарлыг бууруулах, түүнчлэн ХүХ –ийн шингээлтийг нэмэгдүүлэх зорилт тавин ажиллаж буйг хэлнэ.

◆Хөтөлбөрт үйл ажиллагааны (ХҮа) хүрээнд хэрэгжиж буй ЦХМ хөтөлбөрт үйл ажиллагаа (ЦХҮа) –г нэг ЦХМ төсөл гэж бүртгэн авч болно.

ЦХМ хөтөлбөрт үйл ажиллагаа (ЦХҮа) гэдэг нь :

- ☞ Хөтөлбөрт үйл ажиллагааны хүрээнд хэрэгжиж буй төслийн үйл ажиллагаа,
- ☞ нэг эсвэл хоорондоо хамааралтай арга хэмжээний багц,
- ☞ суурь аргачлалд заасны дагуу тогтоогдсон хүрээний дотор ХүХ-ийн ялгарлыг бууруулах эсвэл цэвэр шингээлтийг өөрчлөхөд чиглэсэн.
  - ⇒ БАр нь ЦХҮа нь дан ганц эсвэл олон тооны байгууламж/суурилуулалт/газарт явагдсан эсэхийг тогтоох ёстой.
  - ⇒ Дангаараа ЦЖТ-ийн доод хэмжээнээс давж гарахгүй үзүүлэлттэй ЦХҮа-ийн хувьд ЦЖТ-ийн аргачлал ашиглаж болно.

### Зохицуулах болон гүйцэтгэгч байгууллага [Г3 32 Х38 хэсэг 4-5]

- ☞ ХҮа-г санаачлагч нь тухайн хөтөлбөрт хамрагдагч орнуудын ТҮТ-оос эрх олгогдсон, харилцааны дэг журмын дагуу ГЗ-тэй харилцах болон ЯББ-ыг хуваарилах байгууллагаар нэрлэгдсэн, нийтийн өмчит эсвэл хувийн хэвшлийн ТО байгууллага байна (Бүлэг 4-7).
- ☞ ХҮа-ны ТО нь харилцаа холбоо, ЯББ-ыг хуваарилах болон ТО өөрчлөгдөхтэй холбоотой асуудлыг шийдвэрлэх талаар зохицуулах болон гүйцэтгэгч байгууллагатай тохирно.

### Хил хязгаар [Г332 Х38 хэсэг2]

- ☞ ХҮа эрэгжих газарзүйн хил хязгаар нь нэгээс олон улс орныг хамарч болохын зэрэгцээ, Х.1-д ороогүй оролцогч Тал бүр ЦХҮа нь тухайн орны тогтвортой хөгжилд нэмэр оруулж буйг баталсан байна.

### Орон нутаг/бүс нутаг/үндэсний бодлого болон хууль дүрмийг харгалзах нь [Г3 32 Х38 хэсэг 3]

- ☞ ХҮа нь орон нутаг/бүс нутаг/үндэсний бодлого болон хууль дүрмийг харгалзах тухай ГЗ-өөс гаргасан заавар зөвлөмжийг даган мөрдөнө.
- ☞ Зайлшгүй даган мөрдөх ийм хууль тогтоомжийн биелэлт хангалтгүй байвал ХҮа нь үүнийг шийдвэрлэхэд чиглэж болно. Харин биелэлт нь байнга хянагддаг бол байвал зохих түвшинээс илүү үр дүнд хүрэхэд ХҮа-н үйл ажиллагаа чиглэгдэх ёстой.

### Давхар бүртгэл [Г3 32 Х38 хэсэг6]

- ☞ ХҮа-д хамаарах ЦХҮа нь бие даасан ЦХМ төслийн үйл ажиллагаа, эсвэл өөр ХҮа-д давхар бүртгэгдэхээс сэргийлэх арга хэмжээг зохицуулагч байгуулагч хариуцна. Эдгээр арга хэмжээг ТМБ-аас магадлагаа хийж, нотолгоо гаргана.

### ХҮа ны бүртгэлийн хураамж [Г333 Тай, хэ60]

- ☞ ХҮа-ны бүртгэлийн хураамж нь тухайн ЦХҮа-ны жил бүр бууруулах нийт ялгаралтын хэмжээнд үндэслэх бөгөөд ХҮа-г бүртгүүлэх хүсэлттэй хамт төлөгдөнө. Төлөх хураамжийн хэмжээг тооцоолох, төлөх журмыг тухайн мөрдөгдөж буй дүрэм, орсон өөрчлөлтүүдийн дагуу хийнэ. (Бүлэг 11-3)
- ☞ Дараалан хамрагдах ЦХҮа- бүрт хураамж төлөхгүй.
- ☞ Хураамжийг зохицуулагч/удирдагч байгууллагаас НБДН газарт төлнө.

**Суурь өгөгдөл, нэмэгдэл чанар** [ГЗ 32 Хнх38 para7-8, 12]

- ☞ **ХҮа** хамрагдах бүх **ЦХҮа** нэг БАр ашиглана.
- ☞ **ХҮа** нь түүнд хамрах **ЦХҮа** тус бүрийн бий болгосон ХүХ-н ялгаралтын бууралт болон шингээлт нь бодит, хэмжигдэхүйц болон төслийн хил хязгаарт болсон үйл ажиллагааны үр дүн бөгөөд **ХҮа**-д хувь нэмэр оруулахуйц гэдгийг батлан харуулах ёстой. **ХҮа**-д хамрагдсан **ЦХҮа** бүрийн алдагдал, нэмэгдэл чанар, суурь өгөгдөл, суурь ялгаралт, тохирох байдал, давхар бүртгэлтэй холбоотой асуудлууд хэрхэн шийдэгдснийг магадлах үүднээс **ЦХҮа** бүрийг бүртгэлийн шатанд ямар мэдээллээр хангахыг **ХҮа** шийднэ.

- ☞ Нэгтгэлд оруулахаас бусад зорилггор БАр-ыг түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон тохолдолд журамд дурдагдсан төлөвлөгөөт хугацааны дагуу ямар ч шинэ **ЦХҮа**-г **ХҮа**-д оруулахгүй.
- ☞ Аргачлалыг удаа дараа хянан засварлаж эсвэл нэгдсэн аргачлалд хамруулсан тохиолдолд **ХҮа**-ыг мөн хянан засварлах шаардлагатай ба хийгдэх ёстой аливаа өөрчлөлтийн ТМБ магадлан, ГЗ-өөр батлуулна. Тухайн өөрчлөлтүүдийг ГЗ-өөр баталсан тохиолдолд, **ХҮа**-д хамрагдсан **ЦХҮа** бүр **ХҮа**-ны шинэ хувилбарыг ашиглах ёстой.
- ☞ Аргачлалыг түтгэлзүүлэхээс өмнө хамрагдсан **ЦХҮа** тооцоот хугацаа шинэчлэгдэх өдрөөс эхлэн **ХҮа**-ны шинэ хувилбарыг үйл ажиллагаандаа мөрдөж эхлэх ёстой.

**Хяналт шинжилгээ** [ГЗ 32 Х 38 хэсэг13]

- ☞ **ЦХҮа** тус бүрийн ялгаралтын бууралтыг тухайн бүртгэгдсэн **ХҮа**-д ашигласан хяналт шинжилгээний бүртгэгдсэн төлөвлөгөөний дагуу хянан. Ялгаралтын бууралтыг нотлох аргачлал буюу арга (үүнд, түүвэр судалгаа орж болно) нь эдгээр бууралт, шингээлт үнэн зөв болохыг батлах ёстой.

**Үргэлжлэх болон тооцоот хугацаа** [ГЗ 32 Х38 хэсэг 9-11]

- ☞ **ЦХҮа** бүрийн тооцоот хугацааны эхлэх, дуусах өдөр болон бусад онцлог байдлыг тухайн үйл ажиллагаа бүртгэгдсэн **ХҮа**-д хамрагдах шатанд тодорхойлж, батална.
- ☞ **ЦХҮа**-ны тооцоот хугацаа дээд тал нь сунгагдах нөхцөлтэй 7 жил (О/НС төслийн хувьд 20 жил) хүртэл, эсвэл дахин сунгагдах нөхцөлгүй 10 жил (О/НС төслийн хувьд 30 жил) хүртэл байж болно.
- ☞ Зохицуулагч байгууллага **ХҮа**-д бүртгүүлэх хүсэлтээ мэдүүлэх үедээ **ЦХҮа**-ны үргэлжлэх хугацааг тогтоох ба энэ нь 28 жил (О/НС төслийн хувьд 60 жил)-ээс хэтрэхгүй байна.
- ☞ Зохицуулагч/хэрэгжүүлэгч байгууллага нь **ХҮа** үргэлжлэх хугацаанд аливаа **ЦХҮа**-г **ХҮа**-д хэдийд ч нэмж хамруулж болно.
  - ☞ Эдгээр байгууллага шинээр **ЦХҮа** хамруулснаа зохих маягыг ашиглан ТМБ-аар дамжуулан ГЗ-д мэдээлнэ.
- ☞ Аливаа **ЦХҮа**-ны тооцоот хугацаа хэзээ **ХҮа**-д хамрагдсанаасаа үл шалтгаалан **ХҮа** дуусгавар болох өдрөөр хязгаарлагдана.
- ☞ “Бүртгэгдсэн ЦХМ төслийн тооцоот хугацааг сунгах журам (бүлэг 16)”-ийн хамгийн сүүлийн хувилбарыг **ХҮа** (О/НС төслийн хувьд 20) 7 жил тутам зохих журмын дагуу мөрдөнө. **ХҮа**-д өөрчлөлт орсон тохиолдолд **ЦХҮа** уг өөрчлөлт батлагдсанаас хойш өөрийн тооцоот хугацааг эхний удаа сунгахдээ тусгана.
  - ⇒ Олон хүлээн авагч Талууд хамрагдаж буй тохиолдолд, эдгээр өөрчлөлтийг тусгаж чадах **ЦХҮа**-ууд зөвхөн тооцоот хугацаагаа шинэчилж болно.

**Нэмэлт: Хөтөлбөрт Үйл ажиллагааны бүрэлдэхүүн хэсэг (**ХҮа**)** [ГЗ 36 Х27, хэсэг 7-8]

- ◆ **ХҮа**-г бүртгүүлэхийн тулд **ХҮа**-нд хамрагдах санал болгож жижиг **ЦХҮа** -г дараахь нөхцлүүдэд томоохон хэмжээний үйл ажиллагааны бүрэлдэхүүн хэсэгт тооцно. Үүнд:
  - ☞ Санал болгож буй **ЦХҮа**-тай ижил төстэй үйл ажиллагаа хэрэгжүүлдэг нэгжтэй эсвэл ижил салбарын хүрээнд томоохон хэмжээний **ХҮа** хэрэгжүүлж буй зохицуулагч/гүйцэтгэгч байгууллагатай бол;
  - ☞ Хил хязгаарын хамгийн ойр цэг нь санал болгож буй жижиг **ЦХҮа**-ын хил хязгаарын 1 км дотор байршилтэй бол.
- ◆ Санал болгож буй жижиг хэмжээний **ЦХҮа** нь **ХҮа**-ны бүрэлдэхүүн хэсэгт тооцогдох ёстой хэдий ч тухайн **ХҮа** нь бүртгэгдсэн жижиг хэмжээний **ЦХҮа**-той нийлээд жижиг төслийн шалгуур хэмжээнээс хэтрэхгүй тохиолдолд уг **ЦХҮа**-г ЦХМ-ын жижиг төсөл болон О/НС жижиг төсөлд зориулагдсан хялбарчилсан дэг, журмуудыг мөрдөж болно.

## 20. Регистр болон Олон улсын гүйлгээний бүртгэл (ОУГБ)

### 20-1. ЦХМ-ын регистр

◆ ГЗ нь ЯББ-ын олголт, эзэмшилт, шилжүүлэг болон Х.1-д ороогүй Талуудын ЯББ хүлээн/худалдан авах үйл ажиллагаанд зөв зохистой бүртгэл тооцоо хийх зорилгоор ЦХМ-ын регистрыг байгуулж, хөтөлнө. [ТХ/2005/8/Н1, ху27 хэ1-2]

- ☞ ГЗ нь түүний удирдлага доор регистрыг хөтлөх регистр эрхлэгчийг томилно.
- ☞ ЦХМ-ын регистр нь стандартчилсан цахим мэдээллийн сан байх агаад үндэсний региструуд, ЦХМ-ын регистр болон олон улсын гүйлгээний бүртгэлийн хооронд мэдээллийн үнэн зөв, ил тод, үр өгөөжтэй солилцоо явагдах нөхцлийг бүрдүүлнэ.
- ☞ ЦХМ-ын регистрт дараах данс байна. Үүнд:

(1) ГЗ-ийн нэгдсэн дамжих данс  
Олгогдсон ЯББ-г өөр данс руу шилжүүлэхийн өмнө тус дансанд байрлуулна.  
[ТХ/2005/8/Н1, ху27 хэ3(а)]

(2) Х.1-д ороогүй Талуудын данс  
Энэ нь ЦХМ төслийн үйл ажиллагааг хүлээн авагч, эсвэл данс нээх хүсэлт гаргасан Тал байна.  
[ТХ/2005/8/Н1, ху27 хэ3(б)]

(3) Х.1-д орсон Талууд, тэдгээрийн ТО-ын түр данс  
Эдгээр Тал болон ТО-ын үндэсний регистр ажиллагаанд орох хүртэл ЯББ хүлээн авч байршуулахад ашиглана.  
[ТБХ/2004/2, ху15 хэ57]

(4) Илүүдэл ЯББ-ын цуцлалтын данс  
ГЗ-ийн тодорхойлсноор илүү олгогдсон КП –ын нэгжийг цуцлахад ашиглана. [ТХ/2005/8/Н1, ху27 хэ3(в)]

(5) тЯББ болон уЯББ-ын цуцлалтын данс  
ЦХМ-ын регистрын дамжих дансанд байхдаа хүчинтэй хугацаа нь дуусгавар болсон тЯББ, уЯББ болон шалгуурт тэнцэхгүй болсон уЯББ-г цуцлахад ашиглана.  
[ТХ/2005/8/Н1, ху80 хэ3]

(6) Орлогын шимтгэлийн данс  
ОГШ-Зохиц-ны дагуу ЯББ-г байршуулах, шилжүүлэхэд ашиглана. [ТХ/2005/8/Н1, ху27 хэ3(г)]

◆ (2)(3)(4)(6)-д заасан дээрх данс дотроо хэд хэдэн данс нээж болно.

- ☞ Данс тус бүрийн дугаар нь тухайн Тал/байгууллагын хувийн дугаар болон тухайн дансны онцгой дугаараас бүрдэнэ. [ТХ/2005/8/Н1, ху27 хэ5]

◆ Цуцлалтын данс руу шилжүүлсэн КП-ын нэгжийг өөр данс руу шилжүүлэхгүй бөгөөд тухайн Талын тоон үүргийн биелэлтэнд ашиглахгүй.

◆ ЯББ тус бүр өөрийн хувийн дугаартай байх бөгөөд тухайн хугацаанд зөвхөн аль нэг регистрийн тодорхой нэг дансанд байршина. [ТХ/2005/8/Н1, ху27 хэ4]

**ЦХМ-ын регистрээр дамжуулан олон нийтэд нээлттэй байх мэдээлэл**

ЦХМ-ын регистр нь нууц бус дараах мэдээллийг интернет сүлжээгээр олон нийтэд нээлттэй болгоно. Үүнд:

[ТХ/2005/8/Н1, ху28 хэ9-12]

◆ Дансны тус бүрийн нэр, төлөөлөх дугаар болон Тал/байгууллагын хувийн дугаар зэргийн шинэчлэгдсэн мэдээлэл.

◆ ЦХМ төслийн үйл ажиллагааны нэр, ЯББ олгогдсон жил, оролцогч магадлах байгууллагууд, олон нийтэд нээлттэй тараагдах мэдээлэл зэрэг.

◆ ЦХМ-ын регистртэй холбогдох байршуулалт болон шилжүүлгийн жил бүрийн мэдээлэл, цуврал дугаараар нь.

**Сарын тайлан** [Г321 Тай, хэ70]

ЦХМ-ын регистрээс оролцогч Талуудын холбогдох ТҮТ-д сар бүр тайлан гаргаж хүргүүлнэ.

## 20-2. Үндэсний регистр

◆ Х.1-д орсон Тал тус бүр ЯБН, ЯББ, ТХН болон ШГН-г олгох, эзэмших, шилжүүлэх, хүлээн авах, цуцлах, дуусгах болон ЯБН, ЯББ болон ТХН-г үе дамжуулах шилжүүлэх зэрэг гүйлгээнд үнэн зөв бүртгэл тооцоо хийх зорилгоор үндэсний регистр байгуулж, хөтөлнө. [ТХ/2005/8/Н2, ху28 хэ17]

☞ Тал тус бүр түүний үндэсний регистрийг хөтлөх байгууллагыг регистр эрхлэгчээр томилно. [ТХ/2005/8/Н2, ху28 хэ18]

⇒ 2 буюу түүнээс олон Тал нь тус бүрийн үндэсний регистр салангид байх нөхцөлтэйгээр, үндэсний регистрээ нэгдсэн нэг регистрт сайн дурын үндсэн дээр хамтран хөтөлж болно.

☞ Үндэсний регистр нь мэдээллийн стандартчилсан цахим сан байна. Үндэсний регистр, ЦХМ-ын регистр болон олон улсын гүйлгээний бүртгэлийн хооронд мэдээллийн үнэн зөв, ил тод, үр өгөөжтэй солилцоо явагдах нөхцлийг бүрдүүлнэ. [ТХ/2005/8/Н2, ху28 хэ19]

◆ Үндэсний регистр нь КП-ын нэгжүүд (ТХН, ЯБН, ЯББ, тЯББ, уЯББ болон ШГН)-ийг бүртгэх дараах данстай байна: [ТХ/2005/8/Н2, ху28 хэ21]]

(1) Тухайн Талын эзэмшлийн данс

(3) ГАГАӨО үйл ажиллагааны цуцлалтын данс

Ийм үйл ажиллагаа нь ХүХ-н цэвэр ялгаралтыг бий болгосон тохиолдолд КП-ын нэгжийг цуцлахад ашиглана.

(6) тЯББ нөхөн солих данс

Хүчинтэй хугацаа нь дуусахаас өмнө тЯББ-г нөхөн солих зорилгоор ТХН, ЯББ, ЯБН, ШГН буюу/эсвэл тЯББ-г цуцлахад ашиглана. [ТХ/2005/8/Н1, ху71 хэ43]

(2) Тухайн Талын эрх олгогдсон хуулийн этгээдийн эзэмшлийн данс  
Хариуцаж буй КП-ын нэгжийг байршуулахад ашиглана.

(4) Үл гүйцэтгэлийн цуцлалтын данс

Тухайн Талын 1-р үүрэгт хугацааны илүүдэл ялгарлыг 1.3-аар үржүүлсэн хэмжээний КП-ын нэгжийг цуцлахад ашиглана

(7) уЯББ нөхөн солих данс

уЯББ-г нөхөн солих зорилгоор ТХН, ЯББ, уЯББ, ЯБН ба/эсвэл ШГН-г цуцлахад ашиглана. [ТХ/2005/8/Н1, ху71 хэ47]

(5) Талуудын бусад цуцлалтын данс

(3) болон (4)-раас бусад тохиолдолд КП-ын нэгж цуцлахад ашиглана.

(8) Дуусгалтын данс

Тухайн үүрэгт хугацаанд хүчинтэй КП –ын нэгжийг тухайн Талын тоон үүргийн гүйцэтгэлд тооцохоор дуусгахад ашиглана. [ТХ/2005/8/Ad2, p27 para14]

☞ (1) (2)(3)(5)-д заасан данс дотроо хэд хэдэн данс нээж болно.

☞ (3) (4) (5) (6) (7) (8)-д заасан данс нь үүрэгт хугацаа тус бүрд зориулан нээгдсэн байна.

☞ Дансны дугаар нь Талын хувийн дугаар болон онцгой дугаараас бүрдэнэ. [ТХ/2005/8/Н2, ху28 хэ22]

◆ Цуцлалтын дансанд орсон КП-ын нэгжийг өөр данс болон дараагийн үүрэгт хугацаа руу шилжүүлэхгүйн зэрэгцээ тухайн Талын тоон үүргийн биелэлтэнд мөн тооцохгүй. [ТХ/2005/8/Н2, ху30 хэ35]

◆ Дуусгалтын данс руу орсон КП-ын нэгжийг өөр данс болон дараагийн үүрэгт хугацаа руу шилжүүлэхгүй. [ТХ/2005/8/Н2, ху30 хэ35]

КП-ын нэгжийн цуврал дугаар \*Жишээг дор харуулав.

- ◆ 1 тонн CO<sub>2</sub>-той тэнцэх КП-ын нэгж бүрт цуврал дугаар онооно.
- ◆ КП-ын нэгж нь тухайн хугацаанд тодорхой нэг регистрийн тодорхой нэг дансанд хадгалагдана. [ТХ/2005/8/Н2, ху28 хэ20]

**Цуврал дугаарын тэмдэглэгээ**

1	2	3	4	5	6	7	8	9	10	11
XX	1		000,000,000,000,001	999,999,999,999,999	01	01	1	0000001	1	XX/YY/ZZ

	Тэмдэглэгээ	Эгнээ буюу код
1	Эх сурвалж регистр	2005 оны 1-р сарын 1-ний байдлаарх ISO3166-н улсын 2 оронтой код
2	Нэгжийн төрөл	1 = ТХН, 2 = ШГН, 3 = ТХН-ээс хөрвүүлсэн ЯБН, 4 = ШГН-ээс хөрвүүлсэн ЯБН, 5 = ЯББ, 6 = ТЯББ, 7 = уЯББ
3	Туслах нэгжийн төрөл	Зөвхөн -Киотогийн нэгжийн хувьд хоосон байна, эсвэл ТГБ (Туслах гүйлгээний бүртгэл)-д тодорхойлсноор
4	Нэгжийн цуврал бүлгийн эхлэл	Регистрээс оноосон онцгой дугаар 1 - 999,999,999,999,999 хүртэл
5	Нэгжийн цуврал бүлгийн төгсгөл	Регистрээс оноосон онцгой дугаар 1 - 999,999,999,999,999 хүртэл
6	Анхны үүрэгт хугацаа	1 - 99
7	Тухайн үүрэгт хугацаа	1 - 99
8	ГАГАӨО үйл ажиллагаа	1 = Ойжуулалт, ой нөхөн сэргээх, 2 = Ой модны сүйрэл, 3 = Ойн аж ахуйн менежмент, 4 = Газар тариалангийн менежмент, 5 = Бэлчээрийн менежмент, 6 = Ногоон бүсийг сэргээх
9	Төслийн таних дугаар	Регистрээс Төсөлд оноосон онцгой дугаар
10	Дэд бүлэг	1 эсвэл 2
11	Хүчинтэй байх хугацаа	ТЯББ болон уЯББ-н хүчинтэй байх сүүлийн огноо

[Киотогийн Протоколд хамаарах регистрийн системийн мэдээлэл солилцооны стандарт, техникийн урьдчилсан үзүүлэлт, Хэвлэмэл бус Хавсралтууд, 2004 оны 11-р сарын 3, ху М-2]

Үндэсний регистрээс олон нийтэд нээлттэй болгох мэдээлэл

Үндэсний регистр нь нууц бус мэдээллийг олон нийтэд интернет сүлжээгээр нээлттэй болгоно.

[ТХ/2005/8/Н2, ху32 хэ44-48]

☞ Энэ нь хуулийн этгээдийн эзэмших буй дансны талаарх мэдээлэлд мөн адил хамаарна.

◆ Дансны талаарх мэдээлэл

☞ Данс эзэмшигч, түүний төлөөлөгчийн нэр болон данс эзэмшигчтэй холбоо барих хаяг гэх мэт.

◆ КП-ын нэгжийн нийлбэр дүнгийн мэдээлэл

◆ Данс тус бүрт байршуулсан КП-ын нэгжийн дүн

◆ ХаХ төслийн тараарх мэдээлэл

☞ Төслийн нэр, байршил, ЯБН олгосон жил, олон нийтэд нээлттэй бусад мэдээлэл.

◆ Тухайн Талаас Киотогийн механизмд оролцох эрх олгосон хуулийн этгээдийн жагсаалт.



## 20-3. Олон улсын гүйлгээний бүртгэл (ОУГБ)

- ◆ НҮБУӨСК-ийн НБДН газар нь КП-ын нэгжийг олгох, регистр хооронд шилжүүлэх болон хүлээн авах, цуцлах, хүчинтэй хугацааг дуусгавар болгох, нөхөн солих (ТЯББ болон УЯББ-ын хувьд), дуусгах, үе дамжуулах зэрэг гүйлгээний хүчин төгөлдөр байдлыг баталгаажуулах зорилгоор олон улсын гүйлгээний бүртгэлийг (ОУГБ) байгуулж, хөтөлнө. [ТХ/2005/8/Н2, ху31 хэ38] [ТХ/2005/8/Н1, ху73 хэ55-56]
- ☞ ОУГБ нь мэдээллийн стандартчилсан цахим сан байх байна. Үндэсний регистр, ЦХМ-ын регистр болон ОУГБ-ын хооронд мэдээллийн үнэн зөв, ил тод, үр өгөөжтэй солилцоо явагдах нөхцлийг бүрдүүлсэн байна.
- ◆ ОУГБ нь дараах зүйлсийг автоматаар шалгана. Үүнд: [ТХ/2005/8/Н2, ху31 хэ42]

**(1) Бүх гүйлгээ (олгох, регистрийн хооронд шилжүүлэх болон хүлээн авах, цуцлах, дуусгах болон үе дамжуулах):**

- ☞ Өмнө эцэслэгдсэн эсвэл цуцлагдсан нэгж; нэгээс олон регистрд орсон нэгж; урьд өмнө тогтоогдсон зөрчил нь засагдаагүй байгаа нэгж;
- ☞ Зохисгүйгээр үе дамжуулсан нэгж; буруу олгогдсон нэгж;
- ☞ Гүйлгээнд оролцогч хуулийн этгээдүүдэд эрх олгогдсон байдал.

**(2) Регистр хоорондын шилжүүлэг**

- ☞ Гүйлгээ хийх Талуудын хувьд КМ-д оролцох нөхцөл хангасан эсэх;
- ☞ Шилжүүлэгч Тал үүрэгт хугацааны нөөц ашиглалтын зөрчилтэй эсэх.

**(3) О/НС ЦХМ төслөөс ЯББ авах**

- ☞ Хязгаарлалтыг зөрчсөн эсэх (авч болох ТЯББ болон УЯББ-н хэмжээнд тавигдах хязгаар).

**(4) ЯББ-г дуусгах**

- ☞ Тал нь үүрэгт хугацааны гүйцэтгэлдээ ЯББ-г ашиглах эрхтэй эсэх.

- ◆ Гүйлгээг эцэслэхийн өмнө, санаачлагч регистр нь санал болгох гүйлгээний мэдээллийг ОУГБ болон, хэрэв өөр регистр рүү шилжүүлэх бол, хүлээн авагч үндэсний регистрд хүргүүлнэ. [ТХ/2005/8/Н2, ху31 хэ41]
- ◆ ОУГБ нь бүх гүйлгээний мэдээлэл, огноо болон гүйцэтгэгдсэн хугацааг тэмдэглэж, олон нийтэд нээлттэй болгоно. [ТХ/2005/8/Н2, ху32 хэ43(г)]
- ◆ ОУГБ нь ТЯББ болон УЯББ тус бүрийн хүчинтэй хугацаа дуусахаас 1 сарын өмнө тэдгээрийг нөхөн солих тухай мэдээлэл Х.1-д орсон Талуудад өгнө. [ТХ/2005/8/Н1, ху73 хэ55]
- ☞ Хэрэв Х.1-д орсон Тал нь тогтоогдсон журмын дагуу ТЯББ болон УЯББ-г нөхөн солиогүй бол, ОУГБ нь ийнхүү үл нөхөн солисон тухай мэдээллийг НБДН газарт мөн тухайн Талд КП-ын 8-р зүйлийн дагуу хянан шалгалт хийхэд нэмэлт мэдээлэл болгон ГЗ болон тухайн Талд хүргүүлнэ. [ТХ/2005/8/Н1, ху73 хэ56]

**НЭМЭЛТ: ОУГБ-ын системийн автомат шалгалтаар зөрчил илэрсэн тохиолдолд:**

- ◆ Санаачлагч регистр нь гүйлгээг зогсоож, ОУГБ болон, хэрэв өөр регистрт шилжүүлэх гүйлгээ байсан бол хүлээн авагч регистрд энэ тухай мэдэгдэнэ. ОУГБ нь холбогдох Тал болон Талуудыг 8-р зүйлийн дагуу дахин нягтлах ажилд зориулан НБДН газарт тухайн зөрчлийн талаарх мэдээллийг хүргүүлнэ. [ТХ/2005/8/Н2, ху32 хэ43(а)]
- ◆ Хэрэв санаачлагч регистр нь гүйлгээг зогсоогоогүй бол, энэхүү зөрчил засагдаж, асуудал шийдэгдтэл тухайн гүйлгээнд хамрагдсан КП-ын нэгжийг тоон үүргийн гүйцэтгэлд ашиглахыг хориглоно.
  - ☞ Тухайн Тал илэрсэн зөрчлийг засахад шаардагдах аливаа арга хэмжээг 30 хоногийн дотор авч, хэрэгжүүлнэ. [ТХ/2005/8/Н2, ху32 хэ43(б)]

# Хавсралт 1. ЦХМ-ын баримт бичгүүд

## 1-1. Төслийн баримт бичиг (ЦХМ-ТББ)

- ◆ Шинэ хувилбар ГЗ-өөр батлагдмагц мөрдөгдөж эхэлнэ.
- ◆ ЦХМ-ТББ-ийн шинэ хувилбарт орсон өөрчлөлтүүд дараах төслүүдэд хамаарахгүй. Үүнд:
  - ☞ ЦХМ-ТББ-ийн шинэ хувилбар батлагдахын өмнө магадлагдсан, эсвэл магадлуулахаар МБ-д өргөн мэдүүлсэн;
  - ☞ ЦХМ-ТББ-ийн шинэ хувилбарыг баталснаас хойш 1 сарын дотор МБ-д өргөн мэдүүлсэн;
- ◆ ЦХМ-ТББ-ийн шинэ хувилбарыг баталснаас хойш **6 сар өнгөрсөн** бол өмнөх хувилбарын дагуу боловсруулсан баримтыг ГЗ хүлээн авахгүй. [ТББ Е3 хув6.2, ху4 хэ9-10]

(Хувилбар 03 – 2006 оны 7-р сарын 28-д хүчин төгөлдөр болсон) [Г325 Х15]

А БҮЛЭГ. Төслийн үйл ажиллагааны ерөнхий танилцуулга					
А.1. Төслийн үйл ажиллагааны нэр					
А.2. Төслийн үйл ажиллагааны танилцуулга					
А.3. Төслийн оролцогчид					
А.4. Төслийн үйл ажиллагааны техникийн танилцуулга					
А.4.1. Төслийн үйл ажиллагааны байршил					
<table border="1"> <tr> <td>А.4.1.1. Хүлээн авагч Тал(ууд)</td> </tr> <tr> <td>А.4.1.2. Бүс нутаг/Аймаг/Сум гэх мэт</td> </tr> <tr> <td>А.4.1.3. Хот/Суурин газар/Тосгон гэх мэт</td> </tr> <tr> <td>А.4.1.4. Газар зүйн байршлын дэлгэрэнгүй тайлбар, үүнд төслийн үйл ажиллагаанд онцгой дугаар онооход шаардлагатай мэдээлэл орно:</td> </tr> </table>		А.4.1.1. Хүлээн авагч Тал(ууд)	А.4.1.2. Бүс нутаг/Аймаг/Сум гэх мэт	А.4.1.3. Хот/Суурин газар/Тосгон гэх мэт	А.4.1.4. Газар зүйн байршлын дэлгэрэнгүй тайлбар, үүнд төслийн үйл ажиллагаанд онцгой дугаар онооход шаардлагатай мэдээлэл орно:
А.4.1.1. Хүлээн авагч Тал(ууд)					
А.4.1.2. Бүс нутаг/Аймаг/Сум гэх мэт					
А.4.1.3. Хот/Суурин газар/Тосгон гэх мэт					
А.4.1.4. Газар зүйн байршлын дэлгэрэнгүй тайлбар, үүнд төслийн үйл ажиллагаанд онцгой дугаар онооход шаардлагатай мэдээлэл орно:					
А.4.2. Төслийн үйл ажиллагааны төрөл(үүд)					
А.4.3. Төслийн үйл ажиллагаанд ашиглах технологи					
А.4.4. Сонгосон тооцоот хугацаан дахь ялгаралтын бууралтын тооцоо					
А.4.5. Төслийн үйл ажиллагааны төрийн санхүүжилт					

Б БҮЛЭГ. Ашигласан суурь өгөгдөл, хяналт шинжилгээний аргачлалын танилцуулга					
Б.1. Төслийн үйл ажиллагаанд ашигласан суурь өгөгдөл, хяналт шинжилгээний аргачлалын нэрс, лавлах дугаар					
Б.2. Аргачлалыг сонгосон үндэслэл, төслийн үйл ажиллагаанд ашиглах болсон шалтгаан					
Б.3. Төслийн хил хязгаарт хамаарах эх үүсвэр болон ялгарах хийн танилцуулга					
Б.4. Суурь хувилбарыг хэрхэн тодорхойлсон тухай болон уг суурь хувилбарын танилцуулга					
Б.5. Хүний үйл ажиллагаанаас улбаатай ХүХ-н ялгаралт нь эх үүсвэр тус бүрийн хувьд ЦХМ төслийн үйл ажиллагаа хэрэгжихгүй байх үеийн ялгаралтын түвшнээс бага байх тухай тайлбар (нэмэгдэл чанарын үнэлгээ, баталгаа)					
Б.6. Ялгаралтын бууралт					
<table border="1"> <tr> <td>Б.6.1. Аргачлалын сонголтын талаарх тайлбар</td> </tr> <tr> <td>Б.6.2. Нотолгоо хийх боломжтой тоо баримт, үзүүлэлт</td> </tr> <tr> <td>Б.6.3. Ялгаралтын бууралтын урьдчилсан тооцоо</td> </tr> <tr> <td>Б.6.4. Ялгаралтын бууралтын урьдчилсан тооцооны товчоо</td> </tr> </table>		Б.6.1. Аргачлалын сонголтын талаарх тайлбар	Б.6.2. Нотолгоо хийх боломжтой тоо баримт, үзүүлэлт	Б.6.3. Ялгаралтын бууралтын урьдчилсан тооцоо	Б.6.4. Ялгаралтын бууралтын урьдчилсан тооцооны товчоо
Б.6.1. Аргачлалын сонголтын талаарх тайлбар					
Б.6.2. Нотолгоо хийх боломжтой тоо баримт, үзүүлэлт					
Б.6.3. Ялгаралтын бууралтын урьдчилсан тооцоо					
Б.6.4. Ялгаралтын бууралтын урьдчилсан тооцооны товчоо					
Б.7. Ашигласан хяналт шинжилгээний аргачлал болон хяналт шинжилгээний төлөвлөгөөний танилцуулга					
<table border="1"> <tr> <td>Б.7.1 Хянагдах мэдээлэл, өгөгдөхүүн</td> </tr> <tr> <td>Б.7.2 Хяналт шинжилгээний төлөвлөгөөний танилцуулга</td> </tr> </table>		Б.7.1 Хянагдах мэдээлэл, өгөгдөхүүн	Б.7.2 Хяналт шинжилгээний төлөвлөгөөний танилцуулга		
Б.7.1 Хянагдах мэдээлэл, өгөгдөхүүн					
Б.7.2 Хяналт шинжилгээний төлөвлөгөөний танилцуулга					
Б.8. Ашигласан суурь судалгаа, хяналт шинжилгээний аргачлалын танилцуулга бичсэн өдөр, хариуцсан этгээд/байгууллагын нэр					

(Хувилбар 03 – 2006 оны 7-р сарын 28-д хүчин төгөлдөр болсон) [ГЗ25 Х15]

<b>В БҮЛЭГ. Төслийн үйл ажиллагааны үргэлжлэх хугацаа / Тооцоот хугацаа</b>
В.1. Төслийн үйл ажиллагааны үргэлжлэх хугацаа
В.1.1. Төслийн үйл ажиллагаа эхлэх огноо
В.1.2. Төслийн үйл ажиллагаа үргэлжлэх хүлээгдэж буй хугацаа
В.2. Тооцоот хугацааны сонголт, холбогдох мэдээлэл
В.2.1. Дахин сунгагдах тооцоот хугацаа
В.2.1.1. 1-р тооцоот хугацаа эхлэх огноо
В.2.1.2. 1-р тооцоот хугацааны үргэлжлэх хугацаа
В.2.2. Дахин сунгагдахгүй тооцоот хугацаа
В.2.2.1. Эхлэх огноо
В.2.2.2. Үргэлжлэх хугацаа
<b>Г БҮЛЭГ. Байгаль орчинд үзүүлэх нөлөө</b>
Г.1. Байгаль орчинд үзүүлэх нөлөөнд, үүнд хил хязгаарыг давсан нөлөөг мөн хамруулан хийсэн дүн шинжилгээны баримт бичиг
Г.2. Хэрэв төсөлд оролцогчид, эсвэл хүлээн авагч Талын үзэж буйгаар байгаль орчинд үзүүлэх нөлөө ихтэй бол, хүлээн авагч Талаас тавигдах шаардлага, журмын дагуу байгаль орчны үнэлгээ хийснийг баталсан дүгнэлт, лавлах мэдээллийг хавсаргана уу.
<b>Д БҮЛЭГ. Сонирхлын бүлэглэлүүдийн санал</b>
Д.1. Орон нутаг дахь сонирхлын бүлэглэлүүдийн саналыг хэрхэн авч, эмхэтгэсэн тухай товч тайлбар
Д.2. Хүлээж авсан саналуудын тойм
Д.3. Хүлээж авсан аливаа саналыг хэрхэн зохистой хэмжээнд тусгасан тухай тайлан
<b>Хавсралт 1. Төсөлд оролцогчидтой холбоо барих мэдээлэл</b>
<b>Хавсралт 2. Төрийн санхүүжилтийн талаарх мэдээлэл</b>
<b>Хавсралт 3. Суурь өгөгдлийн мэдээлэл</b>
<b>Хавсралт 4. Хяналт шинжилгээний мэдээлэл</b>

## Хавсралт 1. ЦХМ-ын баримт бичгүүд

### 1-2. Жижиг төслийн үйл ажиллагааны төслийн баримт бичиг (ЦХМ-ЦЖТ-ТББ)

- ◆ Шинэ хувилбар ГЗ-өөр батлагдмагц мөрдөгдөж эхэлнэ.
- ◆ ЦХМ-ЦЖТ-ТББ-н шинэ хувилбарт орсон өөрчлөлтүүд төслийн үйл ажиллагаанд хамаарахгүй. Үүнд:
  - ☞ ЦХМ-ЦЖТ-ТББ-н шинэ хувилбар батлагдахын өмнө магадлагдсан, магадлуулахаар МБ-д өргөн мэдүүлсэн;
  - ☞ ЦХМ-ЦЖТ-ТББ-н шинэ хувилбар батлагдсанаас хойш 1 сарын дотор МБ-д өргөн мэдүүлсэн;
- ◆ ЦХМ-ТББ-н шинэ хувилбар батлагдсанаас хойш 6 сар өнгөрсөн бол, өмнөх хувилбарыг ашиглан боловсруулсан баримт бичгийг ГЗ хүлээж авахгүй. [ЦЖТ Е3 хув4, ху4 хэ11-12]

(Хувилбар 03 – 2006 оны 12-р сарын 22-д хүчин төгөлдөр болсон) [ГЗ28 Х34]

<p><b>А БҮЛЭГ. Жижиг төслийн үйл ажиллагааны ерөнхий танилцуулга</b></p> <p>А.1. Жижиг төслийн үйл ажиллагааны нэр</p> <p>А.2. Жижиг төслийн үйл ажиллагааны танилцуулга</p> <p>А.3. (ЦХМ-ТББ-тай ижил)</p> <p>А.4. Жижиг төслийн үйл ажиллагааны техникийн танилцуулга</p> <p style="margin-left: 20px;">А.4.1. Жижиг төслийн үйл ажиллагааны байршил</p> <p style="margin-left: 40px;">А.4.1.1 – А.4.1.4. (ЦХМ-ТББ-тай ижил)</p> <p style="margin-left: 20px;">А.4.2. Жижиг төслийн үйл ажиллагааны төрөл, ангилал/ууд болон технологи/арга</p> <p style="margin-left: 20px;">А.4.3. Сонгосон тооцоот хугацаан дахь ялгаралтын бууралтын тооцсон хэмжээ</p> <p style="margin-left: 20px;">А.4.4. Жижиг төслийн үйл ажиллагааны төрийн санхүүжилт</p> <p style="margin-left: 20px;">А.4.5. Жижиг төслийн үйл ажиллагаа нь томоохон төслийн үйл ажиллагааны задалсан хэсэг биш болох тухай баталгаа</p>	<p><b>В БҮЛЭГ. Ашигласан суурь өгөгдөл, хяналт шинжилгээний аргачлал</b></p> <p>В.1. Жижиг төслийн үйл ажиллагаанд ашигласан суурь өгөгдөл, хяналт шинжилгээний аргачлалын нэр, лавлах дугаар</p> <p>В.2. Төслийн төрлийг сонгосон үндэслэл</p> <p>В.3. Төслийн хил хязгаарын танилцуулга</p> <p>В.4. Суурь өгөгдөл, түүнийг хэрхэн тодорхойлсон тайлбар</p> <p>В.5. Хүний үйл ажиллагаанаас улбаатай ХүХ-н ялгаралт нь эх үүсвэр тус бүрийн хувьд ЦХМ-ын жижиг төслийн үйл ажиллагаа хэрэгжихгүй байх үеийн ялгаралтын түвшнээс бага байх тухай тайлбар</p> <p>В.6 – В.8. (ЦХМ-ТББ-тай ижил)</p> <p><b>В БҮЛЭГ. (ЦХМ-ТББ-тай ижил)</b></p> <p><b>Г БҮЛЭГ. Байгаль орчинд үзүүлэх нөлөө</b></p> <p>Г.1. Хэрэв хүлээн авагч Талд шаардлагатай бол, төслийн үйл ажиллагааны байгаль орчинд үзүүлэх нөлөөнд хийсэн дүн шинжилгээний баримт</p> <p>Г.2. (ЦХМ-ТББ-тай ижил)</p> <p><b>Д БҮЛЭГ. Сонирхлын бүлэглэлүүдийн санал</b></p> <p>Д.1. Орон нутаг дахь сонирхлын бүлэглэлүүдийн саналыг хэрхэн авч, эмхэтгэсэн тухай товч тайлбар</p> <p>Д.2 – Д.3. (ЦХМ-ТББ-тай ижил)</p> <p><b>Хавсралт 1 – 4. (ЦХМ-ТББ-тай ижил)</b></p>
---	---

**1-3. ЦХМ-ын багцалсан төслийн үйл ажиллагааг өргөн мэдүүлэх маягт (М-ЦХМ-ЦЖТ-БАГЦ)**

Хэрэв төслүүдийн үйл ажиллагааг багцлах хүсэлтэй бол, холбогдох мэдээлэл бүхий маягт (М-ЦХМ-БАГЦ)-ыг хавсаргана. [ЦЖТ Е3 хув4, ху19 хэ8]

<b>А БҮЛЭГ. Багцын ерөнхий танилцуулга</b>
А.1. Багцын нэр: (холбогдох ТББ/д-ийн дугаарын хамт)
А.2. Хувилбар болон огноо: (Маягт, холбогдох ТББ/дийн хувилбар болон огноог бичнэ.)
А.3. Багц, дэд багцуудын танилцуулга
А.4. Төсөлд оролцогчид
<b>Б. Багцын техникийн танилцуулга</b>
Б.1. Багцын байршил
Б.1.1. Хүлээн авагч Тал(ууд)
Б.1.2. Бүс нутаг/Аймаг/Сум гэх мэт: (мэдээллийг хүснэгтээр үзүүлэх)
Б.1.3. Хот/Суурин газар/Тосгн гэх мэт: (мэдээллийг хүснэгтээр үзүүлэх)
Б.1.4. Байршлуудын дэлгэрэнгүй тайлбар, үүнд Багцанд онцгой дугаар онооход шаардлагатай мэдээллийг багтаана.
Б.2. Багцын төрөл, ангилал(ууд), технологи(ууд)/арга(ууд)
Б.3. Сонгосон тооцоот хугацаан дахь ялгаралтын бууралтын тооцоо

<b>В. Төслийн үйл ажиллагаа үргэлжлэх хугацаа / Тооцоот хугацаа</b>
В.1. Багцын үргэлжлэх хугацаа
В.1.1. Багцын эхлэх огноо
В.1.2. Төслийн үйл ажиллагаа үргэлжлэх хүлээгдэж буй хугацаа
В.2. Тооцоот хугацааны сонголт, холбогдох мэдээлэл
В.2.1. Дахин сунгагдах тооцоот хугацаа
В.2.1.1. 1-р тооцоот хугацаа эхлэх огноо
В.2.1.2. 1-р тооцоот хугацааны үргэлжлэх хугацаа
В.2.2. Дахин сунгагдахгүй тооцоот хугацаа
В.2.2.1. Эхлэх огноо
В.2.2.2. Үргэлжлэх хугацаа
<b>Г БҮЛЭГ. Ашигласан хяналт шинжилгээний аргачлал</b>
<b>Хавсралт 1. Багцын оролцогчидтой холбоо барих мэдээлэл</b>

[ЦЖТ Е3 хув4, ху21]

**НЭМЭЛТ: Бүх үйл ажиллагааг хамрах нэг ТББ ашиглах нь** [ЦЖТ Е3 хув4, ху20 хэ17-18]

- ◆Хэрэв багц дахь бүх төслийн үйл ажиллагаа нь нэг төрөлд хамаарах бөгөөд тэдгээрийн ангилал, ашиглах технологи/арга адил бол, бүгдийг нь хамрах нэг ЦХМ-ЦЖТ-ТББ ТО-оос өргөн мэдүүлж болно. Энэ тохиолдолд ТМБ нь нэг нотолгоо, баталгаажуулалтын тайлан гаргана.
- ◆Бусад тохиолдолд (хэрэв багцанд (а) нэг төрлийн, нэг ангилалын боловч өөр өөр технологи/арга ашигласан; (б) нэг төрлийн, өөр өөр ангилалын бөгөөд өөр өөр технологи/арга ашигласан; болон (в) өөр өөр төрлийн төслүүд багтсан бол), ТО нь багц дахь төслийн үйл ажиллагаа тус бүрт ЦХМ-ЦЖТ-ТББ боловсруулж, багцлан, өргөн мэдүүлнэ. Энэ тохиолдолд, багц дахь нотолгооны ижил хугацаа бүхий төслүүдийн үйл ажиллагааг тус бүрт нь дүн шинжилгээ хийж, нотолгоо, баталгаажуулалтын нэг тайлан гаргаж болно.

**1-4. Хөтөлбөрт үйл ажиллагааны төслийн баримт бичгийн маягт (ЦХМ-ХҮа-ББ)**

Хувилбар 01) [Г333 Х41]

◆ Энэ маягтыг ЦХҮа нь том хэмжээний төслийн батлагдсан аргачлалын дагуу хийгдэх ЦХМ-ын ХҮа-г өргөн мэдүүлэхэд ашиглана. Бүртгүүлэх хүсэлт гаргахдаа энэ маягтын зэрэгцээ тухайн ХҮа-д хамаарах ЦХМ-ЦХҮа-ББ болон нэг бодит төслийн ЦХМ-ЦХҮа-ББ-ыг хийж хавсаргана.

<b>А БҮЛЭГ. Хөтөлбөрт үйл ажиллагааны ерөнхий танилцуулга (ХҮа)</b>
A.1. Хөтөлбөрт үйл ажиллагааны нэр
A.2. Хөтөлбөрт үйл ажиллагааны танилцуулга
A.3. ХҮа-г зохицуулах/удирдах байгууллага болон оролцогсод
A.4. Хөтөлбөрт үйл ажиллагааны техникийн танилцуулга
A.4.1. Хөтөлбөрт үйл ажиллагааны байршил
A.4.1.1. Хүлээн авагч Тал(ууд)
A.4.1.2. Бодит/газар зүйн хил хязгаар
A.4.2. Нийтлэг ЦХМ хөтөлбөрт үйл ажиллагааны танилцуулга (ЦХҮа)
A.4.2.1 ЦХҮа-д ашиглах технологи, арга хэмжээнүүд
A.4.2.2 ХҮа-д хамруулах ЦХҮа-ны шалгуур үзүүлэлт
A.4.3. Нэмэгдэл чанарын үнэлгээ, баталгаа
A.4.4. ХҮа-ны үйл ажиллагаа, удирдлага, хяналт шинжилгээний төлөвлөгөө
A.4.4.1 Үйл ажиллагаа, удирдлагын төлөвлөгөө
A.4.4.2. Хяналт шинжилгээний төлөвлөгөө
A.4.5. Хөтөлбөрт үйл ажиллагааны төрийн санхүүжилт
<b>Б БҮЛЭГ. Хөтөлбөрт үйл ажиллагааны үргэлжлэх хугацаа</b>
Б.1 Хөтөлбөрт үйл ажиллагааны эхлэх огноо
Б.2. Хөтөлбөрт үйл ажиллагааны үргэлжлэх хугацаа
<b>В БҮЛЭГ. Байгаль орчны дүн шинжилгээ</b>
В.1. Байгаль орчны дүн шинжилгээ болон ЦХМ-ын дэг, журмын шаардлагыг ямар түвшинд хангаж буйг заана уу. Байгаль орчны дүн шинжилгээ хийсэн түвшний сонголтын үндэслэлийг хийнэ үү.
В.2. Байгаль орчинд үзүүлэх, үүнд хил хязгаарыг давсан нөлөөг мөн хамруулан хийсэн, дүн шинжилгээны талаарх баримт
В.3. Хүлээн авагч Талын хууль/журмын дагуу тухайн хөтөлбөрт үйл ажиллагаанд (ХҮа) хамрагдах нийтлэг ЦХҮа-ны байгаль орчинд үзүүлэх нөлөөний үнэлгээ хийх шаардлагатай эсэхийг заана уу.

<b>Г БҮЛЭГ. Сонирхлын бүлэглэлүүдийн санал</b>
Г.1. Орон нутаг дахь сонирхлын бүлэглэлүүдийн саналыг тусгасан түвшинг заана уу. Тухайн сонголтын үндэслэлийг бичнэ үү.
Г.2. Орон нутаг дахь сонирхлын бүлэглэлүүдийн саналыг хэрхэн авч, эмхэтгэсэн тухай товч тайлбар
Г.3. Хүлээж авсан саналуудын тойм
Г.4. Хүлээж авсан аливаа саналыг хэрхэн зохистой хэмжээнд тусгасан тухай тайлан
<b>Д БҮЛЭГ. Ашигласан суурь өгөгдөл, хяналт шинжилгээний аргачлал</b>
Д.1. ХҮа-д хамрагдсан ЦХҮа тус бүрт ашигласан батлагдсан суурь өгөгдөл, хяналт шинжилгээний аргачлалын нэр, лавлах дугаар
Д.2. Аргачлалыг сонгосон үндэслэл болон ямар учраас энэ нь ЦХҮа-д нийцэх тухай тайлбар
Д.3. ЦХҮа-ны хил хязгаарт хамаарах эх үүсвэр, ялгарах хийн танилцуулга
Д.4. Суурь хувилбарыг хэрхэн тодорхойлсон тухай болон уг суурь хувилбарын танилцуулга
Д.5. ЦХҮа-ны нэмэгдэл чанарын үнэлгээ, баталгаа
Д.5.1. Нийтлэг ЦХҮа-ны нэмэгдэл чанарын үнэлгээ, баталгаа
Д.5.2. ЦХҮа-ны нэмэгдэл чанарыг үнэлэх гол шалгуур, тоо баримт
Д.6. ЦХҮа-ны ялгаралтын бууралтын тооцоо
Д.6.1. Нийтлэг ЦХҮа-д ашигласан батлагдсан суурь өгөгдөл, хяналт шинжилгээний аргачлалын сонголтын талаарх тайлбар
Д.6.2. ЦХҮа-ны ялгаралтын бууралтын тооцоонд ашиглагдах тэгшитгэл, түүний тогтмол өгөгдлүүдийн утга
Д.6.3. ЦХМ-ЦХҮа-ББ маягтад орох тоо баримт, өгөгдлүүд
Д.7. Ашигласан хяналт шинжилгээний аргачлал болон хяналт шинжилгээний төлөвлөгөөний танилцуулга
Д.7.1. ЦХҮа бүрийн хянагдах тоо баримт, өгөгдөхүүн
Д.7.2. ЦХҮа-ны хяналт шинжилгээний төлөвлөгөөний танилцуулга
Д.8. Ашигласан суурь судалгаа, хяналт шинжилгээний аргачлалын танилцуулга бичсэн өдөр, хариуцсан этгээд/байгууллагын нэр
<b>Хавсралт 1 Хөтөлбөрт үйл ажиллагааг зохицуулах/удирдах байгууллага болон оролцогчтой холбоо барих мэдээлэл</b>
<b>Хавсралт 2 Төрийн санхүүжилтийн талаарх мэдээлэл</b>
<b>Хавсралт 3 Суурь өгөгдлийн мэдээлэл</b>
<b>Хавсралт 4 Хяналт шинжилгээний мэдээлэл</b>

**1-5. ЦХМ Хөтөлбөрт үйл ажиллагааны төслийн баримт бичгийн маягт (ЦХМ-ЦХҮа-ББ)**

(Хувилбар 01)  
[ГЗЗЗ Х42]

- ◆ Зохицуулагч/удирдах байгууллага нь ХҮа-ны ББ-н заалтуудыг ашиглан тухайн санал болгож буй ХҮа-ны ЦХМ-ЦХҮа-ББ-ыг боловсруулна.
- ◆ ХҮа-ны ББ-г бүртгүүлэх хүсэлт гаргахдаа тухайн ХҮа-д хамаарах ЦХМ-ЦХҮа-ББ маягт болон нэг бодит төслийн ЦХМ-ЦХҮа-ББ-ыг хийж хавсаргана. Эхний ЦХҮа-ны дараа тухайн ХҮа-нд нэмж хамрагдах ЦХҮа бүрт ЦХМ-ЦХҮа-ББ-ыг бөглөж, мэдүүлнэ.

<p><b>А БҮЛЭГ. ЦХМ Хөтөлбөрт үйл ажиллагааны ерөнхий танилцуулга (ЦХҮа)</b></p>	<p>Б.5. Ялгаралтын бууралт</p>
<p>А.1. ЦХҮа-ны нэр</p>	<p>Б.5.1. Магадлагаа хийх тоо баримт, өгөгдлүүд</p>
<p>А.2. ЦХҮа-ны танилцуулга</p>	<p>Б.5.2. Ялгаралтын бууралтын урьдчилсан тооцоо</p>
<p>А.3. ЦХҮа-г хариуцаж буй байгууллага/этгээд</p>	<p>Б.5.3. Ялгаралтын бууралтын урьдчилсан тооцооны товчоо</p>
<p>А.4. ЦХҮа-ны техникийн танилцуулга</p>	<p>Б.6. Ашигласан хяналт шинжилгээний аргачлал болон хяналт шинжилгээний төлөвлөгөөний танилцуулга</p>
<p>А.4.1. ЦХҮа-г таних тодотгол</p>	<p>Б.6.1. Хяналт шинжилгээний төлөвлөгөөний танилцуулга</p>
<p>А.4.1.1. Хүлээн авагч Тал</p>	<p><b>В. БҮЛЭГ. Байгаль орчны дүн шинжилгээ</b></p>
<p>А.4.1.2. Газар зүйн байршлын лавлагаа болон тухайн ЦХҮа-г онцгойлон таних бусад тодотголууд</p>	<p>В.1. Байгаль орчны дүн шинжилгээ болон ЦХМ-ын дэг, журмын шаардлагыг ямар түвшинд хангаж буйг дурьдана уу. Байгаль орчны дүн шинжилгээ хийсэн түвшний сонголтын үндэслэл</p>
<p>А.4.2. ЦХҮа-ны үргэлжлэх хугацаа</p>	<p>В.2. Байгаль орчинд үзүүлэх нөлөөнд, үүнд хил хязгаарыг давсан нөлөөг мөн хамруулан хийсэн дүн шинжилгээний баримт бичиг</p>
<p>А.4.2.1 ЦХҮа-ны эхлэх огноо</p>	<p>В.3. Хүлээн авагч Талын хууль/журмуудын дагуу тухайн хөтөлбөрт үйл ажиллагаанд (ХҮа) хамрагдах нийтлэг ЦХҮа-ны байгаль орчинд үзүүлэх нөлөөний үнэлгээ хийх шаардлагатай эсэхийг дурьдана уу.</p>
<p>А.4.2.2 ЦХҮа-ны үйл ажиллагаа үргэлжлэх хүлээгдэж буй хугацаа</p>	<p><b>Г БҮЛЭГ. Сонирхлын бүлэглэлүүдийн санал</b></p>
<p>А.4.3. Тооцоот хугацааны сонголт, холбогдох мэдээлэл</p>	<p>Г.1. Орон нутаг дахь сонирхлын бүлэглэлүүдийн саналыг тусгасан түвшинг заана уу. Тухайн сонголтын үндэслэлийг бичнэ үү.</p>
<p>А.4.3.1. Тооцоот хугацаа эхлэх огноо:</p>	<p>Г.2. Орон нутаг дахь сонирхлын бүлэглэлүүдийн саналыг хэрхэн авч, эмхэтгэсэн тухай товч тайлбар</p>
<p>А.4.3.2. Тооцоот хугацааны, хэрэв дахин сунгагдах бол эхний тооцоот хугацааны үргэлжлэх хугацаа</p>	<p>Г.3. Хүлээж авсан саналуудын тойм</p>
<p>А.4.4. Сонгосон тооцоот хугацаан дахь ялгаралтын бууралтын тооцсон хэмжээ</p>	<p>Г.4. Хүлээж авсан аливаа саналыг хэрхэн зохистой хэмжээнд тусгасан тухай тайлан</p>
<p>А.4.5. ЦХҮа-ны төрийн санхүүжилт</p>	<p><b>Хавсралт 1 ЦХҮа-г хариуцах байгууллага/этгээдтэй холбоо барих мэдээлэл</b></p>
<p>А.4.6. ЦХҮа нь тусгайдаа ЦХМ төслөөр бүртгэгдээгүй, мөн бусад бүртгэгдсэн ХҮа-ны хэсэг биш болох тухай баталгаа</p>	<p><b>Хавсралт 2 Төрийн санхүүжилтийн талаарх мэдээлэл</b></p>
<p><b>Б БҮЛЭГ. ЦХҮа-д нийцэх байдал болон ялгаралтын бууралтын тооцоо</b></p>	<p><b>Хавсралт 3 Суурь өгөгдлийн мэдээлэл</b></p>
<p>Б.1. ЦХҮа-г нэмж оруулах бүртгэгдсэн ХҮа-ны нэр, лавлах дугаар</p>	<p><b>Хавсралт 4 Хяналт шинжилгээний мэдээлэл</b></p>
<p>Б.2. ЦХҮа-г бүртгэгдсэн ХҮа-д нэмж оруулах нь яагаад зохистой байгаа үндэслэл</p>	
<p>Б.3. ЦХҮа-ны нэмэгдэл чанар болон бүртгэгдсэн ХҮа-д заагдсан шалгуурт хэрхэн нийцэж буйн үнэлгээ, баталгаа</p>	
<p>Б.4. Төслийн хил хязгаарт хамаарах эх үүсвэр болон ялгарах хийн танилцуулга, мөн ЦХҮа нь бүртгэгдсэн ХҮа-ны газар зүйн хил хязгаарт оршиж буйн баталгаа</p>	

## Хавсралт 2. Аргачилсан зааврууд

Нэмэгдэл чанарыг харуулах аргачилсан зааврууд (О/НС ЦХМ төслийн үйл ажиллагаанд мөн хамааралтай)	
1. Нэмэгдэл чанарыг батлах, үнэлэх заавар (хув 4) [Г336 X13]	Нэмэгдэл чанарыг батлах, үнэлэх үе шат бүхий аргыг санал болгоно. (X.4)
2. Суурь хувилбарыг тодорхойлох болон нэмэгдэл чанарыг батлах хавсарсан заавар (хув 2.1) [Г328 X14]	Суурь хувилбарыг тодорхойлохын зэрэгцээ нэмэгдэл чанарыг батлах үе шат бүхий аргыг санал болгоно.
3. О/НС ЦХМ төслийн үйл ажиллагааны нэмэгдэл чанарыг батлах заавар [Г335 X17]	О/НС ЦХМ төслийн үйл ажиллагааны нэмэгдэл чанарыг батлах, үнэлэх үе шат бүхий аргыг санал болгоно.
ЦХМ төслийн үйл ажиллагаатай холбоотой ялгаралтын хэмжээг тодорхойлох аргачилсан зааврууд	
4. Цахилгаан эрчим хүчний системийн ялгарлын фактор тодорхойлох заавар (хув.1) [Г3 35 X12]	Цахилгаан эрчим хүчний сүлжээний станц үйлдвэрлэсэн эрчим хүчийг орлох үйлдвэрлэлийн CO <sub>2</sub> ялгаралтын хэмжээг “үйл ажиллагааны дундаж” (ҮАД), “суурилагдсан дундаж” (СД) болон “холимог дундаж” (ХД)-ийг тус тус тооцох замаар тооцно.
5. Цахилгаан эрчим хүчний хэрэглээтэй холбогдсон төслийн ялгаралтын хэмжээг тооцох заавар (хув.1) [Г332 X10]	Тухайн ЦХМ төслийн үйл ажиллагаатай холбогдох цахилгаан эрчим хүчний хэрэглээнээс үүсэх ялгаралтын хэмжээг тооцох заавар юм. Жишээ нь, тухайн үйлдвэрийн (хог боловсруулах үйлдвэр, биотүлш үйлдвэрлэх үйлдвэр г.м) үйл ажиллагаанд нэмэгдэл цахилгаан эрчим хүч хэрэглэгдэх байж болно.  Хэрэв төслийн хүрээнд сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээр гаргаж авсан цахилгаан эрчим хүчийг уг төслийн үйл ажиллагаанд ашиглах тохиолдолд энэ заавар хэрэглэгдэхгүй.
6. Малтмал түлш шатаахтай холбогдох төслийн болон нэвчилтийн CO <sub>2</sub> ялгаралтын хэмжээг тооцох заавар (хув1) [Г332 X9]	Малтмал түлш шатаалтаас үүсэх төслийн болон/буюу нэвчилтийн CO <sub>2</sub> ялгаралтын хэмжээг тооцох заавар юм. CO <sub>2</sub> ялгаралтын хэмжээг тухайн хэрэглэсэн түлшний тоо хэмжээ, шинж чанарт үндэслэн тооцох тохиолдолд энэ аргыг ашиглана.
7. Хатуу хаягдлын хогийн цэг дэх метаны ялгаралтыг арилгасан хэмжээг тодорхойлох заавар (хув 2) [Г335 X10]	Төслийн үйл ажиллагаа хэрэгжээгүй тохиолдолд, хатуу хог хаях цэг (ХХХЦ)-ээс бий болох метаны ялгаралтын суурь хэмжээг тооцох аргыг санал болгоно. Ялгаралтын бууралтыг ЭЭЗ (FOD) (эхний эрэмбийн задрал-first order decay) модель ашиглан тооцно.
8. Метан агуулсан хий шатаах төслийн ялгаралтыг тодорхойлох заавар [Г328 X13]	Метан агуулсан хаягдал хийн урсгал (ХУ)-ыг шатаах төслийн ялгаралтыг тодорхойлох журмыг санал болгоно. Дараах нөхцөл байдалд ашиглах боломжтой. Үүнд: ⇒ Шатаагдах хаягдал хийн урсгал нь метан, нүүрсхүчлийн хий болон устөрөгчөөс бусад шатамхай бодис агуулаагүй байх; ⇒ Шатаагдах хаягдал хийн урсгал нь органик бодисын задрал (хогийн цэг, био-боловсруулагч, битүү цүлхэн гэх мэт), эсвэл нүүрсний уурхайгаас гарах хий (нүүрсний давхарга болон уурхай дахь метан)-нээс үүсэлтэй байна.



О/НС ЦХМ төслийн үйл ажиллагаанд зориулагдсан аргачилсан зааврууд	
9. О/НС ЦХМ төслийн үйл ажиллагаанд хэмжилт хийхэд шаардагдах түүвэр судалгааны хэмжилтийн цэгийн тоог тооцох урьдчилсан заавар [Г331 X15]	Хяналт шинжилгээнд түүвэр судалгааны арга ашиглагдах үед энэ аргыг хэрэглэнэ. Нүүрстөрөгчийн цөөрөм дэх өөрчлөлтүүдийг хүссэн нарийвчлалтайгаар тогтооход хэчнээн байнгын хэмжилт хийх цэг байхыг тодорхойлдог. Дараах тохиолдолд байнгын цэгүүдийг ашиглавал зохино. Үүнд: ⇒ Тодорхой давтамжтайгаар хэмжилт хийх; ⇒ Дараалсан хэмжилтүүдийн хоорондох шууд хамаарал өндөр байх магадлалтай үед.
10. О/НС ЦХМ төслийн үйл ажиллагаатай холбоотой ХүХ-н ялгаралтын хэмжээ ач холбогдолтой эсэхийг тогтоох урьдчилсан заавар (хув.1) [Г331 X16]	Тухайн ЦХМ О/НС төслийн үйл ажиллагааны хувьд аль эх үүсвэрүүдийн ХүХ-н ялгаралт, нүүрстөрөгчийн цөөрмийн нөөцийн бууралт болон ялгаралтын нэвчилт зэрэг нь тооцоонд ач холбогдолтой эсэхийг тогтооход ашиглана. Нүүрстөрөгчийн цөөрмийн нөөцийн бууралт болон ялгаралтын нэмэгдлийн нийлбэр нь нүүрстөрөгчийн цөөрмийн нөөцийн нийт бууралт болон ялгаралтын нийт нэмэгдлийн 5%-аас бага, эсвэл хүний үйл ажиллагаанаас улбаатай шингээлтийн цэвэр хэмжээний 5%-аас бага байвал тэдгээрийг тооцоонд оруулах шаардлагагүй гэж үзнэ.
11. О/НС төслийн үйл ажиллагааны хүрээнд малтмал түлш шатаахтай холбоотой ХүХ-н ялгаралтын хэмжээг тооцох [Г333 X14]	Энэ заавар нь О/НС төслийн үйл ажиллагааны хүрээнд холбогдох малтмал түлш шатаалтаас үүдсэн ХүХ-н ялгаралтын (төслийн ялгаралт болон нэвчилт) нэмэгдэх хэмжээг тооцох боломж олгоно. Ялгаралтын эх үүсвэрүүд нь: тээврийн хэрэгсэл (ачааны тэрэг, трактор г.м. хөдөлгөөнт эх үүсвэрүүд ) болон механик тоног төхөөрөмжүүд (жишээлбэл, гинжит хөрөө г.м зөөврийн болон усны насос зэрэг суурин тоног төхөөрөмж) зэрэг О/НС төслийн үйл ажиллагаанд шаардагдах зүйлүүд байна.
12. О/НС ЦХМ төслийн үйл ажиллагааны хувьд хөрсний органик нүүрстөрөгчийн цөөрмийг консерватив (багаар тооцох) тооцоонд оруулахгүй байж болох эсэхийг тогтооход мөрдөх журам (хув.1) [Г333 X15]	Энэ заавар нь О/НС ЦХМ төслийн үйл ажиллагааны хувьд хөрсний органик нүүрстөрөгчийн цөөрмийг консерватив (багаар тооцох) тооцоонд оруулахгүй байж болох эсэхийг тогтооход мөрдөх удирдамж юм. Энэхүү удирдамж нь сүүлийн үеийн шинжлэх ухааны нийтлэлүүдэд хийсэн мэргэжилтнүүдийн дүгнэлт болон УӨЗГХК-ийн холбогдох баримт бичгүүдэд үндэслэн боловсруулагдсан юм. Газар ашиглалт, газар ашиглалтын өөрчлөлттэй холбоотой хөрсний органик нүүрстөрөгчийн цөөрмийн өөрчлөлтийг нотлох баримт хязгаарлагдмал бол консерватив аргыг сонгоно.
13. “Азотын бордоо хэрэглэсний дүнд шууд ялгарах азотын хүчлийн ялгаралтын хэмжээг тооцоолох нь” хув.1) [Г333 X16]	О/НС төслийн үйл ажиллагааны хүрээнд тухайн төслийн хил хязгаарын дотор азотын бордоо хэрэглэснээс үүдэн шууд ялгарах азотын хүчлийн ялгаралтын урьдчилсан болон <i>ex-post</i> (гүйцэтгэлийн дараах) хэмжээг энэ зааврын дагуу тооцох боломжтой.
14. ЦХМ О/НС төслийг хэрэгжилтийн улмаас тухайн үеийн ургамалжилтыг хадсан, шатаасан болон хагдруулсны улмаас ялгарсан ХүХ ялгаралтыг тооцох заавар (хув.1) [Г336 X20]	тухайн төсөлд хамрагдах газар нутгийн О/НС төсөл хэрэгжиж эхлэх үеийн амьд ургамалжилтын улмаас ихэссэн ХүХ-ийн ялгаралтын өсөлтийг тодорхойлоход энэ зааврыг мөн ашиглаж болно—“тухайн үеийн ургамалжилт”—төслийн талбай бэлдэх эсвэл бусад төслийн хэрэгжилттэй холбоотой үйл ажиллагааны улмаас хадагдсан, шатсан болон/эсвэл хагдарч хаягдсан ургамалжилт
15. О/НС ЦХМ төслийн хүрээнд бэлчээрийн хэлбэрийг өөрчилснөөс улбаатай ХүХ-ийн ялгаралтыг тооцох заавар (хув.1) [Г336 X19]	О/НС ЦХМ төслийн хэрэгжилтийн улмаас бэлчээрийн малыг өөр тийш нүүлгэснээс ялгарсан ХүХ ялгаралтыг хэмжихэд энэхүү зааврыг ашиглана. Түүнээс гадна тодорхой ойн мод, жил бүр ургац авдаг тариалангийн талбай, бэлчээр болон онгон газар нутгийг өөрчилсний улмаас ялгарч буй ялгаралтыг тооцоход энэ зааврыг мөн ашиглаж болно.

### Хавсралт 3. Батлагдсан аргачлал

Түлхүүр үг	Тоот	Хув.	Батлагдсан аргачлалын нэр	Заавар*	Хүчинтэй болох хугацаа	Бүрт*
Сэргээгдэх эрчим хүч	БНА0002	7	Төвлөрсөн сүлжээнд холбогдсон сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлд ашиглах суурь өгөгдлийн нэгдсэн аргачлал	1,4,6	2007.12.14	169
	БАр0019	2	Малтмал түлшинд түшиглэсэн, бие даасан, эсвэл төвлөрсөн сүлжээнд холбогдсон цахилгаан станцын эрчим хүчний үйлдвэрлэлийн нэг хэсгийг орлоход чиглэсэн биомассаас бусад сэргээгдэх эрчим хүчний төсөл	1	2006.05.19	0
	БАр0026	3	Аль бага өртгийн дарааллаар (merit-order) түгээх тогтолцоо бүхий Чили болон бусад орны төвлөрсөн сүлжээнд холбогдсон, сэргээгдэх эх үүсвэрээс тэг ялгаралттай цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх аргачлал	1,4	2007.11.02	1
	БАЖ-I.A.	12	Хэрэглэгчийн цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэл		2007.08.10	6
	БАЖ-I.B.	10	Цахилгаан эрчим хүчинд холбогдсон эсэхээс нь үл хамааран хэрэглэгчдийг механик эрчим хүчээр хангах		2007.08.10	0
	БАЖ-I.B.	12	Цахилгаан эрчим хүчинд холбогдсон эсэхээс нь үл хамааран хэрэглэгчийг дулааны эрчим хүчээр хангах		2007.08.10	45
	БАЖ-I.G.	13	Сүлжээнд нийлүүлэгдэх сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэл		2007.12.14	283
Биомасс	БНА0006	6	Төвлөрсөн сүлжээнд холбогдсон, биомассын хаягдал ашиглан эрчим хүч үйлдвэрлэх төсөлд ашиглах суурь өгөгдлийн нэгдсэн аргачлал	2,5,6,7	2007.08.10	68
	БАр0007	1	Биомассаар цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэх улирлын шинж чанартай станцын хамгийн бага өртөг бүхий түлшний сонголтын дүн шинжилгээ		2007.06.14	0
	БАр0036	2	Халаалтын уурын зууханд ашиглах малтмал түлшийг биомассын үлдэгдлээр солих	1,7	2007.08.10	2
	БАр0042	2	Шинээр тусгайлан байгуулсан тариалангийн биомасс ашиглан төвлөрсөн сүлжээнд холбогдсон цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх	1,4	2007.11.02	0
	БАЖ-I.D.	1	Хэрэглэгч дулааны хэрэглээндээ ашиглаж буй сэргээгдэх бус биомассын түлшийг солих		2008.02.01	0
	БАЖ-III.D.	15.1	Хяналт бүхий шатаах, хийжүүлэх болон механик/дулааны аргаар биомассын ялзарлаас гаралтай метаны ялгаралтыг арилгах		2007.12.14	22

Түлхүүр үгт тулгуурласан ангиллыг зохиогчид хийсэн бөгөөд НҮБҮӨСК баримт бичигт дурдагдаагүй болно.  
 Заавар\*: Батлагдсан аргачлалд ашиглагдах аргачлалын зааврууд. Хавсралт 2-оос зааврын оноосон нэрийг харна уу.  
 Бүрт\*: Жагсаалтанд орсон аргачлал (өмнөх болон сольсон хувилбаруудыг оролцуулан)-ыг ашиглан 2008.1.31-ны байдлаар бүртгүүлсэн ЦХМ төслийн нийт тоо.

**Хавсралт 3. Батлагдсан аргачлал**

Түлхүүр үг	Тоот	Хув.	Батлагдсан аргачлалын нэр	Заавар*	Хүчинтэй болох хугацаа	Бүрт
Хаягдал хий эсвэл хаягдал дулаан	<b>БНА0012</b>	<b>2</b>	<b>Хаягдал хий, хаягдал дулаан, болон хаягдал даралтад тулгуурласан эрчим хүчний системийн ХүХ-н ялгаралт бууруулах нэгдсэн аргачлал</b>	1,4	2007.11.02	45
	БАр0009	3	Газрын тосны цооногийн хаягдал хийг хурааж, ашиглах	2,5,6	2007.12.14	3
	БАр0024	2	Цементийн үйлдвэрийн хаягдал дулаан ашиглан эрчим хүч үйлдвэрлэх замаар хүлэмжийн хийн ялгаралтыг бууруулах аргачлал	1,4	2007.11.02	3
	БАр0037	1.1	Газрын тос, хий боловсруулах байгууламжийн хаягдал хийг ашиглах, шаталтыг багасгах	1	2006.09.29	1
	БАр0055	1.1	Цэвэршүүлэх үйлдвэрийн байгууламж дахь хаягдал хий ашиглалтын суурь өгөгдөл, хяналт шинжилгээний аргачлал	2,5	2007.07.27	0
	БАЖ-III.О.	1	Боловсруулах байууламжийн хаягдал хийг хурааж, ашиглах		2007.10.19	0
	БАЖ-III.Ө.	1	Хаягдал хийд тулгуурласан эрчим хүчний систем		2007.10.19	0
Түлшийг солих	<b>БНА0009</b>	<b>3</b>	<b>Аж үйлдвэрийн зориулалттай нүүрс болон газрын тосны гаралтай түлшийг байгалийн хийн түлшээр солих нэгдсэн аргачлал</b>	1	2006.07.28	10
	<b>БНА0011</b>	<b>2</b>	<b>Нүүрс болон газрын тосны гаралтай түлшийг цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлд ашиглагдаж буй байгалийн хийгээр солих нэгдсэн аргачлал</b>	1,2,4,6	2007.11.02	0
	<b>БНА0013</b>	<b>1</b>	<b>Малтмал түлш шатаан ашиглагаж буй цахилгаан станцууд харьцангуй бага ХүХ ялгаруулах технологи ашиглах байгаа эсэхийг үнэлэх суурь өгөгдлийн болон хяналтын нэгдсэн аргачлал</b>	1,6	2007.09.14	0
	БАр0014	4	Байгалийн хийд түшиглэх цахилгаан, дулааны эрчим хүчний үйлдвэрлэл	1	2007.08.10	1
	БАр0029	2	Байгалийн хий ашиглан төвлөрсөн сүлжээнд холбогдсон цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх төслийн аргачлал	1,4	2007.11.02	2
	БАр0048	2	Нүүрстөрөгчийн агууламж өндөртэй түлшинд түшиглэсэн, төвлөрсөн сүлжээнд холбогдсон/үгүй, уур болон цахилгааны эрчим хүчний эх үүсвэрийг орлох, олон төрлийн хэрэглэгчдийг цахилгаан, уураар хангах, цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэх шинэ байгууламжууд	1,4	2007.11.02	0
	БАЖ-III.Б.	12	Малтмал түлшийг солих		2007.11.02	7

Түлхүүр үгт тулгуурласан ангиллыг зохиогчид хийсэн бөгөөд НҮБҮӨСК баримт бичигт дурдагдаагүй болно.  
 Заавар\*: Батлагдсан аргачлалд ашиглагдах аргачлалын зааврууд. Хавсралт 2-оос зааврын оноосон нэрийг харна уу.  
 Бүрт\*: Жагсаалтанд орсон аргачлал (өмнөх болон сольсон хувилбаруудыг оролцуулан)-ыг ашиглан 2008.1.31-ны байдлаар бүртгүүлсэн ЦХМ төслийн нийт тоо.

**Хавсралт 3. Батлагдсан аргачлал**

Түлхүүр үг	Тоот	Хув.	Батлагдсан аргачлалын нэр	Заавар*	Хүчинтэй болох хугацаа	Бүрт*
Эрчим хүчний үр ашиг-нийлүүлэгч тал	БНА0007	3	Эрчим хүчний үйлдвэрлэлийг дан мөчлөгөөс олон мөчлөгт шилжүүлэх төслийн аргачлал	2,4	2007.11.02	1
	БАр0017	2	Уурын хаалтыг солих, уурын конденсат буцаах замаар уурын системийн үү ашгийг сайжруулах		2005.06.22	0
	БАр0018	1.1	Уурын системийг сайжруулах систем	1	2004.12.04	7
	БАр0038	2	SiMn-ийн үйлдвэрлэлд ашигладаг цахилгаан нуман зуухын эрчим хүчний ашиглалтыг сайжруулах аргачлал	1,4	2007.11.02	1
	БАр0044	1	Эрчим хүчний ашиглалтын сайжруулах төсөл: аж үйлдвэрийн болон дулааны шугам сүлжээний уурын зуух сунгах, солих	1	2006.12.22	0
	БАр0045	2	Цахилгаан эрчим хүчний салангид эх үүсвэрүүдийг сүлжээнд холбох	1,4	2007.11.02	1
	БАр0049	2	Аж үйлдвэрийн байгууламж дахь хий ашиглан цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх аргачлал	1,4	2007.11.02	0
	БАр0052	2	Автоматчлагдсан диспетчерийн системийг сайжруулах замаар одоо ажиллаж буй усан цахилгаан станцын эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх	1,4	2007.11.02	0
	БАр0054	2	Тос/усны эмульсын технологи ашиглан уурын зуухны үр ашгийг сайжруулах	1,2,4	2007.11.02	0
	БАр0056	1	Малтмал түлшээр ажиллах уурын зуухны системийн зуух солих, сунгах болон түлш солих замаар үр ашгийг сайжруулах	2,6	2007.07.27	0
	БАр0058	1	Үндсэн шинэ төвлөрсөн дулаан хангамжийн системийг нэвтрүүлэх	1,2,6	2007.10.19	0
	БАр0061	1	Одоогийн ашиглагдаж буй эрчим хүчний станцуудыг сэргээн засварлах болон эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх аргачлал	2,4,6	2007.11.30	0
	БАр0062	1	Турбинуудыг шинэчлэн засварлах замаар станцуудын эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх	2,4,6	2007.11.30	0
	БАЖ-II.A.	9	<i>Нийлүүлэгч талын эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх – дамжуулалт болон түгээлт</i>		2007.08.10	0
БАЖ-II.B.	9	<i>Нийлүүлэгч талын эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх – үйлдвэрлэл</i>		2007.08.10	9	
БАЖ-III.Л.	2	<i>Цаасны үйлдвэрлэлийн явцад натри бикарбонатыг ялгаж авах замаар цахилгаан эрчим хүчний хэрэглээг багасгах</i>		2007.08.10	0	
Эрчим хүчний үр ашиг-хэрэглэгч тал	БАр0020	2	Усны шахуургын үр ашгийг сайжруулах төслийн суурь өгөгдлийн аргачлал	1,4	2007.11.02	0
	БАр0046	2	Айл өрхийг эрчим хүч хэмнэлттэй чийдэнгээр хангах	1,4	2007.11.02	0
	БАр0060	1	Power saving through replacement by energy efficient chillers	2,4	2007.11.30	0
	БАЖ-II.B.	9	<i>Хэрэглэгч талын эрчим хүчний ашиглалтыг сайжруулах тусгай технологийн хөтөлбөрүүд</i>		2007.08.10	4
	БАЖ-II.Г.	11	<i>Үйлдвэрийн байгууламжийн эрчим хүчний ашиглалтын сайжруулах, түлш солих арга хэмжээ</i>		2007.11.02	29
	БАЖ-II.Д.	10	<i>Барилга байгууламжийн эрчим хүчний ашиглалтын сайжруулах, түлш солих арга хэмжээ</i>		2007.11.02	6
	БАЖ-II.E.	9	<i>Хөдөө аж ахуйн байгууламж, үйл ажиллагааны эрчим хүчний ашиглалтын сайжруулах, түлшний солих арга хэмжээ</i>		2007.08.10	0
БАЖ-II.	1	<i>Сэргээгдэхгүй биомассны дулааны хэрэглээний эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээ</i>		2008.02.01	0	

Түлхүүр үгт тулгуурласан ангиллыг зохиогчид хийсэн бөгөөд НҮБҮӨСК баримт бичигт дурдагдаагүй болно.

Заавар\*: Батлагдсан аргачлалд ашиглагдах аргачлалын зааврууд. Хавсралт 2-оос зааврын оноосон нэрийг харна уу.

Бүрт\*: Жаргасалтын өрсөн аргачлал (өмнөх болон сольсон хувилбаруудыг оролцуулан)-ыг ашиглан 2008.1.31-ны байдлаар бүртгүүлсэн ЦХМ

Хавсралт 3. Батлагдсан аргачлал

Түлхүүр үг	Тоот	Хув.	Батлагдсан аргачлалын нэр	Заавар*	Хүчинтэй болох хугацаа	Бүрт
Биотүлш	BAp0047	2	Хаягдал тос болон бионеник гаралтай хаягдал өөх ашиглан түлшинд хэрэглэх биодизель үйлдвэрлэх	1	2007.08.10	0
	<i>БАЖ-III.C.</i>	1	<i>Тосны үйлдвэрлэл эрхлэн, тээврийн зориулалтаар ашиглах</i>		2007.11.30	0
Тээвэр	BAp0031	1	Нийтийн автобус тээврийн шуурхай сүлжээний төслийн аргачлал	1	2006.07.28	1
	<i>БАЖ-III.B.</i>	11	<i>Хүх бага ялгаруулах тээврийн хэрэгслийн тусламжтайгаар ялгаралтыг бууруулах</i>		2007.08.10	1
	<i>БАЖ-III.E.</i>	1	<i>Ялгаруулалт багатай тээврийн хэрэгслийг зах зээлд нэвтрүүлэх</i>		2007.11.30	0
Цемент	БНА0003	7	Цементийн үйлдвэрлэлд ашиглах малтмал түлшийн алтернатив эсвэл арай бага карбон ялгаруулах түлшээр хэсэгчлэн орлуулах замаар ялгаралтыг бууруулах	2,5,6,7	2007.12.14	8
	БНА0005	4	Цементийн үйлдвэрлэлийн Холих шатлагийг сайжруулах нэгдсэн аргачлал	1,4	2007.11.02	14
	БНА0015	1	Нүүрстөрөгч агуулаагүй альтернатив түүхий эдийг цемент шатаах зууханд клинкер үйлдвэрлэл явуулахдаа ашиглах төслийн үйл ажиллагааны суурь өгөгдөл болон хяналт шинжилгээний аргачлал	1,4	2007.11.30	0
Материал ашиглалт	BAp0027	2.1	Органик бус нэгдлийн үйлдвэрлэлийн малтмал болон эрдэс чулуулаг эх үүсвэр бүхий CO <sub>2</sub> -г сэргээгдэх эх үүсвэр бүхий CO <sub>2</sub> -оор солих	1	2006.10.06	1
	BAp0050	2	Аммиак-мочевины нэгдсэн үйлдвэрлэлийн түүхий эдийг солих	2,4	2007.11.02	0
	BAp0057	2	Биомассын хаягдлыг цаасны үйлдвэрийн түүхий эд болгон ашиглах замаар ялгаралтыг арилгах	1,5,6,7,8	2007.12.14	0
	BAp0063	1	Аж үйлдвэрийн байгууламжийн хаягдал хийнээс ялгарах CO <sub>2</sub> –ийг дахин ашиглах замаар CO <sub>2</sub> үйлдвэрлэлийн малтмал түлшний хэрэглээг оруулах	1,2,4,5,6	2007.11.30	0
	<i>БАЖ-III.I</i>	3	<i>Аж үйлдвэрийн түүхий эд болгон ашиглагдах нүүрстөрөгчийн давхар ислийн үйлдвэрлэлд малтмал түлш хэрэглэхийг зогсоох</i>		2007.08.10	0
	<i>БАЖ-III.H.</i>	1	<i>Био хийнээс гаргаж авах метаныг ашиглан устөрөгч үйлдвэрлэх</i>		2007.10.19	0

Түлхүүр үгт тулгуурласан ангиллыг зохиогчид хийсэн бөгөөд НҮБҮӨСК баримт бичигт дурдагдаагүй болно.  
 Заавар\*: Батлагдсан аргачлалд ашиглагдах аргачлалын зааврууд. Хавсралт 2-оос зааврын оноосон нэрийг харна уу.  
 Бүрт\*: Жагсаалтанд орсон аргачлал (өмнөх болон сольсон хувилбаруудыг оролцуулан)-ыг ашиглан 2008.1.31-ны байдлаар бүртгүүлсэн ЦХМ төслийн нийт тоо.

**Хавсралт 3. Батлагдсан аргачлал**

Түлхүүр үг	Тоот	Хув.	Батлагдсан аргачлалын нэр	Заавар*	Хүчинтэй болох хугацаа	Бүрт*
Био хий	БНА0010	3	Малын бууц ашиглалтын системийн ХүХ-н ялгаралтыг бууруулах төслийн суурь өгөгдлийн нэгдсэн аргачлал	5,6,8	2007.11.02	51
	БНА0014	1	Хаягдал ус цэвэршүүлэхэд ялгарах метаны ялгаралтыг арилгах	1,4,5,6,8	2007.11.30	7
	БАр0053	1	Байгалийн хий түгээх системд биологийн аргаар боловсруулсан метан шахах	1,5,6,8	2007.06.22	0
	БАЖ-III.Г.	13	Хөдөө аж ахуйн болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас ялгарах метаныг хураах		2007.08.10	78
	БАЖ-III.Ж	8	Хаягдал ус цэвэрлэх төхөөрөмжөөс ялгарах метаныг хураах		2007.12.14	9
	БАЖ-III.З.	6	Битүү цүлхэнг задгай системээр солих замаар бохир ус цэвэрлэх төхөөрөмж дэх метаны ялгаралтыг арилгах		2007.08.10	2
Хогийн цэгээс ялгарах хаягдал хий	БНА0001	8	Хогийн цэгээс ялгарах хаягдал хийн төслийн үйл ажиллагааны нэгдсэн суурь өгөгдлийн болон хяналт шинжилгээний аргачлал	1,2,5,6,7,8	2007.12.14	66
	БАЖ-III.Ё.	5	Хогийн цэгээс ялгарах хаягдал хийг хураах		2007.08.10	3
Бордоо	БАр0025	10	Хаягдал боловсруулах альтернатив аргаар органик хаягдлын ялгаралтыг арилгах арга	1,4,7,8	2007.11.02	5
	БАр0039	2	Органик гаралтай шингэн хаягдал болон биоорганик хатуу хаягдлыг холимог бордоо болгох замаар метаны ялгаралтыг бууруулах	1,7	2007.11.02	0
	БАЖ-III.Е.	5	Биомассын ялзарлаас гаралтай метаны ялгаралтыг бордоонд ашиглах замаар арилгах		2007.08.10	5
Нүүрсний далд уурхай/давхаргын метан	БНА0008	4	Нүүрсний давхарга, далд уурхайн болон агаар солилцооны метан хурааж эрчим хүч (цахилгаан эсвэл механик), дулаан үйлдвэрлэх ба/эсвэл устгах нэгдмэл аргачлал	1,4,8	2007.11.02	7
	БАр0064	1	Уурхайн метаныг хураах, ашиглах эсвэл газрын гүн, хатуу чулуулга, үнэт болон үндсэн металын уурхайд булан устгах аргачлал	1,2,4,5,6,8	2007.11.30	0
Алдагдлыг бууруулах	БАр0023	2	Байгалийн хий дамжуулах хоолойн компрессор болон зангилаа станцуудын алдагдлыг багасгах		2007.05.18	0
	БАр0043	2	Хуучин төмөр хоолойг полиэтилен хоолойгоор солих замаар байгалийн хийг дамжуулах системийн алдагдлыг багасгах	1	2007.11.02	0
Метантай холбоотой бусад	БАр0041	1	Модны нүүрс үйлдвэрлэл дэх мод нүүрстөрөгчжүүлэх ажиллагааны метаны ялгаралтыг бууруулах	1	2005.11.02	1
	БАЖ-III.Й.	3	Задгай шатаалтыг механикжсан технологиор солих замаар модны нүүрсний үйлдвэрлэлийн метан ялгаралтыг арилгах		2007.11.02	0
	БАЖ-III.К.	2	Хяналттай пиролизыг нэвтрүүлэх замаар биомассын ялзралаас үүсэх метаны ялгаралтыг арилгах		2007.08.10	0
	БАЖ-III.П.	1	Хөдөө аж ахуйн үйл ажиллагаанаас ялгарах метаныг өрх, жижиг фермийн түвшинд хураах		2007.10.19	0

Түлхүүр үгт тулгуурласан ангиллыг зохиогчид хийсэн бөгөөд НҮБҮӨСК баримт бичигт дурдагдаагүй болно.

Заавар\*: Батлагдсан аргачлалд ашиглагдах аргачлалын зааврууд. Хавсралт 2-оос зааврын оноосон нэрийг харна уу.

Бүрт\*: Жагсаалтанд орсон аргачлал (өмнөх болон сольсон хувилбаруудыг оролцуулан)-ыг ашиглан 2008.1.31-ны байдлаар бүртгүүлсэн ЦХМ

**Хавсралт 3. Батлагдсан аргачлал**

Түлхүүр үг	Тоот	Хув.	Батлагдсан аргачлалын нэр	Заавар*	Хүчинтэй болох хугацаа	Бүрт
N <sub>2</sub> O	БАр0021	2	Адипийн хүчил үйлдвэрлэлээс гарах азотын хүчлийн задралын суурь өгөгдлийн аргачлал	5,6	2007.12.14	4
	БАр0028	4.1	Азотын хүчил болон Капролактамын үйлдвэрийн хаягдал хийнд агуулагдах азотын хүчлийг катализатороор задлах	1	2006.12.22	10
	БАр0034	2	Азотын хүчлийн үйлдвэрлэлийн аммиак шатаах зуухан дахь азотын хүчлийг катализатороор багасгах	1	2006.11.02	8
	БАр0051	2	Азотын хүчлийн үйлдвэрт азотын хүчлийг хоёрдугаар шатны катализатороор задлах нь	1	2007.11.02	0
HFCs, PFCs, SF <sub>6</sub>	БАр0001	5.2	HFC23 хаягдал хийг шатааж устгах нь		2006.12.22	17
	БАр0030	2	Хөнгөн цагааны хайлшны үйлдвэрлэл дэх анодын үйлчлэлийг бууруулах замаар Перфторт нүүрстөрөгчийн ялгаралтыг бууруулах нь	1	2007.12.14	0
	БАр0035	1	Цахилгаан түгээлтийн сүлжээн дэх SF <sub>6</sub> -н ялгаралтын бууралт	1	2006.09.29	0
	БАр0059	1	Хөнгөн цагааны хайлшны үйлдвэрлэл дэх ХүХ -ийн ялгаралтыг бууруулах нь	2,4,5	2007.10.19	0
	БАр0065	1	Магнийн үйлдвэрлэлийн салбарт ашиглагдаж буй SF <sub>6</sub> -ийг алтернатив хийгээр орлуулах	2	2008.02.01	0
	БАЖ-III.N.	2	<i>Хатуулаг полиуретан хөөс үйлдвэрлэлтээс үүсэх ус фторт нүүрстөрөгчийн ялгаралтыг арилгах</i>		2007.08.10	0

Түлхүүр үгт тулгуурласан ангиллыг зохиогчид хийсэн бөгөөд НҮБҮӨСК баримт бичигт дурдагдаагүй болно.  
 Заавар\*: Батлагдсан аргачлалд ашиглагдах аргачлалын зааврууд. Хавсралт 2-оос зааврын оноосон нэрийг харна уу.  
 Бүрт\*: Жагсаалтанд орсон аргачлал (өмнөх болон сольсон хувилбаруудыг оролцуулан)-ыг ашиглан 2008.1.31-ны байдлаар бүртгүүлсэн ЦХМ төслийн нийт тоо.

**Хавсралт 3. Батлагдсан аргачлал**

Түлхүүр үг	Тоот	Хув.	Батлагдсан аргачлалын нэр	Заавар*	Хүчинтэй болох хугацаа	Бүрт
Ойжуулалт, ой нөхөн сэргээлт	ОНС-БАр0001	2	Элэгдэлд орсон газар нутгийн ойг нөхөн сэргээх	3	2006.05.19	1
	ОНС-БАр0002	1	Элэгдэлд орсон газар нутгийг ойжуулах, ой нөхөн сэргээх замаар сэргээх	3	2006.05.19	0
	ОНС-БАр0003	3	Мод суулгах, байгалийн сэргэлтийг дэмжих, мал бэлчихийг хязгаарлах замаар элэгдсэн газар нутгийг ойжуулах, ой нөхөн сэргээх	3	2007.12.14	0
	ОНС-БАр0004	2	Хөдөө аж ахуйд ашиглагдаж буй газар нутгийг ойжуулах, ой нөхөн сэргээх	3	2007.12.14	0
	ОНС-БАр0005	1	Үйлдвэрлэл болон арилжааны зорилгоор ойжуулах, ой нөхөн сэргээх төслийн үйл ажиллагаа	3	2006.12.22	0
	ОНС-БАр0006	1	Элэгдэлд орсон газар нутгийг бут сөөгөөр дэмжин, мод суулгах замаар ойжуулах, ой нөхөн сэргээх	3	2007.12.16	0
	ОНС-БАр0007	2	Газар тариалан, бэлчээрийн зорилгоор ашиглагдаж буй газар нутгийг ойжуулах, ой нөхөн сэргээх	3	2007.12.14	0
	ОНС-БАр0008	2	Мод бэлтгэлд тогтмол ашиглагдаж буй газар нутгийг ойжуулах, ой нөхөн сэргээх	3,9	2007.12.14	0
	ОНС-БАр0009	2	Талхлагдсан газрыг бэлчээрийн зориулттай болгон ойжуулах, ой нөхөн сэргээх	3,9,11,12,13	2007.12.14	0
	ОНС-БАр0010	2	Улсын нөөц болон хамгаалалттай бүс нутагт байрлах, зохион байгууллалтанд ороогүй бэлчээрийг ойжуулах, ойг нөхөн сэргээх	3,9,11,12,13	2007.12.14	0
	ОНС-БАЖ0001	4.1	<i>ЦХМ-ын дагуу бэлчээр болон тарилангийн талбайд хэрэгжүүлж буй ойжуулалт, ой нөхөн сэргээх жижиг төслийн суурь өгөгдөл, хяналт шинжилгээний хялбарчилсан аргачлал</i>	14	2007.08.10	0
	ОНС-БАЖ0002	1	<i>Суурин газарт хэрэгжиж буй ЦХМ-ын ойжуулалт, ой нөхөн сэргээх жижиг төслийн суурь өгөгдөл, хяналт шинжилгээний хялбарчилсан аргачлал</i>	14	2007.12.14	0
	ОНС-БАЖ0003	1	<i>ЦХМ-ын дагуу намаг дээр хэрэгжиж буй ойжуулалт, ой нөхөн сэргээх жижиг төслийн суурь өгөгдөл, хяналт шинжилгээний хялбарчилсан аргачлал</i>	14	2007.12.14	0

Түлхүүр үгт тулгуурласан ангиллыг зохиогчид хийсэн бөгөөд НҮБҮӨСК баримт бичигт дурдагдаагүй болно.  
 Заавар\*: Батлагдсан аргачлалд ашиглагдах аргачлалын зааврууд. Хавсралт 2-оос зааврын оноосон нэрийг харна уу.  
 Бүрт\*: Жагсаалтанд орсон аргачлал (өмнөх болон сольсон хувилбаруудыг оролцуулан)-ыг ашиглан 2008.1.31-ны байдлаар бүртгүүлсэн ЦХМ төслийн нийт тоо.



Энэ нь нэмэгдэл чанарыг батлах, үнэлэх суурь арга бөгөөд олон төрлийн төсөлд ашиглагдах боломжтой. Төсөл тус бүрийн онцлогийн дагуу зохих өөрчлөлтийг оруулах шаардлага гарч болно.

Нэмэгдэл чанарыг үнэлэх энэхүү аргыг ашиглах нь, хамгийн үнэмшилтэй суурь хувилбарыг сонгож, тайлбарлах шатлал бүхий суурь өгөгдлийн аргачлал ашиглах шаардлагыг орлохгүй.

Төсөлд оролцогчид (ТО) нэмэгдэл чанарыг батлах өөр аргыг ГЗ-д санал болгож болно.

### Алхам 1. Одоогийн хууль тогтоомжтой нийцэх, төслийн үйл ажиллагааны бусад хувилбарыг тодорхойлох

#### *Дэд алхам 1а. Төслийн үйл ажиллагааны бусад хувилбарыг тодорхойлох:*

- ☞ Санал болгож буй ЦХМ төслийн үйл ажиллагаатай ижил төстэй бүтээгдэхүүн, үйлчилгээ бий болгох, ТО эсвэл төсөл боловсруулагчид хэрэгжүүлэх боломжтой, биелэгдэхүйц, үнэмшилтэй хувилбаруудыг тодорхойлно.

#### *Дэд алхам 1б. Холбогдох хууль тогтоомжийг биелүүлэх:*

- ☞ Альтернатив хувилбар нь заавал биелүүлэх хууль эрх зүйн заалтуудад нийцсэн байна. Хэрэв зарим заалтанд нийцэхгүй байвал, тэдгээр нь төдийлөн мөрдөгддөггүй болохыг харуулна;
- ☞ Хэрэв санал болгож буй төслийн үйл ажиллагаа нь ТО-н судалсан бүхий л хувилбаруудаас заавал биелүүлэх, тогтмол мөрдөгддөг хууль эрх зүйн заалтуудтай нийцсэн цорын ганц хувилбар бол түүнийг нэмэгдэл хэмээн үзэхгүй.

### Дээрх нөхцөлүүдийг хангавал

Алхам 2, эсвэл 3, эсвэл 2 болон 3-ын аль алинд шилжинэ.

### Алхам 2. Хөрөнгө оруулалтын дүн шинжилгээ

Санал болгож буй төслийн үйл ажиллагааны хувьд ЯББ-ын арилжааны орлогогүй байвал, алхам 1-д тодорхойлсон 1-ээс цөөнгүй хувилбартай харьцуулахад эдийн засаг болон санхүүгийн хувьд үр ашиг муутай эсэхийг тогтооно

#### *Дэд алхам 2а. Дүн шинжилгээний зохимжтой аргыг тодорхойлох :*

- ☞ Хэрэв ЦХМ төслийн үйл ажиллагаа нь ЦХМ-тай холбоотой орлогоос өөр санхүү, эдийн засгийн үр ашгийг бий болгохгүй байвал дүн шинжилгээний энгийн өртөг тооцох арга (Сонголт I)-г ашиглана. Бусад тохиолдолд хөрөнгө оруулалтын харьцуулалт (Сонголт II) эсвэл жишгийн дүн шинжилгээ (Сонголт III)-г ашиглана.

#### *Дэд алхам 2б.*

##### *Сонголт I. Энгийн өртгийн тооцоо*

- ☞ ЦХМ төслийн үйл ажиллагааны өртгийг баримтжуулж, ЦХМ-тай холбоотой орлогоос өөр эдийн засгийн үр ашиг бий болохгүйг харуулна.

##### *Сонголт II. Хөрөнгө оруулалтын харьцуулалт*

- ☞ Төслийн төрөл болон шийдвэр гаргахад хамгийн тохиромжтой өөрийн ашгийн түвшин (IRR), одоогийн цэвэр үнэлэмж (NPV), өртөг ашгийн харьцаа, үйлчилгээний нэгж өртөг зэрэг санхүүгийн үзүүлэлтүүдийг тодорхойлно.

##### *Сонголт III. Жишгийн дүн шинжилгээ*

- ☞ Санхүүгийн хүчин зүйл болон холбогдох жишгийг тодорхойлно. Жишгийг төрийн бондын хүү, санхүүгийн өртгийн тооцоо, хөрөнгийн ашгийн байвал зохих түвшин болон компанийн дотоод жишиг зэрэгт тулгуурлан төлгөөно.

#### *Дэд алхам 2в. Санхүүгийн үзүүлэлтүүдийг тооцох, харьцуулах (зөвхөн сонголт II, III-д хамаарна):*

- ☞ ЦХМ-ТББ-д санал болгож буй ЦХМ үйл ажиллагааны санхүүгийн үзүүлэлтүүдийг (ЯББ-ын орлогоос бусад) дараахь аль нэг хувилбарын хамт танилцуулна:
  - ⇒ Сонголт II бол альтернатив хувилбарын тухайн үзүүлэлтүүд, Сонголт III бол санхүүгийн жишиг. Хэрэв ЦХМ төслийн үйл ажиллагааны үзүүлэлтүүд илүү муу байвал ЦХМ төслийн үйл ажиллагааг санхүүгийн хувьд тааламжтай хэмээн үзэх боломжгүй.

#### *Дэд алхам 2г. Хэлбэлзлийн судалгаа (зөвхөн сонголт II болон III-д хамаарна):*

- ☞ Хэлбэлзлийн судалгаа хийн, үндсэн таамаглалд гарах өөрчлөлтүүд хийсэн дүгнэлтэд ноцтой нөлөөлөх эсэхийг харуулна. Хөрөнгө оруулалтын шинжилгээг төслийн үйл ажиллагааны хүрээнд хэдий ч ЦХМ тооцоот хугацаанд баригдуулахгүй гээр гүйцэтгэх ёстойг ГЗ-ийн тодруулан зөвшөөрсөн болно. [ГЗ 35 Rep хэс77]

### Алхам 3. Саадын дүн шинжилгээ

Санал болгож буй төслийн үйл ажиллагааны хэрэгжилтэнд саад учирч буй эсэх болон уг төсөл хэрэгжсэнээр бусад нэгээс цөөнгүй хувилбарын хэрэгжилтэд саад болохгүй гэдгийг тогтооно. Тогтоосон саад болон түүний цар хүрээг ил тод, баталгаатай нотлох баримтаар тайлбарлана. Хэрэв ЦХМ нь, санал болгож буй төслийн үйл ажиллагааны хэрэгжилтэд учрах саад бэрхшээлийг арилгаж чадахгүй байвал, уг төслийн үйл ажиллагааг нэмэгдэл гэж тооцохгүй.

#### ***Дэд алхам 3а. Санал болгож буй төрлийн төслийн үйл ажиллагааны хэрэгжилтэд учрах саадыг тодорхойлох:***

☞ Санал болгож буй төслийн үйл ажиллагааг ЦХМ-д бүртгэхгүй бол уг төсөл хэрэгжихгүй байх бодит, үнэмшилтэй саад байгааг тодорхойлно. Ийм саад нь, Алхам 2-оор тодорхойлсон эдийн засаг/санхүүгийн саад бэрхшээлээс гадна хөрөнгө оруулалт, технологи, тогтсон горимын зэрэг саад байж болно.

#### ***Дэд алхам 3б. Тухайн саад нь (санал болгож буй төслийн үйл ажиллагаанаас бусад) нэгээс цөөнгүй хувилбарын хэрэгжилтэд саад учруулахгүйг харуулах***

☞ Хэрэв тухайн саад нь бусад хувилбарт нөлөөлөх бол, үр нөлөө нь санал болгож буй ЦХМ төслийн үйл ажиллагаанд үзүүлэх нөлөөнөөс сул болохыг тайлбарлана.

Дээрх нөхцөл хангагдвал

### Алхам 4. Тогтсон горимын дүн шинжилгээ

Нэмэгдэл чанарын дээрх ерөнхий шалгуураас гадна санал болгож буй төслийн төрөл нь холбогдох салбар болон бүс нутагт хэрхэн нэвтэрсэн талаар судалсан дүн шинжилгээ хийнэ. Энэ нь хөрөнгө оруулалт (Алхам 2) болон саад (Алхам 3)-ын дүн шинжилгээг орлох шалгуур болно.

#### ***Дэд алхам 4а. Санал болгож буй төсөлтэй ижил төстэй үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх:***

☞ Санал болгож буй төслийн үйл ажиллагаатай ижил төстэй, урьд өмнө эсвэл одоо хэрэгжиж буй бусад үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийнэ. Үүнд бусад ЦХМ төслийн үйл ажиллагааг хамруулахгүй.

#### ***Дэд алхам 4б. Одоогоор хэрэгжиж буй ижил төстэй бусад сонголтуудыг авч үзэх:***

☞ Хэрэв дээрх ижил төстэй үйл ажиллагаа байгаа бол, тэдгээр нь санал болгож буй төслийн үйл ажиллагаа нь санхүүгийн хувьд тааламжгүй эсвэл саадаар хязгаарлагдсан гэсэн байр суурийг ямар учраас үгүйсгэхгүй болохыг тайлбарлах шаардлагатай.

Дээрх нөхцөл хангагдвал

**Санал болгож буй ЦХМ төслийн үйл ажиллагаа нэмэгдэл чанартай болно.**

## Хавсралт 5. Цахилгаан эрчим хүчний системийн ялгаралтын факторыг тооцоолох заавар

(Хув 01)[ГЗ 35 Х12]

### Хамрах хүрээ болон хэрэглэгдэх нөхцөл

- ◆ Энэ зааврыг нэгдсэн сүлжээнээс хангагдах цахилгаан эрчим хүчийг орлох төслийн үйл ажиллагааны суурь ялгаралтыг тооцоход зориулагдсан estimate the CO<sub>2</sub> ялгаралтын факторыг тодорхойлох зориулалтаар мөн ашиглаж болно. ө.х:
  - ☞ Төслийн үйл ажиллагаа нь нэгдсэн сүлжээнд цахилгаан эрчим хүч нийлүүлж байгаа эсвэл,
  - ☞ Төслийн үйл ажиллагаа нь нэгдсэн сүлжээгээр хангагдаж буй цахилгаан эрчим хүчийг хэмнэхэд нөлөөлж байгаа (ө.х. Хэрэглэгч талын эрчим хүчний үр ашгийг нэмэгдүүлэх төслүүд).
- ◆ төслийн үйл ажиллагаа нь нэгдсэн сүлжээнээс цахилгаан эрчим хүч хэрэглэж байгаа эсвэл төслийн хил хязгаараас гадна байрлах нэгдсэн сүлжээнээс авч буй цахилгаан эрчим хүчний хэрэглээ ихсэж буй тохиолдлуудад төслийн болон алдагдлын ялгаралтыг тооцоолоход зориулагдсан “Цахилгаан эрчим хүчний хэрэглээний төслийн ялгаралтыг тооцоолох заавар”-т энэхүү зааврыг мөн тусгасан байгаа гэдгийг анхаарна уу.
- ◆ Энэ заавар нь дараах гурван параметрийг (нэгж: т-CO<sub>2</sub>/МВт с (нэгж: т-CO<sub>2</sub>/МВтц) тодорхойлоход зориулагдсан болно:

ЯФ <sub>Үд,у</sub>	у жилийн хувьд нэгдсэн сүлжээнд холбогдсон эрчим хүч үйлдвэрлэлийн CO <sub>2</sub> ялгаралтын факторын үйл ажиллагааны дундаж (ҮД)	ҮД - санал болгож буй ЦХМ төслийн үйл ажиллагаа цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлд нь нөлөөлөх одоо ашиглалтанд станцуудын багцыг хэлнэ.
ЯФ <sub>Сд,у</sub>	у жилийн хувьд нэгдсэн сүлжээнд холбогдсон эрчим хүч үйлдвэрлэлийн CO <sub>2</sub> ялгаралтын факторын суурилагдсан дундаж (СД)	СД -Санал болгож буй ЦХМ төслийн үйл ажиллагаа барилгын ажилд нь нөлөөлөх тийм эрчим хүчний нэгжийн төрлийн багцыг хэлнэ .
ЯФ <sub>Хд,у</sub>	у жилийн хувьд нэгдсэн сүлжээнд холбогдсон эрчим хүч үйлдвэрлэлийн CO <sub>2</sub> ялгаралтын факторын холимог дундаж (ХД) $ЯФ_{Хд,у} = ЯФ_{Үд,у} \times w_{Сд} + ЯФ_{grid,Сд,у} \times w_{Сд} \quad (w_{Үд} + w_{Сд} = 1)$	

### Суурь өгөгдлийн аргачлалын дэс дараалал

[Алхам 1. Холбогдох цахилгаан эрчим хүчний системийг тодорхойлох](#)

[Алхам 2. Үйл ажиллагааны дундаж \(ҮАД\) аргыг method](#)


[Алхам 3. Сонгосон аргын дагуу үйл ажиллагааны дундаж \(ҮАД\) ялгаралтын факторыг тооцоолох](#)

[Алхам 4. Суурилагдсан дундажад \(СД\) хамрагдах ёстой эрчимх үчний нэгжүүдийг тодорхойлох](#)

[Алхам 5. Суурилагдсан дундаж \(СД\)-ийн ялгаралтын факторыг тооцоолох](#)

[Алхам 6. Холимог дундаж \(ХД\)-ийн ялгаралтын факторыг тооцоолох](#)

Алхам 1. Холбогдох цахилгаан эрчим хүчний системийг тодорхойлох



- ♦ Хэрвээ хүлээн авагч улсын ТҮН төслийн цахилгаан эрчим хүчний систем болон холбогдсон цахилгаан эрчим хүчний системүүдийн талаар схем хэвлэн гаргасан бол эдгээр схемийг мөрдөнө.
- ♦ Хэрвээ ийм схем байхгүй бол, ТО нь төслийн цахилгаан эрчим хүчний систем болон холбогдсон ямарваа цахилгаан эрчим хүчний системийг тус тус тодорхойлж, ЦХМ-ТББ дээрхи эдгээрийн талаархи ойлголтыг магадлан, баримтжуулах хэрэгтэй. Үүний тулд дараахь шалгууруудын тусламжтайгаар дамжуулалтын мэдэгдэхүйц бэрхшээл байгаа эсэхийг тодорхойлж болно:
  - ☞ Цахилгаан эрчим хүчний spot зах зээл бүхий цахилгаан эрчим хүчний системийн хувьд : тухайн жилийн цагийн 60 болон түүнээс дээш хувьд системүүдийн цахилгаан эрчим хүчний үнийн ялгаа нь 5 % (дамжуулалт, түгээлтийн зардалыг оролцуулахгүйгээр)-аас давсан тохиолдолд.
  - ☞ Тухайн жилийн цагийн 90 болон түүнээс дээш хувьд дамжуулалтын шугам ашиглагдах хүчин чадлынхаа 90 болон түүнээс дээш хувьд ажиллаж буй тохиолдолд.
- ♦ Эдгээр шалгуурууд нь нэгдсэн сүлжээний хил хязгаарын ойлгомжтой байдалд нөлөөлөхгүй байгаа тохиолдолд, үелсэн диспетчерийн системтэй (ө.х. аймгийн / бүсийн / үндэсний) томоохон улсууд нь бүсчилсэн нэгдсэн сүлжээний тодорхойлолтыг мөрдвөл зохино. Аймаг хооронд явагдаж буй тухайн цахилгаан эрчим хүчний худалдаанд ЦХМ төслийн үйл ажиллагаа шууд болон шууд бусаар нөлөөлж болох тул аймгийн нэгдсэн сүлжээний тодорхойлолтыг мөрдөх нь ихэнхи тохиолдолд хэтэрхий нарийвчилсан байж болох хандлагатай. Бусад улсуудын хувьд үндэсний (эсвэл хамгийн том) сүлжээний тодорхойлолтыг үндсэн зарчим болгон ашиглах нь зүйтэй.

Үйл ажиллагааны дундаж (ҮД) ялгаралтын факторыг тооцох

- ☞ Нэгэн адил хүлээн авагч улс доторхи холбогдсон цахилгаан эрчим хүчний системээс авч буй цахилгаан эрчим хүчний цэвэр импортын  $(EF_{grid,import,y})$  CO<sub>2</sub> ялгаралтын факторыг тодорхойлохд дараахь хэд хэдэн хувилбарын аль нэгийг ашигла :
  - ⇒ (a) 0 т-CO<sub>2</sub>/МВтц, эсвэл
  - ⇒ (б) Алхам 3 (г) –д заасны дагуу тодорхойлсон экспортын нэгдсэн сүлжээний үйл ажиллагааны жигнэсэн дундаж ялгаралтын түвшин; эсвэл (г) Алхам 3 (а)-д заасны дагуу тодорхойлсон экспортын нэгдсэн сүлжээний үйл ажиллагааны энгийн дундаж CO<sub>2</sub> ялгаралтын түвшин, хэрвээ энэ аргын нөхцлүүд алхам 2-т заасан байвал экспортын сүлжээний хувьд хэрэглэ; эсвэл
  - ⇒ (d) Доорхи алхам 3 (б)-д заасны дагуу тодорхойлсон экспортын нэгдсэн сүлжээний ялгаралтын түвшингийн энгийн тодотгосон үйл ажиллагааны дундаж .
- ☞ Өөр хүлээн авагч улсад байрлалтай холбогдсон цахилгаан эрчим хүчний системээс авч буй импортын хувьд ялгаралтын фактор нь нэг МВтц тутам 0 т CO<sub>2</sub>. Цахилгаан эрчим хүчний экспортыг цахилгааны эрчим хүчний ялгаралтыг тооцох, хянахад ашигласан цахилгаан эрчим хүч үйлдвэрлэлийн тоо хэмжээнээс хасч болохгүй.

Суурилагдсан дундаж (СД) ялгаралтын факторыг тодорхойлох тохиолдолд

- ☞ Түгээлтийн системд сүүлийн үед болон ойрын ирээдүйд хийгдэх өргөтгөлүүд цахилгаан эрчим хүчний импортыг үлэмж нэмэгдүүлэхээс бусад тохиолдолд орон зайн хувьд төслийн эрчим хүчний систем нь хязгаарлмагдал болно. Ийм тохиолдолд , дамжуулалтын хүчин чадлыг суурилагдсан дундаж эх үүсвэрт тооцохыг зөвшөөрнө.

**Алхам 2. Үйл ажиллагааны дундаж (ҮД) аргыг сонгох**

- ◆ Үйл ажиллагааны дундаж ялгаралтын факторын ( $ЯФ_{\text{ҮД},y}$ ) тооцоо нь дараахь 4 аргын аль нэгэнд тулгуурласан бөгөөд эдгээрийн алийг нь ч (арга болгоны талаар Алхам 3-т дэлгэрэнгүй заасан) үндсэндээ ашиглаж болно.
- ◆ Сонгосон өгөгдлийн төрлийг ЦХМ-ТББ-д заавал баримтжуулан үлдээх ёстой бөгөөд тооцоот хугацааны туршид ямарваа өөрчлөлт хийж болохгүй.
- ◆ Хэрвээ эрчим хүчний эх үүсвэрийн ижил түүврийн бүлэгт шалгуур тохирч байгаа бол ЦХМ-д бүртгэгдсэн станцууд нь үйл ажиллагааны дундажийг тооцоолоход ашиглагдаж буй түүврийн бүлэгт багтсан байх ёстой.



**Энгийн ҮД аргыг** зөвхөн бага өртөгт/ өртөгт/зайлшгүй ашиглах нөөц нь төвлөрсөн сүлжээний нийт гарцын 50%-аас бага хувийг эзэлж буй тохиолдолд ашиглана. Үүнийг дараахь хэлбэрээр тодорхойлох хэрэгтэй:

- ☞ 1) хамгийн сүүлийн 5 жилийн дундажаас харахад, эсвэл
- ☞ 2) усан цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлийн олон жилийн дундажид тулгуурлан.

⇒ Бага өртөгт/зайлшгүй ашиглах нөөц гэдэг нь харьцангуй бага нэмэлт үйл ажиллагаатай зардалтай эсвэл нэгдсэн сүлжээний өдрийн эсвэл улирлын ачааллыг бие даан түгээдэг станцуудыг хэлнэ. Үүнд ихэвчлэн усан, гео-дулаан, салхийн, бага өртөгт биомасс, атомын болон наран станцууд хамрагдана. Хэрвээ нүүрс зайлшгүй ашиглагдах ёстой, эдгээр төрлийн станцыг мөн энэ жагсаалтанд оруулан тооцож болно.

**ҮД “”ийн түгээлтийн мэдээний шинжилгээний** хувьд төслийн үйлдвэрлэл төвлөрсөн цахилгаан эрчим хүчийг орлож байгаа тухайн жилийг ашиглан, ялгаралтын факторыг жилийн туршид хяналт хийх болгон сунгах хэрэгтэй.

**Энгийн ҮД, энгийн тодотгосон ҮД, дундаж ҮД-ийн хувьд** ялгаралтын факторыг дараахь 2 төрлийн өгөгдлийг ашиглан тооцоолж болно:

- ☞ **Урьдчилан хувилбар:** тооцоот хугацааны туршид ялгаралтын факторыг хянаж, дахин тооцоолох шаардлагагүй ТББ-г өргөн мэдүүлэх үед мэдэгдэж байгаа сүүлийн 3 жилийн нийт үйлдвэрлэлийн жигнэсэн дундаж хэмжээ, эсвэл
- ☞ **Ex post (гүйцэтгэлийн дараах) хувилбар:** Хэрэв ЯФ хяналт шинжилгээгээр сунгах бол төслийн үйлдвэрлэл явагдсан жил. Хэрвээ у жилийн ялгаралтын факторыг тооцоолоход шаардлагатай өгөгдөл нь у жилийн эцсээс хойш 6 сараас дээш хугацааны дараа л тодорхой болдог бол өмнөх жилийн ( $y-1$ ) ялгаралтын факторыг ашиглаж болно. Хэрвээ у жилийн эцсээс хойш 18 сарын дараа ихэвчлэн уг өгөгдөл бэлэн болдог бол, өмнөхийн өмнөх жилийн ( $y-2$ ) ялгаралтын факторыг мөн ашиглаж болно. Эдгээр тохиолдолд, харгалзах ижил өгөгдлийн төрлийг ( $y, y-1$  эсвэл  $y-2$ ) бүх тооцоот хугацааны туршид ашиглах ёстой.

## Хавсралт 5. Цахилгаан эрчим хүчний системийн ялгаралтын факторыг тооцох заавар

### Алхам 3. Сонгогдсон аргын (1/2) дагуу үйл ажиллагааны дундаж (ҮД) ялгаралтын факторыг тооцох нь

#### (а) Энгийн ҮД

◆ Энгийн ҮД ялгаралтын факторыг сүлжээнд эрчим хүч нийлүүлэх үйлдвэрлэлийн нэг жилд үйлдвэрлэх эрчим хүчний нэгжид оногдох, жигнэсэн дундаж үйлдвэрлэлийн ялгаралтын хэмжээгээр  $[t\text{-CO}_2/\text{МВтцаг}]$  тодорхойлно. Үүнд бага өртөгт/зайлшгүй ашиглах нөөцөд түшиглэсэн станцуудыг оруулахгүйгээр харин импортыг тооцон тодорхойлно. Дараах маягаар тооцож болно:

☞ **Хувилбар А:** Эрчим хүчний эх үүсвэр бүрийн түлшний хэрэглээ болон цэвэр цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлийн мэдээлэлд тулгуурлан

☞ **Хувилбар Б:** Эрчим хүчний эх үүсвэр нэгж бүрийн цэвэр цахилгаан эрчим хүч үйлдвэрлэл, дундаж үр ашиг болон нэгж бүрийн ашигласан түлшний төрлийн мэдээлэл ашиглан (мэдээлэл авах 3 дэд хувилбар байна)

⇒ **Хувилбар Б1:** Эрчим хүчний нэгжийн түлшний хэрэглээ болон цахилгаан эрчим хүч үйлдвэрлэлийн хэмжээ мэдэгдэж байгаа нөхцөл

⇒ **Хувилбар Б2:** Эрчим хүчний нэгжийн цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэл болон ашигласан түлшийн хэмжээ зөвхөн мэдэгдэж байгаа бөгөөд ялгаралтын факторыг ашигласан түлшний төрлийн  $\text{CO}_2$  ялгаралтын фактор болон тухайн нэгжийн үр ашгийг тодорхойлох шаардлагатай нөхцөл

⇒ **Хувилбар Б3:** Эрчим хүчний нэгжийн цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэл зөвхөн мэдэгдэж байгаа бөгөөд  $0 t\text{CO}_2/\text{МВтцаг}$  –ийн ялгаралтын факторыг энгийн, уламжлалт аргаар тодорхойлж болох нөхцөл.

☞ **Хувилбар В:** Сүлжээнд эрчим хүч нийлүүлэх бүх эх үүсвэрийн цэвэр нийт цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлийн хэмжээ, түлшний төрөл болон төслийн эрчим хүчний системийн түлшний хэрэглээнд үндэслэн .

◆ **Хувилбар А** -г эрчим хүчний эх үүсвэрийн хувьд мэдээлэл бэлэн байгаа тохиолдолд ашиглах ёстой. Бусад тохиолдолд, **хувилбар Б** эсвэл **В** –ийг ашиглавал зохино. Энгийн ҮД-ийг тооцоолох тохиолдолд, хувилбар А,Б-д шаардлагатай мэдээлэл олдохгүй тохиолдолд л зөвхөн **Хувилбар В**-ийг хэрэглэх хэрэгтэй. Мөн атомын болон сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэл нь бага өртөгт /зайлшгүй ашиглах нөөцөд тооцогдож байгаа, эдгээр эх үүсвэрээс нэгдсэн сүлжээнд нийлүүлсэн цахилгаан эрчим хүчний хэмжээ нь мэдэгдэж байгаа тохиолдолд ашиглаж болно.


#### (б) Энгийн тодотгосон ҮД

◆ Энгийн тодотгосон ҮД ялгаралтын фактор нь энгийн ҮД-ийн нэг төрөл бөгөөд эрчим хүчний эх үүсвэрүүд (импортыг оролцуулан) нь бага өртөгт/зайлшгүй ашиглах нөөц эх үүсвэр болон бусад эх үүсвэрээр ангилагдсан болно.

◆ **Энгийн ҮД-тай адил**, it can be calculated by **рХувилбар А** эсвэл **Б**-ээр мөн тооцож болно (зүүн талыг харна уу). Мэдээлэл бэлэн байгаа тохиолдолд л зөвхөн **Хувилбар А** –г ашиглах хэрэгтэй. Бусад тохиолдолд, **хувилбар Б**-ийг ашиглавал зохино. Хувилбар В нь энгийн тодотгосон ҮД-д тохиромжгүй.

#### Энгийн тодотгосон ҮД-ийн $\lambda$ -ийг тооцох нь

(i) **Ачааллын үргэлжлэх хугацааны муруйг зур.** Нэг жилийн цаг тутмын ачааллын мэдээллийг цуглуулж, МВт-ын ихээс бага руу нь жагсаана. МВт-ыг жилийн 8760 цагаар ихээс бага руу нь графикаар зурна



(iv)  $\lambda$  жилийн дундаж болох бага өртөгт/зайлшгүй ашиглах нөөцийн ажиллах цаг"-ийг тодорхойл. Эхлээд, алхам (iii) зурагдсан хөндлөн шугам болон алхам(i) -д зурагдсан ачааллын үргэлжлэх хугацааны муруй огтлолцох цэгийг ол. Огтлолын цэгийн баруун талд байрлах цагийн хэмжээ нь (нийт 8760 цагийн дотор) бага өртөгт/зайлшгүй ашиглах нөөц дундаж байх нийт цагийг илтгэнэ. Хэрвээ дээрхи шугамууд огтлолцохгүй бол бага өртөгт/зайлшгүй ашиглагдах нөөц нь дундаж биш бөгөөд  $\lambda$  нь тэгтэй тэнцэнэ гэсэн дүгнэлт гаргаж болно.

**Алхам 3. Үйл ажиллагааны дундаж (ҮД) ялгаралтын факторыг сонгогдсон аргаар (2/2)**

**тодорхойлох нь**

**(в) Түгээлтийн ҮД**

◆ Түгээлтийн ҮД ялгаралтын факторыг төслийн үйлдвэрлэлээр цахилгаан эрчим хүч нийлүүлж буй цаг тутамд түгээсэн эрчим хүчний эх үүсвэрт тулгуурлан тодорхойлно. Түгээлтийн хэмжээний эрэмбийн хамгийн эхэнд байгаа эрчим хүчний эх үүсвэр нэгжүүдийн багцыг үндэсний диспетчерийн газарт хандан олж ав.:

(i) Цахилгаан эрчим хүч импортлогч эх үүсвэр зэрэг сүлжээн дэх эрчим хүчний эх үүсвэр бүрийн ажиллагааны түгээлтийн үүрэг, болон

☞ Төслийн үйл ажиллагаа цахилгаан эрчим хүчийг нийлүүлж буй цаг тутамд сүлжээн дэх эрчим хүчний бүх эх үүсвэрээс түгээсэн эрчим хүчний хэмжээ (МВт)

◆ Цахилгаан станц буюу эрчим хүчний эх үүсвэр бүрийн эрчим хүч үйлдвэрлэл  $h$  цаг тутамд эрэмблэгдэж байдаг. Түгээлтийн дундажийн эрчим хүчний нэгжийн багцанд  $h$  цагт түгээгдсэн нийт цахилгаан эрчим хүчний  $x$  % дахь нэгжүүд багтах бөгөөд  $x$  % нь:

☞ (a) 10%-тай тэнцүү буюу их байна; эсвэл

☞ (b) төсөл  $h$  цагийн туршид түгээсэн цахилгаан эрчим хүчний хэмжээг тухайн  $h$  цагийн туршид төвлөрсөн сүлжээнд үйлдвэрлэгдсэн нийт цахилгаан эрчим хүчний хэмжээнд хуваасантай тэнцэнэ.

◆ Энэ арга нь түүхэн өгөгдөлд тохиромжгүй тул жил бүр хяналт хийх хэрэгтэй.

☞ Хэрвээ цаг тутмын түлшний хэрэглээний хэмжээ мэдэгдэж байгаа бол цаг тутмын ялгаралтын факторыг эрчим хүчний эх үүсвэр бүрийн хувьд тодорхойл.

☞ Бусад тохиолдолд, цаг тутмын ялгаралтын факторыг тухайн эрчим хүчний эх үүсвэр нэгж бүрийн үр ашиг болон ашигласан түлшний төрөлд үндэслэн тооцоог хий.

◆ Эрчим хүчний нэгжийн  $\text{CO}_2$  ялгаралтын факторыг хувилбар Б1, Б2, Б3 хувилбаруудыг ашиглан энгийн ҮД зааврыг мөрдөн тодорхойлвол зүйтэй.

**(г) Дундаж ҮД**

◆ Дундаж ҮД ялгаралтын фактор нь сүлжээнд холбогдсон үйлдвэрлэлийн бүх эх үүсвэрүүдийн эрчим хүчний нэгжид оногдох дундаж ялгаралтын хэмжээ бөгөөд **энгийн ҮД** аргачлалын зааврын дагуу гэхдээ бүх томъёо, бага өртөгт/зайлшгүй ашиглах эрчим хүчний эх үүсвэрүүдийг оролцуулан тооцно.

◆ **Хувилбар А** -г эрчим хүчний эх үүсвэрийн хувьд мэдээлэл олдоцтой тохиолдолд ашиглана. Бусад тохиолдолд, **хувилбар Б** эсвэл **В** -ийг ашиглавал зохино. Хувилбар А, Б-д шаардлагатай мэдээлэл олдохгүй тохиолдолд л зөвхөн **Хувилбар В**-ийг хэрэглэх хэрэгтэй.

**Алхам 4. Суурилагдсан дундажид (СД) хамрагдах ёстой эрчим хүчний нэгжүүдийг тодорхойлох нь**

- ◆ Эрчим хүчний нэгжийн түүвэр бүлэг  $m$  нь дараахь эх үүсвэрүүдийн жилийн эрчим хүчний томоохон үйлдвэрлэлийн суурилагдсан дунждийг тооцоход ашиглагдана :
  - ☞ (а) Хамгийн сүүлд шинэчлэгдсэн таван эрчим хүчний нэгжийн багц эсвэл,
  - ☞ (б) Цахилгаан эрчим хүчний сүлжээний нийт үйлдвэрлэлийн (МВт цаг) 20%-ийг нийлүүлж буй, хамгийн сүүлд баригдсан эрчим хүчний хүчин чадлын нэмэгдэлийн багц.
    - ⇒ Хэрвээ 20% нь нэгжийн хүчин чадалд багтаж буй бол нэгжийг бүхэлд нь тооцоонд оруулна.
- ◆ Ерөнхий зааврын дагуу, эрчим хүчний нэгжийн баригдсан хугацаа гэдэг нь тухайн нэгж сүлжээнд цахилгаан эрчим хүч нийлүүлж эхэлсэн өдрийг хэлнэ.
- ◆ ЦХМ төсөлд бүртгэгдсэн эрчим хүчний станцууд нь түүврийн бүлэг  $m$ -д хамрагдахгүй. Харин, ЦХМ төсөлд бүртгэгдээгүй эрчим хүчний бүлэг СД ялгаралтын факторыг тодорхойлохдоо 10 ба түүнээс дээш жилийн өмнө баригдсан эрчим хүчний нэгжүүдийг хамруулсан бол:
  - ☞ (i) Уг бүлгээс 10 ба түүнээс дээш жилийн баригдсан эрчим хүчний нэгжүүдийг хасч,
  - ☞ (ii) ЦХМ төсөлд бүртгэгдсэн, цахилгаан эрчим хүчний төвлөрсөн сүлжээнд холбогдсон бөгөөд сүлжээнд түгээлтийн эрх бүхий байгууллагаар дамжуулан ханддаг (энэ мэдээллийг Хүлээн авагч улс гаргаж өгөх үүрэгтэй) эрчим хүчний төслүүдийг оронд нь хамруулах хэрэгтэй.
- ◆ СД ялгаралтын факторын тооцоонд станцуудын шинэчлэн сайжруулсан хүчин чадлын нэмэгдэлийг оруулж үл болно.
- ◆ Өгөгдлийн төрлийн хувьд, дараах 2 хувилбарын аль нэгийг сонгож болно:
  - ☞ **Хувилбар 1:** Эхний тооцоот хугацааны СД ялгаралтын фактор *ex-ante*-ийг ЦХМ-ТББ-ийг ҮТН-д хүргэн магадлуулахаар өгсөн барих үеийн  $m$  түүврийн бүлэгт аль хэдийн багтан орсон нэгжүүдийн хамгийн сүүлийн мэдээлэлд үндэслэн тооцоолно. Удаахь буюу 2-р тооцоот хугацааны СД ялгаралтын факторыг ЦХМ-ТББ-ийг ҮТН-д хандан, тооцоот хугацааг сунгах саналыг хүргүүлсэн үеийн  $m$  түүврийн бүлэгт аль хэдийн багтан орсон нэгжүүдийн хамгийн сүүлийн мэдээлэлд үндэслэн шинэчилнэ. 3-р тооцоот хугацааны СД ялгаралтын факторыг 2-р буюу өмнөх тооцоот хугацаанд ашигласан зааврын дагуу тооцоолно. Энэ тохиолдолд, тооцоот хугацааны ялгаралтын факторыг хянах шаардлагагүй.
  - ☞ **Хувилбар 2:** Эхний тооцоот хугацааны хувьд, төслийн үйл ажиллагаа бүртгэгдсэн жил баригдсан нэгжүүд болон уг бүртгэгдсэн жилийн хувьд мэдээлэл нь олдоцгүй байгаа боловч мэдээлэл нь олдож байгаа хамгийн сүүлийн жил баригдсан нэгжүүдийн СД ялгаралтын факторыг жил болгон шинэчлэн сайжруулах (*ex-post*) шаардлагатай. 2-р тооцоот хугацааны СД ялгаралтын факторыг **1-р хувилбарт** заасан *ex-ante*-тай адилаар тооцоолно. 3-р тооцоот хугацааны СД ялгаралтын факторыг 2-р тооцоот хугацаатай адил тодорхойлно.
- ◆ Сонгосон хувилбарын талаар ЦХМ-ТББ-д баримтжуулан үлдээх ёстой.

**Алхам 5. Суурилагдсан дундаж (СД) ялгаралтын факторыг тооцох арга**

- ◆ СД ялгаралтын фактор гэдэг нь эрчим хүчний үйлдвэрлэлийн хэмжээний мэдээлэл олдоцтой буйгаа хамгийн сүүлийн ужилийн туршид эрчим хүчний бүх нэгж  $m$ -ээс ялгарсан жигнэсэн дундаж ялгаралтын фактор ( $t\text{-CO}_2/\text{МВтцаг}$ ) -ыг хэлнэ.
- ◆  $m$  эрчим хүчний нэгж бүрийн  $\text{CO}_2$  ялгаралтын факторыг эрчим хүчний үйлдвэрлэлийн мэдээлэл олдож байгаа хамгийн сүүлийн жил болох  $y$  болон СД-д хамрагдсан эрчим хүчний нэгж болох  $m$ -ийг тус тус ашиглаж, **энгийн ҮД** ийн 3 (а) алхамыг мөрдөх замаар хувилбар **В1, В2**, эсвэл **В3**, - ийн дагуу тодорхойлох хэрэгтэй.



**Алхам 6. Холимог дундаж (ХД) ялгаралтын факторыг тооцох арга**

◆ Холимог дундаж (ХД) ялгаралтын факторыг дараахь байдлаар тооцож олно:

$$ЯФ_{ХД,у} = ЯФ_{УД,у} \times w_{УД} + ЯФ_{СД,у} \times w_{СД}$$

⇒ ЯФ<sub>СД,у</sub> = у жилийн СД CO<sub>2</sub> ялгаралтын фактор (т-CO<sub>2</sub>/МВтц), бөгөөд у жилийн ЯФ<sub>УД,у</sub> = УД CO<sub>2</sub> ялгаралтын фактор (т-CO<sub>2</sub>/МВтц)

⇒ w<sub>УД</sub> = үйл ажиллагааны дундаж ялгаралтын факторын эзлэх хувь (%), w<sub>СД</sub> = суурилагдсан дундаж ялгаралтын факторын эзлэх хувь (%)

◆ Дараахь үндсэн утгуудыг w<sub>УД</sub> болон w<sub>СД</sub> ашиглана :

☞ Салхин болон нарнаас эрчим хүч үйлдвэрлэх төслийн хувьд: эхний болон удаах тооцоот хугацаанд w<sub>УД</sub> = 0.75, w<sub>СД</sub> = 0.25 (үйлдвэрлэлийн тогтвортой бус онцлогийг харгалзан) байна.

☞ Бусад бүх төслийн хувьд: энэ аргын талаар батлагдсан аргачлалд өөрөөр заагаагүй бол эхний тооцоот хугацааны хувьд w<sub>УД</sub> = 0.5, w<sub>СД</sub> = 0.5 байх бөгөөд 2 дах болон 3 дах тооцоот хугацааны хувьд w<sub>УД</sub> = 0.25, w<sub>СД</sub> = 0.75.

☞ w<sub>УД</sub> + w<sub>СД</sub> = 1 үндсэн нөхцлийг хангасан өөр хувилбарыг ГЗ-аар хэлэлцүүлэн санал болгож болно. ТО ашиглах w<sub>УД</sub> + w<sub>СД</sub> –ийг утга тооцоот хугацааны хувьд тогтмол байх ёстой бөгөөд уг хугацааг сунгах тохиолдолд дахин өөрчилж болно.

**Хяналт, шинжилгээний аргачлал**

ҮД болон СД ялгаралтын факторын тооцоог ЦХМ-ТББ-д хүснэгтэн байдалд оруулан, цахилгаан хэлбэрээр хадгалж, хавсаргана. Ялгаралтын факторыг тооцоолоход ашиглагдсан бүх л мэдээллийг оруулсан байх ёстой. Үүнд:

☞ Сүлжээнд холбогдсон эрчим хүчний нэгж/станц бүрийн хувьд дараахь мэдээлэл:

⇒ Станц, түүний ашиглалтанд орсон өдөр, хүчин чадал (МВт), ашигласан түлшний төрөл, тухайн жилд үйлдвэрлэсэн нийт цэвэр цахилгаан эрчим хүчний хэмжээ, хэрэв боломжтой бол: тухайн жилд ашиглагдсан түлшний хэмжээг төрөл тус бүрийн тодорхой мэдээлэл. Энгийн ҮД болон энгийн тодотгосон ҮД аргыг ашигласан тохиолдолд тухайн станц/нэгж бага өртөгт/зайлшгүй ашиглагдах нөөц эсэх тухай мэдээлэл.

☞ Ашиглагдсан цэвэр калорийн утга, CO<sub>2</sub> ялгаралтын фактор, станцын ашигт үйлийн коэффициент, тодорхой хугацааны хувьд СД болон ҮД –д хамрагдсан станцууд болон энгийн тодотгосон ҮД аргыг ашигласан тохиолдолд у жилийн цаг тутамд үйлдвэрлэгдсэн ачааллын мэдээ (ихэвчлэн МВт)

☞ Түгээлтийн ҮД аргыг ашигласан тохиолдолд: төслийн станц сүлжээний цахилгаан эрчим хүчийг орлосон h цаг бүрийн хувьд дараахь мэдээлэл:

⇒ Сүлжээнд холбогдсон бүх станцуудын түгээлтийн дараалал/эрэмбэ, сүлжээний цахилгаан эрчим хүчний нийт эрэлт, төслийн үйл ажиллагаагаар нийлүүлсэн цахилгаан эрчим хүчний нийт хэмжээ, түгээлтийн эрэмбийн хамгийн эхний станцууд болон станц бүрийн цахилгаан үйлдвэрлэл, цаг тутмын түлшний хэрэглээний хэмжээ, болон тухайн цагийн туршид ашиглагдсан түлшний төрөл, хэмжээний мэдээлэл.

Эдгээр мэдээллийг сүлжээний СД болон ҮД ялгаралтын факторыг тооцоолоход ашигласан эрэмбийнх нь дагуу байрлуулан баримтжуулсан байх ёстой.

**ВОХ: Станцуудын үр ашгийн суурь фактор**

Хувилбар Б2-ийн дагуу энгийн ҮД-ийг тооцоолохдоо дараах хүснэгтэнд харуулсан үндсэн утгуудыг хэрэглэ.

		2000-с өмнө	2000-с дараа
Нүүрс	Ердийн үр ашигтай станц	37.0 %	39.0 %
	Супер үр ашигтай станц		45.0 %
	Ультра үр ашигтай станц		50.0 %
	Нүүрс хийжүүлэх буюу синтетик хийн станц		50.0 %
	Нүүрс болон биомассаар ажиллах станц	35.5 %	
	Нүүрс болон биомассаар ажиллах циклон горимт станц	36.5 %	40.0 %
	Нүүрс болон биомассаар ажиллах даралтат горим бүхий станц		41.5 %
Тос	Уурын турбин	37.5 %	39.0 %
	Нээлттэй цикл	30.0 %	39.5 %
	Холимог цикл	46.0 %	46.0 %
Хий	Уурын турбин	37.5 %	37.5 %
	Нээлттэй цикл	30.0 %	39.5 %
	Холимог цикл	46.0 %	60.0 %

## Хавсралт 6. Холимог биотүлшний хэрэглээ

Дараахь заавар нь биотүлш болон биотүлшний үйлдвэрлэл аль аль нь ЯББ авах эрхтэй бөгөөд уг үйлдвэрлэлийн шугамын дагуу давхар бүртгэл гарч болзошгүй аливаа төслийн үйл ажиллагааны хувьд ялгаралтыг бууралтыг нь давхар бүртгэсэн явдал гарахаас сэргийлэхэд зориулагдсан болно. [ГЗ 26 Х12]

### Энэ зааварт хамрагдах биотүлшний төслүүдийн төрөл

Малтмал түлшийг биотүлшээр орлуулан ЯББ авахаар завдаж буй ЦХМ төслийн аргачлалын саналууд нь дараахь нөхцлүүдийг хангасан төслийн үйл ажиллагаанд тавигдаж болно:

- ☞ Малтмал түлшийг биотүлшээр орлуулснаар ЯББ авахаар завдаж буй биотүлшний хэрэглэгчид (эцсийн хэрэглэгч).
- ☞ Биотүлшний үйлдвэрлэл эрхлэн ЯББ авахаар завдаж буй үйлдвэрлэгч нь :
  - ⇒ Биотүлш худалдан авсан бөгөөд төслийн хил хязгаарын дотор байрлах хэрэглэгчид;
  - ⇒ Биотүлшний хэрэглээний улмаас буурсан ялгаралтын хэмжээг төслийн үйл ажиллагаанд хамрагдсан хэрэглэгчдийн хэрэглээнд үндэслэн тогтоосон.

Зөвхөн биотүлшний үйлдвэрлэл эрхэлсний төлөө ЯББ авахаар завдаж буй, ө.х үйлдвэрлэсэн биотүлшний хэрэглээ талыг (эцсийн хэрэглэгчдийг) хамраагүй төслүүд нь ЦХМ төсөл гэж тооцогдохгүй гэдгийг ГЗ-өөс тодруулан анхааруулсан болно. [ГЗ 30 Рер, хэсэг14]

### Хавсралт I улсуудад биотүлш экспортлох

Хавсралт 1 орнуудад экспортолсон ямарваа биотүлшний үйлдвэрлэл ЦХМ-ийн хүрээнд хамрагдахгүй болно.

### Хяналт, шинжилгээ

- ◆ Энэ аргачлалд хэрэглэгчийн /эцсийн хэрэглэгч/ ашиглах малтмал түлшийг орлож буй биотүлшийн бодит хэрэглээний хэмжээг ямарваа эргэлзээгүйгээр магадлахад зориулагдсан хяналт шинжилгээ явуулах схемийг зохих элементийнх нь хамт / ө.х цахилгаан хэрэглээ/ тусгасан болно.
- ◆ Хяналт тавин шалгасан эцсийн хэрэглэгчийн хэрэглэсэн элементүүд нь биотүлшний үйлдвэрлэлтэй тохирч байх ёстойгоос гадна ялгаралтын бууралтыг тооцож, мэдээлэхэд ашиглагдана.
- ◆ Биотүлш хэрэглэгчдийн явуулсан төслийн үйл ажиллагааны аргачлал нь хэмжигдэхүйцээс гадна ЦХМ төсөлд хувь нэмэр оруулахуйц алдагдлын хэмжээг тодорхойлно.

Биотүлшний тариалалт, ургац хураалт болон боловсруулалт

- ◆ Биотүлшний үйлдвэрлэлд ашиглагдаж биомассын үйлдвэрлэлээс улбаатай ялгаралтын хэмжээг сайжруулсан биотүлшний төслийн үр дүнд ялгаралтын бууралт гарсан үед тооцвол зохино.
- ◆ Гэсэн хэдий ч, уг төсөл нь бүртгэгдсэн О/НС төслөөс эх сурвалжтай биомассыг хэрэглэж байгаагаа батлан харуулсан тохиолдолд (ө.х. Биомасс худалдан авах гэрээний дагуу), биомассын үйлдвэрлэлээс улбаатай ялгаралтыг тооцоолох шаардлагагүй болно.

**ЖИШЭЭ: Биотүлшний шаталт** [Үндэсний Хүлэмжийн Хийн Тооллого явуулах тухай шинэчлэн засварласан журам УӨЗГХК 1996: гарын авлага 1.33]

☞ Биомассын түлшийг шатааснаас ялгарах CO<sub>2</sub> хийг улсын нийт CO<sub>2</sub> хийн ялгаралтанд оруулахгүй.

## Хавсралт 7. Дэлхийн дулааралтын чадамж (ДДЧ) болон нүүрстөрөгч ялгаралтын фактор (НЯФ)

- ◆ Дэлхийн дулааралтын чадамж (ДДЧ) гэдэг нь хүлэмжийн хийн CO<sub>2</sub>-той жишсэн дулаан ялгаруулах харьцангуй чадамжийн хэмжүүр юм. Талуудын ашиглах ДДЧ нь УӨЗГХК-ын 2 дахь Үнэлгээний тайлан (“1995 УӨЗГХК ДДЧ-ийн утга”)–д заасан, 100 жилийн хугацаан дахь ХүХ-н нөлөөлөлд үндэслэн тогтоосон ДДЧ байна [ГБХ/1997/7/Н1, ху31 хэ3]. ДДЧ-ын утгыг 1-р тооцоот хугацааны явцад тогтмол байлгах боловч цаашид шинжлэх ухааны ололтуудад үндэслэн өөрчлөгдөж болно.
- ◆ Нүүрстөрөгч ялгаралтын фактор (НЯФ) гэж өгөдсөн эх үүсвэрээс ялгарах нүүрстөрөгч (эсвэл CO<sub>2</sub>)-ийн тухайн үйл ажиллагааны нэгжид ногдох тооцоолсон дундаж хэмжээг хэлнэ. Тухайн улс, эсвэл төсөлд холбогдолтой тодорхой мэдээлэл байхгүй буюу олоход хүндрэлтэй тохиолдолд л УӨЗГХК-ын суурь утгыг ашиглаж болохыг ГЗ-өөс зөвшөөрсөн. [Г325 Тай, para59]  
Мөн, УӨЗГХК-ын вэб хуудсанд 2006 оны 10-р сарын 24-д нийтлэгдсэн “Хүлэмжийн хийн үндэсний тооллогын талаарх УӨЗГХК-ын заавар-2006”-ыг энэ өдрөөс хойшхи хамгийн сүүлийн хувилбар гэж үзэхийг ГЗ шийдвэрлэсэн. [Г328 Тай, хэ68]

### Дэлхийн дулааралтын чадамж

Нэр	Химийн томъёо	ДДЧ	Нэр	Химийн томъёо	ДДЧ
CO <sub>2</sub>	CO <sub>2</sub>	1	HFC-23	CHF <sub>3</sub>	11,700
Метан *	CH <sub>4</sub>	21	HFC-236fa	C <sub>3</sub> H <sub>2</sub> F <sub>6</sub>	6,300
Азотын хүчил	N <sub>2</sub> O	310	HFC-143a	C <sub>2</sub> H <sub>3</sub> F <sub>3</sub>	3,800
Перфторт этан	C <sub>2</sub> F <sub>6</sub>	9,200	HFC-134a	CH <sub>2</sub> FCF <sub>3</sub>	1,300
Перфторт пентан	C <sub>5</sub> F <sub>12</sub>	7,500	HFC-134	C <sub>2</sub> H <sub>2</sub> F <sub>4</sub>	1,000
Перфторт гексан	C <sub>6</sub> F <sub>14</sub>	7,400	HFC-32	CH <sub>2</sub> F <sub>2</sub>	650
Гексафторт хүхэр	SF <sub>6</sub>	23,900	HFC-41	CH <sub>3</sub> F	150

Уур амьсгалын өөрчлөлт 1995: Уур амьсгалын өөрчлөлтийн шинжлэх ухаан, ху. 22, Уур амьсгалын өөрчлөлтийн талаарх Засгийн гадар хоорондын комисс, 1996.

### Эрчим хүчний хэмжих нэгжийн хөрвөлт

руу:	ТЖ	Гкал	Сая тжт	ГВтцаг
ээс:	Үржүүлэх:			
ТЖ	1	238.8	2.388 x 10 <sup>-5</sup>	0.2778
Гкал	4.1868 x 10 <sup>-3</sup>	1	10 <sup>-7</sup>	1.163 x 10 <sup>-3</sup>
Сая тжт	4.1868 x 10 <sup>4</sup>	10 <sup>7</sup>	1	11630
ГВтцаг	3.6	860	8.6x10 <sup>-5</sup>	1

Түлшний шаталтын CO<sub>2</sub>-н ялгаралт (2006 нийтлэл), ху.1.11, Олон улсын Эрчим хүчний Агентлаг, 2006.

### Нүүрстөрөгч ялгаралтын фактор

Малтмал түлш		CO <sub>2</sub> ялгаралтын фактор (кг/ТЖ)	Цэвэр илчлэг (ТЖ/Гг) Гг=1000тонн	CO <sub>2</sub> ялгаралтын фактор (тонн-CO <sub>2</sub> /тонн (Түлш))
Шингэн түлш	Газрын тос	73,300	42.3	3.101
	Хөдөлгүүрийн түлш	69,300	44.3	3.070
	Бусад керосин	71,900	43.8	3.149
	Хий/Дизель түлш	74,100	43.0	3.186
	Шингэрүүлсэн нефтийн хий	63,100	47.3	2.985
Хатуу түлш	Антрацит	98,300	26.7	2.625
	Чулуун нүүрс	96,100	18.9	1.816
	Хүрэн нүүрс	101,000	11.9	1.202
Хийн түлш	Байгалийн хий	56,100	48.0	2.693

Хүлэмжийн хийн үндэсний тооллогын талаарх УӨЗГХК-ын заавар, 2006, ху. 1.18-1.24, Уур амьсгалын өөрчлөлтийн талаарх Засгийн гадар хоорондын комисс, 2006.

[Нүүрстөрөгчийн исэлдлийн суурь фактор 1-тэй тэнцүү байна.] [CO<sub>2</sub>-н ялгаралтын фактор тонн-CO<sub>2</sub>/тонн (Түлш)-ыг энэ баримт бичигт тооцож гаргасан бөгөөд УӨЗГХК-ын зааварт өгөгддөггүй.]

Өмнөх хувилбарт орсон гол өөрчлөлтүүд (Хув. 4.0 / 2007 оны 11 сар)

Хуудас	Бүлэг	Өөрчлөлт
16	5. ЦХМ төсөлд тавигдах нөхцөл	“Бүтээгдэхүүнийг нь хэрэглэж/ашигласны улмаас ялгаралтын хэмжээ буурахад нөлөөлөх төслийн үйл ажиллагаа”-ийг нэмэн оруулав.
18	6. ТББ боловсруулах нь	“ТББ болон аргачлалтай холбоойтой маягтууд” шинэ хүснэгтийг нэмэн оруулав.
23	7-4. Шинэ аргачлал (ШАр)-ын санал өргөн мэдүүлэх журам	(13)-р алхам шинэчлэгдэн, бүхэлдээ өөрчлөгдөв.
26	7-6. Батлагдсан Аргачлал (БАр)-д тайлбар хүсэх журам	(1)-р алхам өөрчлөгдөв.
35	11-3. Бүртгэлийн хураамж	“Буурай хөгжилтэй улсуудад хэрэгжүүлэх ЦХМ-ийн төслүүдийг ямарваа бүртгэлийн хураамж болон захиргааны зардлаас чөлөөлнө” өгүүлбэрийг дунд нь нэмж оруулав.
41	15. ЯББ-ыг хуваарилалт	
42	16. Тооцоот хугацааг сунгах нь	(2)-р алхам өөрчлөгдөв.
44	17-1. ЦЖТ –ийн тодорхойлолт	“ГЗ хялбаршуулсан аргачлалыг баталсан тул сэргээгдэхгүй биомассыг сэргээгдэх биомассаар солих” хэсгийг арилгав.
52	18-3. Жижиг хэмжээний О/НС ЦХМ төслүүд	“Жижиг О/НС ЦХМ төслийн үйл ажиллагааны тодорхойлолт” хэсгийг шинэчлэв
65-66	Хавсралт 2. Аргачлалын зааврууд	Шинэ заавруудыг нэмэн, зарим хувилбаруудыг шинэчлэв.
67-73	Хавсралт 3. Батлагдсан аргачлалууд	Нийтэд нь шинэчлэв.



Япон улсын Байгаль орчны яам,  
Дэлхийн байгаль орчны товчоо,  
Уур амьсгалын өөрчлөлтийн бодлогын газар  
Япон улс, 100-8975, Токио, Чиёода-кү,  
Касүмигасеки, 1-2-2  
URL: <http://www.env.go.jp>



Дэлхийн байгаль орчны стратегийн хүрээлэн,  
Уур амьсгалын бодлогын төсөл / ЦХМ Хөтөлбөр,  
Япон улс, 240-0115, Канагава, Хаяама,  
Камияамагүчи, 2108-11  
EMAIL: [ЦХМ-info@iges.or.jp](mailto:ЦХМ-info@iges.or.jp)  
URL: <http://www.iges.or.jp/en/CDM/index.html>



Зүүн Хойд Азийн Эдийн засгийн  
судалгааны хүрээлэн,  
Япон улс, 950-0078, Нийгата хот  
Чүо-кү, Бандайжима 5-1,  
Бандайжима байр, 13 давхар  
URL: <http://www.erina.or.jp>



Ирээдүйн хөгжлийн хүрээлэн (ТББ)  
Монгол улс, Улаанбаатар-211213  
Төв шуудан, Ш/Х - 1711

© Байгаль орчны яам, Япон улс, 2007.

Тус баримт нь Япон улсын Байгаль орчны яам санхүүжүүлж, Дэлхийн байгаль орчны стратегийн хүрээлэн (IGES)-ээс нийтэлсэн ЦХМ-ын чадавхийг сайжруулах хөтөлбөрийн хэсэг мөн.

Энд агуулагдсан мэдээллийн үнэн зөвд нийтэлсэн өдрийн байдлаар итгэлтэй хэдий ч, байж болзошгүй алдаа болон орхигдуулсан мэдээллийн хувьд зохиогч, нийтлэгчид эрх зүйн аливаа хариуцлага хүлээхгүй.

Тус баримтын англи хэлнээс монгол хэлэнд хийсэн орчуулгыг Япон улсын Зүүн Хойд Азийн Эдийн засгийн судалгааны хүрээлэн (ERINA), Монгол улсын Ирээдүйн хөгжлийн хүрээлэн (IFF), хэвлэлтийг Монгол улсын Байгаль, орчны яам тус тус ивээн тэтгэв.

Үнэ төлбөргүй тараагдана.